



GOBI

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

Ж И Л И Й Н 2018
Т А Й Л А Н

● АГУУЛГА

5-15

● МАНАЙ КОМПАНИ

Компанийн ерөнхий танилцуулга
Эрхэм зорилго, үнэт зүйлс, үйл ажиллагааны зарчим
Түүхэн замнал
ТУЗ-ийн даргын мэндчилгээ
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

17-33

● 2018 ОНД БИД

Бидний амжилтууд
Онцлох үйл явдлууд
Статистик мэдээ
2018 оны санхүүгийн үр дүн, 2019 оны төлөвлөгөө
Хөрөнгө оруулалт
Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ технологи, хөгжүүлэлт

35-49

● БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ноолуурын салбар
Дотоод зах зээл
Гадаад зах зээл
Бүтээгдэхүүн
Брэндүүд
Коллекциуд
Бидний харилцагчид

51-73

● КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа
Засаглалын өөрийн үнэлгээний үр дүн
Хувьцаа эзэмшигчид
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Төлөөлөн удирдах зөвлөл
Төлөөлөн удирдах зөвлөл болон хороодын 2018 оны ажлын тайлан
Дотоод аудитын хэлтэс
Компанийн бүтэц
Компанийн эрх бүхий албан тушаалтнууд
Хөрөнгийн зах зээл ба компанийн хувьцаа
Ногдол ашиг

75-83

● ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Тогтвортой хөгжил
Нийгмийн хариуцлага
Эрсдэлийн удирдлага
Чанарын удирдлага

85-143

● ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хараат бус аудитор
Говь ХК болон түүний охин компаниудын нэгтгэсэн санхүүгийн тайлан болон хараат бус аудиторын тайлан
Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх тодорхойлолт



МАНАЙ
КОМПАНИ


КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА



- Компанийн оноосон нэр: ГОВЬ хувьцаат компани
- Үйл ажиллагааны чиглэл: Ямааны ноолууранд цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
- Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК

Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК
Утас: (976)-70139977
Факс: (976)-70143081
И-мэйл: info@gobi.mn
Вэб сайт: www.gobi.mn
Фэйсбүүк: GobiCashmere
Онлайн дэлгүүр: www.gobicashmere.com
- Компанийн удирдлага: ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА
Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН
- Үүсгэн байгуулагдсан огноо: 1981 оны 9 сарын 5-ны өдөр
- Ажилчдын тоо: 2,113
- Үйлдвэрийн хүчин чадал: 900 тонн түүхий ноолуур боловсруулах
500 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас хийх
1,000,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх
1,100,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх
162,000 ширхэг ноолууран пальто болон пиджак үйлдвэрлэх
- Дэлгүүрийн тоо: Дотоод
Улаанбаатар хот 5
Дархан хот 1

Гадаад
Салбар дэлгүүр 5
Франчайз дэлгүүр 61



ЭРХЭМ ЗОРИЛГО

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнэтэй байгууллага байна.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС



- Компанийнхаа төлөө зүрх сэтгэл, бүхий л авьяас чадвараа дайчлан ажиллаж буй чадварлаг мэргэжилтэн, ажилтнууд
- Бидэнтэй үргэлж хамт байдаг нийт хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд
- Дэлхийд хосгүй Монгол ноолуур
- Дэлхийн дэвшилтэт технологийн үйлдвэр

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ


- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль, дүрмийг чандлан сахиулна
- Хүний эрхийг дээдэлнэ
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна

УРИА ҮГ

Дэлхийд танигдсан Монгол брэнд



ТҮҮХЭН ЗАМНАЛ



UNIDO-ийн төслийн хүрээнд ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах туршилтын үйлдвэр ашиглалтанд оров.

Ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэрийн машин тоног төхөөрөмжийн угсралт, тохируулгын ажлыг гүйцэтгэн, технологийн шугамыг ашиглалтанд хүлээн авч, Монгол-Японы хамтын ажиллагааны хүрээнд дэх анхны байгууламж Говь үйлдвэр үүд хаалгаа нээв.

Олон улсын ISO-9000 стандартыг үе шаттайгаар нэвтрүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 98 хувийг экспортлон Олон улсын чанарын цом, гэрчилгээг авсан Монгол улсын анхны үйлдвэр болов.

Монголд анх удаа ноос ноолууран хөнжил, ноолууран давуу, драп, нарийн номерын ээрмэл утас үйлдвэрлэх "Говь-2" үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авав.

Утас будах технологи нэвтрүүлэв. Орчин үеийн компьютерийн системд холбогдсон STOLL-330 сүлжих машиныг суурилуулав.

Япон улсын Засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт 5.0 тэрбум иенийн буцалтгүй тусламж олгож, Улаанбаатар хотноо ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр байгуулах тухай Монгол-Японы Засгийн газрын хэлэлцээр байгуулав.


Компьютерийн автомат удирдлага бүхий Япон улсын SET-092 сүлжих машиныг үйлдвэрт суурилуулав.

Монгол Улсын Засгийн газрын Өмч Хувьчлалын Комиссын тогтоолоор Говь УУГ-ыг Говь ХК болгон зохион байгуулж, МХБ-д бүртгүүлэн, нийт дүрмийн сангийн 25.1% буюу 1,919,061 ширхэг хувьцаа нь хөрөнгийн биржээр арилжаалагдав.

Гадаад зах зээлээ өргөжүүлэн Япон улсад "Алтай", Бельги улсад "Gobi Europe", АНУ-д "Gobi-USA" зэрэг охин компаниуд байгуулж, дэлхийн 30 гаруй оронтой түншийн харилцаа тогтоов.

Говь компанийн төрийн өмчлөлд байсан 73.45%-н хувьцааг "ЭФ СИ АЙ" ХХК Олон улсын нээлттэй дуудлага худалдаагаар худалдан авснаар Говь ХК хувийн эзэмшилд бүрэн шилжив.





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн амар мэндийг эрэн мэндчилье. Говь ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны үр дүнд, амжилт ололт болон цаашид сайжруулан хөгжүүлэх ажлуудаа тайлагнах хариуцлагатай цаг дахин ирлээ.

Улиран өнгөрсөн жилд ТУЗ, гүйцэтгэх удирдлагын баг болон ажилтнуудынхаа хамтын хүчин чармайлтаар Говь ХК "Шилдэг хувьцаат компани"-аар шалгарч, үндэсний том үйлдвэрлэгч, салбартаа тэргүүлэгчийнхээ манлайллыг улам бүр бэхжүүлж чадлаа.

Бид сайн засаглалын зарчмуудыг баримтлан үйлдвэрлэлийн өндөр бүтээмж, үр ашигт байдал, тогтвортой хөгжлийн стратегийг чиг болгон ажилласны үр дүнд компанийн зах зээлийн үнэлгээ 260.5 тэрбум төгрөг болж 2017 онтой харьцуулахад 43.5 хувиар өсч, цэвэр ашиг 17.8 тэрбум төгрөгт хүрчээ. Мөн нэгж хувьцааны жигнэсэн дундаж ханш өмнөх оноос 61.4 хувийн өсөлттэй байлаа.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2018 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 6.8 төгрөг буюу цэвэр ашгийн 30 хувь болох нийт 5.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ 3 дахин өссөн үзүүлэлт юм.

2018 онд бидний хувьд гадаад зах зээлээ тэлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр хичээн ажилласны үр дүнд борлуулалтаа 39%-иар өсгөж, бизнес төлөвлөгөөний зорилтуудаа амжилттай биелүүлж чадсан урам зориг, эрч хүчээр дүүрэн жил байлаа.

Энэ завшааныг ашиглан 2018 онд дэвшүүлсэн зорилго зорилтондоо хүрэхийн тулд хичээл зүтгэлтэй, бүтээлч ажилласан компанийн удирдлагууд болон нийт ажиллагсдадаа талархал дэвшүүлье.

Та бүхэнд өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Д.ГЭРЭЛМАА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

"Дэлхийд танигдсан Монгол брэнд" уриатай Говь ХК нь 1981 онд Монгол улсын ууган үйлдвэрүүдийн нэг Говь комбинат нэртэйгээр анх үүсгэн байгуулагдсан цагаасаа Монгол улсынхаа эдийн засаг, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсаар ирлээ. Эдүгээ манай компани үүсгэн байгуулагдаад 38 дахь жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа бөгөөд түүхэн энэ жилүүдэд байгууллагын маань үе үеийн удирдлага, хамт олны хүчин зүтгэл, хөдөлмөрийн үр дүнд улам бүр өргөжин тэлж, улсын хэмжээнд нэр хүндтэй шилдэг компани болон тодорсныг энд цохон тэмдэглэхэд таатай байна.

Говь ХК нь 2007 онд анх хувьчлагдахад нийт хөрөнгийн хэмжээ 27 тэрбум байсан бол эдүгээ 249 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, жилд 173 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, өнгөрөгч онд 384 ажлын байрыг шинээр бий болгон, улмаар 2,100 гаруй хүнийг ажлын байраар хангасан, улсын төсөвт жилд 28 гаруй тэрбум төгрөгийн татвар, хураамж төвлөрүүлсэн үндэсний хэмжээний томоохон компани болоод байна.

Бид 2018 онд Италийн Bigagli мөлхөө ээрэх машиныг ээрмэлийн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, сүлжмэлийн бүх утсыг мөлхөө ээрэх машинаар ээрдэг болсноор бүтээгдэхүүний чанарт онцгой дэвшлийг гаргалаа. Мөн ноолууран пальтоны борлуулалтаар дэлхийд тэргүүлэх зорилгоо амжилттай биелүүлснээс гадна ноолууран пиджакны масс үйлдвэрлэл явуулахад зориулан Герман болон Турк улсын тоног төхөөрөмжүүдийг оёмолын үйлдвэртээ нэвтрүүлэн, дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц загвар, чанар, технологийн шаардлага хангасан ноолууран пиджакны үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлж чадлаа. Түүнчлэн бид ноолууран даавууны хөгжүүлэлтийг тасралтгүй эрэлхийлэн, сайжруулж хамгийн нимгэн ноолууран даавуугаар хослол үйлдвэрлэж эхлээд байгааг дуулгахад таатай байна.

Өнгөрөгч онд бид Засгийн газрын ордны зүүн талд байрлах Галлериа Улаанбаатар төвд шинэ салбар дэлгүүрээ нээж, дотоод болон гадаадын худалдан авагч нарт дэлхийн стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

Миний бие тус компанийн гүйцэтгэх захирлын хувиар Говь ХК-ийг зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, улс орныхоо эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ХАРИЛЦАГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, АЖИЛТНУУДЫНХАА САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ хөнгөн үйлдвэрлэлийн салбарын жишиг компани байлгахыг эрхэм зорилгоо болгон ажиллах болно.

Бидний ололт амжилтыг цаг үргэлж дэмжиж байдаг та бүхэндээ сайн сайхныг хүсч, цаашдын ажил үйлст тань өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БААТАРСАЙХАН



2018
ОНД БИД

БИДНИЙ АМЖИЛТУУД



ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА

4 сарын 27-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ТОП-100" ААН-ийг шалгаруулах ёслол болж, Говь ХК 23 дугаар байранд шалгарлаа. Мөн ажилтнуудын тоогоор 6 дугаарт жагсав.



ҮНДЭСНИЙ БАХАРХАЛТ БҮТЭЭГДЭХҮҮН

10 сарын 17-21-ний өдрүүдэд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санаачилгаар Монгол Улсад хөнгөн аж үйлдвэрийн салбар хөгжсөний 85 жилийн ойг угтан зохион байгуулсан "Монгол экспорт экспо-2018" нэгдсэн арга хэмжээнээс Говь ХК-ийн хатгамалтай пальто, пиджак "ҮНДЭСНИЙ БАХАРХАЛТ БҮТЭЭГДЭХҮҮН"-ээр шалгарав.

ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛТАЙ БАЙГУУЛЛАГА

10 сарын 10-11-ний өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газраас гамшгийн эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх зорилгоор улс орон даяар "ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛ"-ын арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд Говь ХК оролцон Хан-Уул дүүргийн нийт 93 байгууллагуудыг манлайлан "ДҮҮРЭН ХАНГАЛТТАЙ" үнэлгээ авч өргөмжлөлөөр шагнуулав.



ШИЛДЭГ ХУВЬЦААТ КОМПАНИ

12 сарын 13-ны өдөр Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал гардуулах GRAND BULL AWARDS ёслол болж, хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын 2014-2018 оны ололт, амжилтуудыг дүгнэн, шилдгийн шилдгүүдээ тодруулсан бөгөөд Говь ХК "ШИЛДЭГ ХУВЬЦААТ КОМПАНИ"-аар шалгарав.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



ДЮССЕЛЬДОРФ ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Дюссельдорф хотод 130 м.кв талбай бүхий франчайз дэлгүүрээ нээв.

2.10

3.09

4.17



ИСТАНБУЛ ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотод 260 м.кв талбай бүхий франчайз дэлгүүрээ нээв.

4.30



АНХАН ШАТНЫ ҮЙЛДВЭРИЙН ШАВ ТАВИХ ЁСЛОЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Төв аймгийн Сэргэлэн сумын 14.7 га газарт шинээр барихаар төлөвлөж буй Анхан шатны цогц үйлдвэрийн шав тавих ёслолыг амжилттай зохион байгуулав.


6.14

6.15



ХАЙЛААР ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

Өвөр Монголын Өөртөө Засах Орны хурдацтай хөгжиж буй хотуудын нэг болох Хайлаар хотод 160 м.кв талбай бүхий франчайз дэлгүүрээ нээв.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх "Мираж" гэр ресторанд зохион байгууллаа. Хуралд нийт 6,946,873 саналын эрхтэй 210 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирж, хурлын ирц 89.05% байв. Хурлаар ТУЗ-өөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт, Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудал, ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудал болон ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлуудыг хэлэлцэж баталснаас гадна 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.



ТАЛАРХЛЫН ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2017 онд үйлдвэрийн дээвэрт гарсан галын аюулыг бид хөдөлмөрч хамт олон болон сайхан сэтгэлт Монгол түмнийхээ дэмээр давж гарч үйлдвэрийнхээ үйл ажиллагааг богино хугацаанд сэргээж чадсан тул жилийн дараа буюу энэ оны 6 сарын 14-нд галын ослын үед халуун сэтгэлийн гараа сунган сэтгэл санаа болон эд материалын тусламж үзүүлсэн төрийн болон хувийн өмчит аж ахуй нэгж байгууллага, хувь хүмүүсийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.

ХӨХ ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод 80 м.кв талбай бүхий франчайз дэлгүүрээ нээв.



8.18

9.06

10.03

ГАЛЛЕРИА УЛААНБААТАРТ ШИНЭ САЛБАР ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

Хотын төв цэгт буюу Засгийн газрын ордны зүүн талд байрлах Галлериа Улаанбаатар төвд 1,428 м.кв талбай бүхий шинэ салбар дэлгүүрээ нээж Улаанбаатар хотын жишиг үйлчилгээний стандарт бүхий дэлгүүрээр хэрэглэгчиддээ үйлчилж эхэллээ.



10.15

11.01

ЧИКАГО ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

Америкийн Нэгдсэн Улсын Иллинойс мужийн Чикаго хотод 300 м.кв талбай бүхий франчайз дэлгүүрээ нээв.



11.15



СИ ЯНГ ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Си Янг хотод 100 м.кв талбай бүхий франчайз дэлгүүрээ нээв.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх "Мираж" ресторанд зохион байгууллаа. Хуралд нийт 6,921,425 саналын эрхтэй 45 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирж, хурлын ирц 88.72% байсан бөгөөд компанийн хувьцааг 100 хувааж, дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг 99.99% саналаар батлав.



ҮЙЛДВЭРИЙН ШИНЭ ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА

Үйлдвэрийн барилгын дэргэд 6,690 м.кв талбай бүхий 2 давхар өргөтгөлийн барилгыг ашиглалтад орууллаа. Тус барилга руу Сүлжмэлийн үйлдвэр болон Оёмолын үйлдвэрүүд шилжин оров.

СТАТИСТИК МЭДЭЭ

/2017 оны гүйцэтгэлтэй харьцуулав/



39% ↑

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
173.4 ТЭРБУМ ТӨГРӨГ



1.5% ↑

ЦЭВЭР АШИГ
17.8 ТЭРБУМ ТӨГРӨГ



50% ↑

ДОТООД БОРЛУУЛАЛТ
111.8 ТЭРБУМ ТӨГРӨГ



23% ↑

ГАДААД БОРЛУУЛАЛТ
61.6 ТЭРБУМ ТӨГРӨГ



40% ↑

ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР
28.1 ТЭРБУМ ТӨГРӨГ



177% ↑

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
29.5 ТЭРБУМ ТӨГРӨГ



44% ↑

КОМПАНИЙН ҮНЭЛГЭЭ
260.5 ТЭРБУМ ТӨГРӨГ




22% ↑

АЖИЛТНУУДЫН ТОО
384 ХҮНЭЭР НЭМЭГДЭВ




4% ↑

ЭЭРМЭЛ УТАС
367 ТОНН



41% ↑

СҮЛЖМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН
800 МЯНГАН ШИРХЭГ



56% ↑

НЭХМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН
478 МЯНГАН ШИРХЭГ



45% ↑

ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮН
82 МЯНГАН ШИРХЭГ

НИЙТ АЖИЛТНУУДЫН ТОО

2,113



ЗАХИРГАА-259



ҮЙЛДВЭР-1,581




БОРЛУУЛАЛТ-273

АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА




28%



72%

АЖИЛТНУУДЫН НАСЖИЛТ



Хүүхэд асрах чөлөөтэй -168



Гадаад, дотоод сургалтад давхардсан тоогоор хамрагдсан -4,326



Төрийн дээд одон медаль, компанийн шагналаар шагнуулсан -129

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



ДЭЭД -840



БҮРЭН ДУНД -726



ТУСГАЙ ДУНД -547

2018 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН, 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2017 он		2018 он				2019 он		
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт		Төлөвлөгөө биелэлт %	Төлөвлөгөө	Өмнөх оноос өсөлт	
					тоо	хувь			тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	124,425	150,445	173,439	49,014	39%	115%	239,905	66,466	38%
Дотоод борлуулалт	сая.төг	74,564	96,545	111,864	37,300	50%	116%	157,405	45,541	41%
Гадаад борлуулалт	сая.төг	49,861	53,900	61,575	11,714	23%	114%	82,500	20,925	34%
Экспорт	мян.USD	20,424	22,000	24,713	4,289	21%	112%	30,000	5,287	21%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	73,881	93,728	102,148	28,267	38%	109%	143,137	40,989	40%
НИЙТ АШИГ	сая.төг	50,544	56,717	71,292	20,748	41%	126%	96,769	25,477	36%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	26,328	32,176	41,852	15,525	59%	130%	58,112	16,260	39%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	774	-	6,191	5,417	699%	0%	2,968	-3,223	-52%
Татварын өмнөх ашиг	сая.төг	23,442	24,541	23,248	-194	-1%	95%	35,688	12,439	54%
ЦЭВЭР АШИГ	сая.төг	17,503	18,856	17,764	261	1%	94%	27,551	9,787	55%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	100,983	125,904	144,000	43,017	43%	114%	204,218	60,218	42%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.81	0.84	0.83	0.02	2%	99%	0.85	0.02	3%
ҮЙЛДВЭРЛЭЛТ										
Сүлжмэл	мян.шир	567	800	800	233	41%	100%	938	138	17%
Нэхмэл	мян.шир	306	400	478	172	56%	119%	522	44	9%
Оёмол	мян.шир	57	73	82	25	45%	112%	90	7	9%
Үүнээс: Пальто	мян.шир	41	60	56	15	37%	94%	66	9	17%
Пиджак	мян.шир	2	9	8	6	306%	89%	13	4	50%
Ээрмэл	тонн	352	407	367	15	4%	90%	317	-51	-14%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	1,729	1,956	2,113	384	22%	108%	2,164	51	2.4%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	71,964	76,915	82,082	10,118	14%	107%	110,862	28,780	35%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	10,657	17,005	29,476	18,819	177%	173%	13,060	-16,416	-56%

2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1

Компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 38% өсгөнө.

2

Бараа материалын үлдэгдлийн удирдлагыг сайжруулж, үлдэгдлийг 40% бууруулна.

3

Нийт ажилтны тоог тогтвортой түвшинд байлгаж, чанар болон бүтээмжийг сайжруулахад тусгайлан анхаарах бөгөөд үйлдвэрлэлийн үйл явцад "Toyota production system"-г нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4

Галлериа Улаанбаатар салбарын борлуулалтыг 2019 онд Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрийн борлуулалтын орлогод дүйцэхүйц болгох бодлого баримталж ажиллана.

5

Олон улсын чанарын ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх бөгөөд, Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандарт болон Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх бэлтгэлийг хангана.

6

Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын шинэ бодлого боловсруулан ажиллана.


7

Глобал брэндиг хөгжүүлэхэд баримтлах бодлогын суурийг тавина.


8

Хослолын зориулалттай нарийн даавууны үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлж, өндөр чанартай, загварлаг бүтээгдэхүүнийг массаар үйлдвэрлэнэ.


БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ




БОРЛУУЛАЛТ



ЦЭВЭР АШИГ




ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ





ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

тэрбум төгрөг




2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 86.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2018 онд 29.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 12.8 тэрбум төгрөг буюу 43%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 15.0 тэрбум төгрөг буюу 51%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 1.7 тэрбум төгрөг буюу 6%-ийг бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна.


- Сүлжмэлийн үйлдвэр /6.3 тэрбум төгрөг/
- Оёмолын үйлдвэр /2.2 тэрбум төгрөг/
- Нэхмэлийн үйлдвэр /1.2 тэрбум төгрөг/
- Ээрмэлийн үйлдвэр /3.6 тэрбум төгрөг/
- Анхан шатны үйлдвэр /1.7 тэрбум төгрөг/



- Үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж /15.0 тэрбум төгрөг/
- Барилга /12.8 тэрбум төгрөг/
- Бусад /1.7 тэрбум төгрөг/



- Галлери Улаанбаатар дэлгүүрийн барилга /6.4 тэрбум төгрөг/
- Үйлдвэрийн өргөтгөлийн барилга /5.3 тэрбум төгрөг/
- Бусад барилга байгууламж /1.1 тэрбум төгрөг/



- Тавилга, компьютер, биет бус хөрөнгө /1.3 тэрбум төгрөг/
- Тээврийн хэрэгсэл /0.3 тэрбум төгрөг/
- Бусад /0.1 тэрбум төгрөг/



ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, ХӨГЖҮҮЛЭЛТ



АНХАН ШАТНЫ ҮЙЛДВЭР

2017 оноос эхлэн Самнах дамжлага дээр Хятадын шинэ загварын самнах машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлж туршсан. Шинэ машин үйлдвэрлэлд нэвтрүүлснээр 4 дахин эрчим хүч хэмнэх, ажиллах хүчийг 40% хэмнэх, чанарын үл тохирлыг 50% бууруулах, хаг хогны агууламжийг багасгах зэрэг сайжруулалт бий болсон тул энэ онд нэмэлтээр 5 шугам суурилуулсан.

ЭЭРМЭЛИЙН ҮЙЛДВЭР

Ээрэх дамжлага дээр Италийн Bigagli мөлхөө ээрэх машиныг үйлдвэрлэлд шинээр нэвтрүүлсэн. Ингэснээр утасны даац, чанарыг сайжруулахаас гадна бүтээгдэхүүнд бөөсрөлт үүсгэхгүй байх зэрэг үр дүн гарсан. Мөн Япон улсын Muratec шилжүүлэн ороох машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн сүлжмэлийн бүх утсыг мөлхөө ээрэх машинаар ээрч эхэлсэн.



НЭХМЭЛИЙН ҮЙЛДВЭР

Ноолууран пальто болон пиджакны үйлдвэрлэл, борлуулалтаар дэлхийд тэргүүлэх зорилтын хүрээнд пальтоны зориулалттай зузаан драп болон 100% ноолууран утсаар хослолын зориулалттай нарийн даавуу, 70% ноолуур болон 30% торгоны холиотой утсаар пиджакны зориулалттай даавуу зэргийг тус тус нэхэж туршин, ноолууран даавуу драпны хөгжүүлэлтүүдийг амжилттай хийн масс үйлдвэрлэл хийж эхэлсэн.



СҮЛЖМЭЛИЙН ҮЙЛДВЭР




Сүлжмэлийн үйлдвэрийн оёх дамжлага дээр Италийн Complett K&S үйлдвэрийн шидээсний машиныг нэвтрүүлж кеттель болон шидээсний машиныг хослуулан хэрэглэж эхэлснээр ажилбарын урт болон хугацааг хэмнэхээс гадна үйлдвэрлэлийн бүтээмжийг 72% өсгөсөн.



Японы SHIMA SEIKI MACH2XS оёдолгүй сүлжих 10 ширхэг машиныг шинээр ашиглалтад оруулсан. Энэхүү машин нь бүтээгдэхүүнийг бүтнээр нь сүлжиж гаргахаас гадна цамцны захыг өөрөөсөө сүлжиж гаргах онцлогтой юм.

ОЁМОЛЫН ҮЙЛДВЭР

2018 онд дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц загвар, чанар, технологийн шаардлага хангасан ноолууран пиджак үйлдвэрлэх зорилгын хүрээнд эмэгтэй пиджак үйлдвэрлэхэд зориулсан Герман улсын Indupress брэндийн хэлбэржүүлэгч индүү болон эрэгтэй пиджак үйлдвэрлэхэд зориулсан Турк улсын Malkan Kft брэндийн хэлбэржүүлэгч индүү зэрэг тоног төхөөрөмжүүдийг суурилуулан, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж масс үйлдвэрлэлийг эхлүүлсэн.



ТОЁОТА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СИСТЕМ

Тоёота Үйлдвэрлэлийн Систем (Toyota Production System)–г үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр Японы мэргэжилтэн Хори Жүнжи-тэй хамтран ажиллаж, үйлдвэрийн ээлж зохион байгуулалтыг сайжруулах, дамжлага дундын үлдэгдлийг бууруулах, машин тоног төхөөрөмжийг бүтээмж өндөртэйгөөр байрлуулах, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг илүү боловсронгуй болгох зэрэг арга барилын талаар туршлага солилцон, зөвлөгөө авч хэрэгжүүлэн ажилласан.

Мөн компанийн хэлтэс, нэгж бүр үйл ажиллагаандаа Кайзен системийг нэвтрүүлэн ажилтан бүр бүтээмжээ нэмэгдүүлэх дээр санал санаачилга гарган ажилласан.





БИДНИЙ
ҮЙЛ АЖИЛЛАГАА


НООЛУУРЫН САЛБАР

САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Монгол улсад 2018 онд 27.3 сая тоо толгой ямаан сүрэг тоологдсон нь өмнөх онтой ижил үзүүлэлттэй байлаа. Манай улс 2018 онд 9,500 тонн ноолуур бэлтгэсэн нь өмнөх оноос 1% өсөлттэй байсан бөгөөд дэлхийн түүхий ноолуурын 48%-ийг хангаж байна. Харин ноолуурын дундаж үнэ 105,000 төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 32% өссөн үзүүлэлттэй байсан бөгөөд ноолуурын зах зээлийн хэмжээ 1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 35% өсөлтийг үзүүлээ.

Сүүлийн 5 жилийн Монгол улсын ноолуурын салбарын тоон мэдээлэл:

Ямааны тоо толгой /сая тоо толгой/




Ноолуур бэлтгэл /тонн/



Ноолуурын дундаж үнэ /мян.төг/



Ноолуурын зах зээл /тэрбум.төг/



“НООЛУУР” ХӨТӨЛБӨР

Монгол улсын засгийн газраас Ноолуурын салбарыг тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт тооцон дэмжих зорилгоор Хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрт тусгагдсан хэд хэдэн ажлуудыг 2018 оноос хэрэгжүүлж эхэллээ. Үүний томоохон илрэл нь Монгол улсын засгийн газраас “Ноолуур” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан 2018 оны 2-р сард батлуулсан явдал байв. Энэхүү хөтөлбөрийг 2018-с 2021 оны хооронд 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд Монгол улсын ноолууран бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэн боловсруулалтын төвшинг нэмэгдүүлж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой юм.


“Ноолуур” хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэгийн нөхцөлийг сайжруулан, татвар, санхүүгийн оновчтой дэмжлэг үзүүлснээр түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэж, ноолуурын салбарт одоо байгаа 5,000 гаруй ажлын байрыг тогтвортой хадгалж, 3,600 гаруй ажлын байрыг шинээр бий болгон, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээг 5.7 дахин өсгөх зэрэг эерэг үр дүн гарах боломжтой.



Дэлхийн түүхий ноолуурын хэрэгцээний 48%-ийг Монгол Улс хангаж байна.

ОЛОН УЛСЫН НООЛУУРЫН САЛБАР


Дэлхийн хүн амын тоо /тэрбум/



Дэлхий нийт 7.7 тэрбум хүн амтай бөгөөд үүнээс хүйтэн сэрүүн бүсэд амьдарч байгаа буюу ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн зорилтот зах зээлд 1.5 тэрбум хүн амьдарч байна. Энэ нь дэлхийн нийт хүн амын 19%-ийг эзэлж байна.

- Халуун, дулаан бүс /6.2 тэрбум/
- Хүйтэн сэрүүн бүс /1.5 тэрбум/


Олон улсын ноолуурын зах зээл /тэрбум ам.доллар/




Олон улс дахь ноолуурын салбарын нийт зах зээлийн хэмжээ 2018 онд 3.2 тэрбум ам.доллар* байсан бөгөөд 2025 он гэхэд 4.2 тэрбум ам.долларт хүрч, жил бүр дунджаар 3.86 хувиар** өснө гэж тооцоолж байна.

*HTF Market Intelligence компанийн судалгаа
**Aurum Partners ХХК-ийн “Говь ХК-ийн Азийн Хөгжлийн Банкнд зориулсан судалгааны тайлан” 2018 оны 1 сар

Ноолууран бүтээгдэхүүн хэрэглэгч гол улсууд



Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тэргүүлэгч компаниуд



Эх сурвалж: Дэлхийн банкны судалгаа 2016 он

Олон улсын зах зээлд ноолууран бүтээгдэхүүн хэрэглэгч гол улсууд дотроос Хятад, АНУ, Европын орнууд дэлхийн ноолуурын зах зээлийн 75%-ийг эзэлж байна. Харин Говь брэндийн хувьд дэлхийн зах зээлд ноолууран бүтээгдэхүүний борлуулалтаараа 2.2%-ийг эзэлж байна.

Иймд Говь ХК-ийн хувьд, цаашлаад Монгол улсын хувьд ноолууран эцсийн бүтээгдэхүүний загвар дизайн, чанар, үйлдвэрлэл дээрээ дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц сайжруулалтуудыг хийн, экспортын хэмжээгээ улам бүр нэмэгдүүлэн гадаад зах зээл рүү чиглэсэн үйл ажиллагааг шат дараатайгаар эрчимтэй хийвэл дэлхийн ноолуурын зах зээлд бидэнд том боломжууд нээлттэй байна.

ДОТООД ЗАХ ЗЭЭЛ

↑ **50%**


2018 онд дотоод борлуулалт 111.9 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 50% өсөлттэй байсан.

Дотоод зах зээлд эзлэх хувь



Гадаад худалдан авагч-50%

Дотоод худалдан авагч-50%



Дотоод борлуулалтыг мөнгөн дүнгээр нь аваад үзвэл 50%-ыг монгол худалдан авагчид, харин 50%-ыг гадаад худалдан авагчид буюу жуулчдын худалдан авалт эзэлж байна. Говь ХК-иас худалдан авалт хийсэн нийт жуулчдын 66.4%-ыг Солонгос болон Хятад улсын жуулчид эзэлж байна.

↑ **13%**

МОНГОЛ УЛСАД ИРСЭН НИЙТ ЖУУЛЧИД
529.4 мянган хүн

↑ **35%**

ГОВЬ БРЭНДИЙН ДЭЛГҮҮРЭЭР ҮЙЛЧЛҮҮЛСЭН ЖУУЛЧИД
111.5 мянган хүн

↑ **35%**

ЖУУЛЧДЫН ХУДАЛДАН АВАЛТЫН ДҮН
51.2 тэрбум төгрөг

2018 онд Монгол улсад зочилсон нийт жуулчдын тоо өмнөх оноос 13% өсч 529.4 мянгад хүрсэн бөгөөд Говь ХК-иас бүтээгдэхүүн худалдан авсан гадаад жуулчдын тоо 35% өссөн. Түүнийг дагаад жуулчдын худалдан авалтын дүн 35% өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь гадаадаас Монгол улсад ирж буй жуулчдын тоо компанийн борлуулалтад шууд нөлөөлдөг гэдгийг илэрхий харуулж байна. Цаашид аялал жуулчлалын салбарын хөгжил, өсөлт нь Говь ХК төдийгүй дотоодын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд борлуулалтаа өсгөхөд маш том түлхэц болно. Говь ХК-ийн хувьд ч гэсэн энэхүү боломжийг ашиглан жуулчдыг татах, үйлчилгээний чанар стандартаа сайжруулах арга тактикийг борлуулалтын стратегидаа суулган ажиллаж байна.

ШИНЭЭР НЭЭГДСЭН ДЭЛГҮҮР



ГАЛЛЕРИА УЛААНБААТАР САЛБАР

2018 оны 10 сарын 15-ны өдөр Улаанбаатар хотын зүрхэн цэгт буюу Засгийн газрын ордны зүүн талд баригдсан Галлериа Улаанбаатар төвийн 1 болон 2 дугаар давхарт 1,428 м.кв талбай бүхий шинэ салбар дэлгүүрээ нээв. Улмаар хотын тансаг зэрэглэлийн бүсэд борлуулалтын сувгаа тэлэн, дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээний стандарт бүхий дэлгүүрээр хэрэглэгчиддээ үйлчилж эхэллээ.


2018 ОНЫ ДЭЭД АМЖИЛТ



1 өдөрт **1.7** тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн /11 сарын 23/



1 өдөрт **655** ширхэг пальто борлуулсан /11 сарын 23/



Black friday хямдралаар 4 өдөрт **4.8** тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн /11 сарын 23-26/


2019 ОНД БИД

Борлуулалтын сувгуудынхаа үр ашгийн тооцооллыг хийсний үндсэн дээр Улсын их дэлгүүр салбар болон Өргөө зочид буудал салбар дэлгүүрээ хаан, цаашид Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүр, Галлериа Улаанбаатар салбар дэлгүүр, Смарт салбар дэлгүүр, Шангри-Ла салбар дэлгүүр, Чингис хаан ОУНОБ салбар дэлгүүр, Дархан салбар дэлгүүр гэсэн үндсэн 6 салбар дэлгүүрээр борлуулалтыг хийхээр төлөвлөж байна.

Мөн салбар дэлгүүрүүдийн нийт ажилтнуудынхаа үйлчилгээ, мэдлэг чадварыг нэмэгдүүлэн дэлхийн стандартад нийцсэн үйлчилгээгээр хэрэглэгчиддээ үйлчлэх зорилт тавин ажиллаж байна.

8 → 6

2018 он 2019 он




ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

↑ 23%


2018 онд гадаад борлуулалт 61.6 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 23% өсөлттэй байсан.

Гадаад борлуулалтад эзлэх хувь



ШИНЭЭР НЭЭГДСЭН ДЭЛГҮҮРҮҮД

● Франчайз дэлгүүр ● Pop-Up дэлгүүр



Бид дэлхийн 31 орны 171 орчим харилцагч нарт бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. 2018 оны сүүлийн байдлаар 13 орны 40 хотод 61 франчайз дэлгүүр, 5 салбар дэлгүүртэй байна.

2022 он гэхэд гадаад дахь дэлгүүрийн тоог 100-д хүргэж 90 франчайз дэлгүүр, 10 салбар дэлгүүртэй болохоор зорин ажиллаж байна.

ОНЛАЙН ХУДАЛДАА



2017 онд www.gobicashmere.com гэсэн өөрийн онлайн худалдааны сайттай болсноор дэлхийн өнцөг булан бүрт ГОВЬ брэндийн бүтээгдэхүүнийг түргэн шуурхай борлуулах боломжтой болсон бол 2018 оноос эхлэн гадаад зах зээл рүү чиглэсэн интернет худалдааны сувгаа тэлж "Gobi Cashmere" ухаалаг утасны аппликейшнийг хэрэглээнд нэвтрүүлэн хөгжүүлэлтийг хийхээс гадна 310 сая гаруй идэвхтэй хэрэглэгчтэй АНУ-ын жижиглэнгийн худалдааны 43%-ийг эзэлдэг amazon.com сайт дээр бүтээгдэхүүнээ байршуулан борлуулж эхэлсэн.

ОНЦЛОХ АЖИЛ

Гадаад харилцагч нартаа зориулан шинэ коллекцийн танилцуулга хийх, нэгдсэн байдлаар захиалга авах арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан. Ийнхүү гадаад харилцагч нараасаа захиалгыг нэгдсэн журмаар авснаар үйлдвэрлэл болон борлуулалтын төлөвлөгөөгөө урьдчилан боловсруулан, бүтээмжээ нэмэгдүүлэн ажиллах боломжтой болсон.



3 сард Бельгийн вант улсын Брюссель хотод зохион байгуулсан ГОВЬ болон YAMA брэндийн 2018 оны намар, өвлийн коллекци танилцуулах, захиалга авах арга хэмжээ



8 сард Япон улсын Токио хотод зохион байгуулсан ГОВЬ, YAMA болон ОРГАНИК брэндийн 2019 оны хавар, зуны коллекци танилцуулах, захиалга авах арга хэмжээ


СОНИРХОЛТОЙ БАРИМТУУД



БНСУ-ийн Hyundai Home Shopping-оор ГОВЬ брэндийн бүтээгдэхүүнүүд амжилттай борлуулагдав.



12,000 ширхэг Джемпер цамц 60 минутад борлуулагдав. /10 сарын 09/



800 ширхэг 2 талт пальто 17 минутад борлуулагдав. /10 сарын 19/



4,000 ширхэг Сүлжмэл шааль 18 минутад борлуулагдав. /11 сарын 05/

2019 ОНД БИД


Салбар дэлгүүрүүдийнхээ үйлчилгээ, зохион байгуулалтыг сайжруулахаас гадна франчайз дэлгүүрийнхээ тоог нэмэн Тува улсын Кызыл хот болон БНХАУ-ын Бээжин хотуудад шинэ дэлгүүрээ нээхээр төлөвлөж байна.

Мөн дэлхий дахинд хурдацтай хөгжиж буй "Онлайн худалдаа"-ны сувгийг илүү хөгжүүлэн, идэвхжүүлэлтийг хийж борлуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

БҮТЭЭГДЭХҮҮН

Манай компанийн Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын мэргэшсэн чадварлаг хамт олон 2018 онд дэлхийн загварын чиг хандлагад нийцсэн 24 коллекцийн загварыг хийн хэрэглэгч, үйлчлүүлэгчиддээ дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхэд авьяас чадвараа дайчлан ажилласан.


БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ /мөнгөн дүнгээр/



Бүтээгдэхүүний борлуулалтын бүтцийг нэр төрлөөр нь задлаад үзвэл 2018 онд сүлжмэл бүтээгдэхүүний борлуулалтад эзлэх хувь 3%, нэхмэл бүтээгдэхүүний борлуулалтад эзлэх хувь 6%-иар тус тус буурсан бол оёмол бүтээгдэхүүний борлуулалтад эзлэх хувь 7% нэмэгдэж 30%-д хүрсэн үзүүлэлттэй байна. Манай компани цаашид борлуулалтад эзлэх оёмол бүтээгдэхүүний хувь хэмжээг нэмэгдүүлж, сүлжмэл болон нэхмэл бүтээгдэхүүний эзлэх хувийг бууруулахаар төлөвлөж байна. Үүнтэй уялдаад ноолууран пальто, пиджак, болон хослолын загвар дизайн, технологийн хөгжүүлэлт дээр онцгойлон анхаарч ажиллаж байна.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ

Борлуултад эзлэх хувь



Бид 2018 онд бүтээгдэхүүний нэр төрлийг цэгцэлж, борлуулалтад эзлэх хувь хэмжээ дээр нь үндэслэн бүтээгдэхүүний нэр төрлийг бууруулах, борлуулалт багатай нэр төрлийн үйлдвэрлэлийг зогсоож, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажилласан.

Улмаар нийт борлуулалтын 99.6%-ийг эзэлж буй ТОП 35 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үргэлжлүүлэн үйлдвэрлэж, борлуулалтад 0.4%-ийг эзэлж байсан 24 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлээс хасаж, үйлдвэрийн ачааллыг багасган бүтээмжийг нэмэгдүүлэн ажилласан.

Дээрх графикаас харахад нийт борлуулалтын 82.5%-ийг ТОП 6 нэр төрлийн бүтээгдэхүүн, 96.6%-ийг ТОП 14 нэр төрлийн бүтээгдэхүүн эзэлж байна. Иймд цаашид эдгээр нэр төрлийн бүтээгдэхүүнд онцгой ач холбогдол өгөн, загвар, чанар, технологи дээр сайжруулалтыг хийн ажиллахаар төлөвлөж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ, ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ

TITEM



2018 оны үйл ажиллагааны зорилтын нэг болох дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц загвар, чанар, технологийн шаардлага хангасан ноолууран пиджак хийх технологи, ноу-хау-г сурч эзэмших зорилтын хүрээнд Унгар улсын "Титэм" компанитай хамтран ажиллаж, Говь компанийн мэргэжилтнүүд Унгар улс дахь "Титэм" үйлдвэрт очиж туршлага солилцон, мэргэшиж, улмаар эрэгтэй болон эмэгтэй пиджакны масс үйлдвэрлэлийг эхлүүлэв.

Гадаад зах зээл рүү чиглэсэн борлуулалт болон Монгол улсад ирж буй жуулчдын худалдан авалтын тоог нэмэгдүүлэх зорилгоор ноолууран пальтоны стандарт хэмжээг шинэчлэн Ази, Европ өмсгөлөөр размер хувиргалтыг хийн худалдаанд гаргаж байна.



Анхан шат, ээрэх, нэхэх үйлдвэрүүдийн бүх шат дамжлагаар бэлтгэн Япон улсад боловсруулалтыг нь хийсэн хослолын зориулалттай 100% ноолууран нимгэн даавуугаар оёмолын үйлдвэрт хослол үйлдвэрлэх туршилтыг эхлүүлэв.

Шинийг эрэлхийлсэн энэхүү томоохон алхмаар Говь ХК дэлхийн тансаг зэрэглэлийн брэндүүдтэй эн зэрэгцэхүйц чанартай хослолыг үйлдвэрлэх боломжтойгоо илэрхийлсэн бөгөөд цаашид нимгэн даавууны үйлдвэрлэл технологийг хөгжүүлж, чанар болон загварын өндөр түвшинд хослолыг массаар үйлдвэрлэнэ.

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

3D принттэй, splendor утастай, хатгамалтай, үстэй сүлжмэл бүтээгдэхүүнүүд



Хэлхгэр загварын, принттэй, хээтэй, хатгамалтай пиджакнууд



Загвар, суултыг нь сайжруулсан эрэгтэй пиджакнууд болон зуны нимгэн хослол




Haneda coat, Black coat, Anna Von Griesheim-тэй хамтарсан онцгой загварын пальтонууд

Зураач С.Саранцацралт болон Н.Туяа нартай хамтарсан принттэй шааль болон амьтны принттэй шаальнууд



Загварлаг эрчүүдэд зориулсан барласан шааль болон принттэй шаальнууд



БРЭНДУУД



MONGOLIAN CASHMERE

Дэлхийд танигдсан монгол брэнд
Gobi Mongolian Cashmere брэнд

GOBI ORGANIC
MONGOLIAN CASHMERE

Ноолуурын байгалийн үндсэн 4 өнгө болох
цайвар, цайвар шаргал, хөх саарал, бор өнгүүдийг
ашигласан, будаагүй, цайруулаагүй
Gobi Organic Cashmere брэнд



Илүү загварлаг, илүү тансаг зэрэглэлийн YAMA брэнд

Монголоор "Ямаа" буюу тансаг, дулаан ноолуурыг бий болгодог
таван хошуу малын нэгээр нэрлэсэн бол японоор Yama гэх үг
нь "Уулын оргил" гэсэн утгатай. Дэлхийн зах зээлд хэдийнээ
танигдсан GOBЬ брэнд тансаг зэрэглэлийн ноолууран
бүтээгдэхүүний зах зээлд хүч үзэхийг билэгдэн ийнхүү нэрлэсэн.

GOBI KIDS

Хүүхдийн хөдөлгөөнд саадгүй, хөнгөн, зөөлөн,
загварлаг GOBI KIDS хүүхдийн брэнд



КОЛЛЕКЦИУД



ЦАГААН САР 2018



GOBI ХАВАР/ЗУН 2018



GOBI KIDS 2018



GOBI НАМАР/ӨВӨЛ 2018-19



YAMA ХАВАР/ЗУН 2018



НААДАМ 2018



YAMA НАМАР/ӨВӨЛ 2018-19



ОРГАНИК 2018

БИДНИЙ ХАРИЛЦАГЧИД





КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



Бид 2018 онд компанийн сайн засаглалыг бэхжүүлэн сайжруулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

- Засаглалын бодлогын бичиг баримтуудыг шинэчлэн боловсруулж "Говь ХК-ийн Засаглалын дүрэм журмууд" гэсэн эмхтгэлийг гаргасан. 2018 онд шинэчлэн боловсруулсан бодлогын бичиг баримтууд:
 - Ногдол ашгийн журам
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам
 - ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
 - Мэдээллийн үйл ажиллагааны журам
 - Компанийн ёс зүйн дүрэм
 - Оролцогч талуудын өргөдөл, санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журам
 - Эрх бүхий албан тушаалтнуудын талаар баримтлах бодлого
- ТУЗ-ийн дэргэдэх хороод чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:
 - Гүйцэтгэх удирдлагатай Менежментийн гэрээг шинэчлэн байгуулсан.
 - ТУЗ-ийн гишүүдийн өөрийн үнэлгээний асуулгыг боловсруулан баталсан.
 - ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, дүгнэсэн.
 - Компанийн засаглалын өөрийн үнэлгээг хийж Монголын хөрөнгийн бирж болон Компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнасан.
 - ТУЗ-ийн дэргэдэх хороод хурлаараа хэлэлцсэн асуудал, үр дүнгийн талаар ТУЗ-ийн хурал дээр тогтмол тайлагнадаг болсон.
- Хувьцаа эзэмшигч нарынхаа эрх ашгийг хангах зорилгоор дараах ажлыг хийсэн. Үүнд:
 - Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хөндлөнгийн аудиторын төлөөллөөс оролцуулан, хувьцаа эзэмшигчдийг асуулт асууж мэдээлэл авах нөхцөлөөр хангадаг болсон.
 - Жилийн үйл ажиллагааны тайланд Эрсдэлийн удирдлага гэсэн агуулгыг нэмэлтээр оруулж, компанийн эрсдэлийн удирдлагын талаар, цаашлаад компанид учирч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллийг тусгадаг болсон.

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Манай компани Монголын хөрөнгийн биржээс батлан гаргасан Хувьцаат компаниудад зориулсан "Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга" буюу компани өөрийгөө үнэлэх асуулгыг ашиглан Засаглалын өөрийн үнэлгээг 2 дахь жилдээ хийн, 2018 оны 12 сарын 21-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэн, хянаж баталсан.

ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Үндсэн зарчмууд	Асуултын тоо	Зорилгот үр дүн	Бодит үр дүн			Хэрэгжилтийн хувь	
				2017 он	2018 он	Өсөлт %	2017 он	2018 он
A	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал	20	20.0%	17.5%	18.5%	1% ↑	87.5%	92.5%
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал	10	10.0%	7.5%	9.5%	2% ↑	75.0%	95.0%
В	Оролцогч талууд	10	10.0%	8.0%	8.5%	0.5% ↑	80.0%	85.0%
Г	Ил тод нээлттэй байдал	20	20.0%	16.5%	18.0%	1.5% ↑	82.5%	90.0%
Д	Төлөөлөн удирдах зөвлөл	30	30.0%	24.5%	27.5%	3% ↑	81.7%	91.6%
Е	Гүйцэтгэх удирдлага	10	10.0%	7.5%	9.0%	1.5% ↑	75.0%	90.0%
	Нийт	100	100.0%	81.5%	91.0%	9.5% ↑		

Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн 2018 оны засаглалын нэгдсэн үнэлгээ нь 91.0% буюу өмнөх оноос 9.5% өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Үүнээс 90% ба түүнээс дээш хэрэгжилттэй байгаа үзүүлэлтүүд нь:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал
- Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал
- Ил тод нээлттэй байдал
- Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой үйл ажиллагаа
- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа

Харин 90%-аас доош хэрэгжилттэй байгаа үзүүлэлтүүд нь:

- Оролцогч талууд гэсэн үр дүнтэй байна.


ЦААШИД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХАД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Манай компани Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, гаднын компаниудын сайн засаглалын туршлагаас суралцан сайн засаглалыг бэхжүүлэх, компанийн засаглалаар улсдаа манлайлан, хичээн ажилласаар ирсэн. Энэ ч утгаараа бидэнд хийж сайжруулах зүйлс нэлээд байгааг илтгэсэн үр дүн гарлаа хэмээн Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна. Иймд бид цаашид компанийн засаглалаа улам илүү сайжруулахын тулд дараах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

- Жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн үйл ажиллагаа, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны үр дүнг илүү дэлгэрэнгүй оруулдаг болох, тайлангийн агуулгыг улам сайжруулах
- Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр компанийн үйл ажиллагааны тайлангаас гадна ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг тайлагнадаг болох
- Хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хангах, эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр нь бүрэн хангахын төлөө сайжруулалтын арга хэмжээг тасралтгүй эрэлхийлэх
- Олон нийтэд тухай бүр хүргэх мэдээллийн агуулга, цар хүрээг улам бүр сайжруулах
- Компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулгыг тасралтгүй сайжруулах
- Дотоод мэдээллийн агуулгыг байдлыг хангах тал дээр тавих хяналтын тогтолцоог илүү сайжруулах
- Тайлангийн жил дууссаны дараа ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагаанд илүү нарийвчилсан байдлаар дүгнэлт өгдөг болох
- Эрсдэл аудитын хорооны зүгээс компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэн дүгнэлт өгдөг болох зэрэг ажлыг хийхээр төлөвлөж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо /ширхэг/	Эзэмшлийн хувь
ХИДЕ ИНТЕР ХХК	265,238,300	34.00%
ЭФ-СИ-АЙ ХХК	223,001,900	28.59%
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	168,809,800	21.64%

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО
780,112,500

/2018 оны 10 сарын 3-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр компанийн хувьцааг 100 хуваасан./

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО
16,586

/2018.12.31-ний байдлаар/

ХИДЕ ИНТЕР ХХК, ЭФ-СИ-АЙ ХХК нь хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

ТАВАН БОГД ТРЕЙД ХХК нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.



Таван Богд Групп нь 16 охин компани, 3 хөрөнгө оруулалттай компани, 4 бизнес нэгж, нийт 12,000 гаруй ажиллагсадтайгаар бизнесийн салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын манлайлагч групп компани юм.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК нь Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хурлыг 2018 оны 4 сарын 17-ны өдрийн 14:00 цагт компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” гэр ресторанд зохион байгуулсан. Хуралд 6,946,873 саналын эрхтэй 210 хувьцаа эзэмшигч оролцож, 89.05%-ийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2017 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.88%-ийн саналаар батлав.
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж 99.85%-ийн саналаар батлав.
3. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийг батлахад кумулятив аргаар санал хураалт явуулан, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр М.Баяр, Д.Гэрэлмаа, Б.Нандин-Эрдэнэ, Такэши Камбэ, З.Шагдарсүрэн нарыг, ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ц.Баатарсайхан, Ж.Оюунчимэг, Хидэо Савада, Д.Хулан нарыг тус тус 3 жилийн хугацаатайгаар сонгох шийдвэр гаргав.
5. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг 99.84%-ийн саналаар батлав.

ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

Говь ХК нь Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит бус хурлыг 2018 оны 10 сарын 03-ны өдрийн 10:00 цагт компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд зохион байгуулсан. Хуралд 6,921,425 саналын эрхтэй 45 хувьцаа эзэмшигч оролцож, 88.72%-ийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

1. Компанийн хувьцааг 1:100 хуваах тухай асуудлыг хэлэлцэж 99.99%-ийн саналаар батлав.
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж 99.99%-ийн саналаар батлав.



УДИРДЛАГА БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАРДАЛ



ЗАРДЛЫН ТӨРӨЛ	/мян.төг/		
	2018 он	2017 он	2016 он
ТУЗ-ийн цалин урамшуулал	184,367	109,614	82,783
Удирдлагын цалин урамшуулал	1,719,000	1,033,005	724,449
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	16,472	13,407	11,138

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ХАРААТ БУС ГИШҮҮД



Дамбын ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн дарга
Хараат бус гишүүн
/Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор



Мягмарын БАЯР

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Нэр дэвшүүлэх хорооны дарга/

ШУТИС-ийн УТС-ийн Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын дэд профессор



Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Эрсдэл, аудитын хорооны дарга/

СЭЗИС, Бизнесийн Удирдлагын тэнхимийн ахлах багш



Такэши КАМБЭ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Цалин урамшууллын хорооны гишүүн/

Asahi Life Insurance Менежер



Зуунай ШАГДАРСУРЭН

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Эрсдэл, аудитын хорооны гишүүн/

Өмгөөлөгч, Хуулийн зөвлөл

ЕРДИЙН ГИШҮҮД



Цагаачийн БААТАРСАЙХАН

ТУЗ-ийн ердийн гишүүн
/Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал



Дашдаваагийн ХУЛАН

ТУЗ-ийн ердийн гишүүн
/Эрсдэл, аудитын хорооны гишүүн/

Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч



Хидэо САВАДА

ТУЗ-ийн ердийн гишүүн

Н.И.С компанийн Ерөнхийлөгч



Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ

ТУЗ-ийн ердийн гишүүн
/Цалин урамшууллын хорооны гишүүн/

Таван Богд Групп, Маркетингийн газрын захирал

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ НЭР	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ	
	ДАНГААРАА	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД
Д.ХУЛАН	12,247,300 ширхэг (1.57%)	ЭФ-СИ-АЙ ХХК 28.59% ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 21.64%
Ц.БААТАРСАЙХАН	50,000 ширхэг (0.01%)	
НИЙТ		51.80%

ТУЗ-ИЙН 2018 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2018 онд 6 удаа ээлжит хурал, 3 удаа ээлжит бус хурал зохион байгуулж, 35 асуудлыг хэлэлцэн 33 шийдвэр, 33 тогтоол гаргав. Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 35 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажиллав.

№	Хуралдсан огноо	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр
1	2018.02.02 /ээлжит хурал/	1. 2017 оны санхүү, үр дүнтэй танилцах	-
		2. а. Компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөг шинэчлэн батлах, 2. б. 2022 он хүртэлх дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг батлах	1. 2018 оны бизнес төлөвлөгөөг шинэчлэн батлав. 2. 2022 он хүртэлх дунд хугацааны төлөвлөгөөг батлав.
		3. Компанийн 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай хэлэлцэх	3. 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 220 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэв. /Цэвэр ашгийн 9.8%, нэгж хувьцаанд олгосон ногдол ашгийн хэмжээ өмнөх оноос 10% өсөлттэй/
		4. Компанийн 2017 оны сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийгдсэн хэлцлийн гүйцэтгэлтэй танилцах, 2018 онд хийгдэх хэлцлийг хэлэлцэж батлах	4. 2018 онд сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийгдэх хэлцлийг батлав.
		5. Тоног төхөөрөмжийн санхүүжилт авах тухай хэлэлцэж батлах	5. Япон улсын Muratec үйлдвэрээс ээрмэлийн үйлдвэрт шилжүүлэн ороох машин авах гэж байгаатай холбогдуулан тоног төхөөрөмжийн санхүүжилт авахыг зөвшөөрөх тухай тогтоол гаргав.
		6. "Ногдол ашгийн журам"-ыг хэлэлцэж батлах	6."Ногдол ашгийн журам"-ыг батлав.
		7. "Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам"-ыг хэлэлцэж батлах	7. "Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам"-ыг батлав.
		8. ТУЗ-ийн 2018 оны хурлын хуваарийг батлах	8. ТУЗ-ийн 2018 оны хурлын хуваарийг батлав.
2	2018.02.15 /ээлжит бус хурал/	9. 2018 оны 1-р сарын санхүү үр дүнг хэлэлцэх	-
		10. Монгол улсын хөгжлийн банкнаас зээл авах тухай хэлэлцэх	9. 2018 оны түүхий эд бэлтгэлтэй холбоотой Монгол улсын хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээлийн санхүүжилт авахыг зөвшөөрөв.
		11. Ди Би Эм лизинг ХХК-с санхүүжилт авах тухай хэлэлцэх	10. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Ди Би Эм лизинг ХХК-с хөрөнгө оруулалтын зориулалттай санхүүжилт авахыг зөвшөөрөв
3	2018.03.07 /ээлжит бус хурал/	11. 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4 сарын 17-ны өдөр хуралдуулахаар тогтож, хурлаар хэлэлцүүлэх асуудлыг батлав.	-
		12. Говь ХК-ийн 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлыг хэлэлцэж, хурал зарлан хуралдуулах тухай шийдвэрийг гаргав	1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах 2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай хэлэлцэн батлах 3. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах 4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай хэлэлцэн батлах 5. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах
		13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын болон редакцын комиссыг томилох	12. Тооллогын комисс болон редакцын комиссыг томилох тогтоол гаргав.
4	2018.03.19 /ээлжит бус хурал/	14. Худалдаа хөгжлийн банкнаас авсан санхүүжилтийн барьцаа хөрөнгийг өөрчлөх тухай хэлэлцэх	13. Худалдаа хөгжлийн банкнаас 2016 оны 12 сард авсан санхүүжилтийн барьцаа хөрөнгийг өөрчлөхийг зөвшөөрөв.
4	2018.03.19 /ээлжит бус хурал/	15. Монгол улсын хөгжлийн банкнаас авах зээлийн нөхцөлийг өөрчлөн, зээлийн санхүүжилт авах тухай хэлэлцэх	14. Монгол улсын хөгжлийн банкнаас авах эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээлийн санхүүжилт авахыг зөвшөөрсөн 2018.02.15-ны тогтоолын нөхцөлийг өөрчлөн доллараар бус төгрөгөөр санхүүжилт авахыг зөвшөөрөв.

5	2018.04.09 /ээлжит хурал/	16. 2018 оны 2-р сарын санхүү, үр дүн болон түүхий эд бэлтгэлийн явцтай танилцах	-
		17. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалуудтай танилцах	-
		18. "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ыг хэлэлцэж батлах	15. "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ыг батлав.
6	2018.07.09 /ээлжит хурал/	19. 2018 оны 5-р сарын санхүү, үр дүн болон түүхий эд бэлтгэлийн тайлантай танилцах	-
		20. "Мэдээллийн үйл ажиллагааны журам"-ыг хэлэлцэж батлах	16. "Мэдээллийн үйл ажиллагааны журам"-ыг батлав.
		21. ТУЗ-ийн өөрийн үнэлгээний тайлангийн үр дүнтэй танилцах	-
		22. ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлаар хэлэлцсэн асуудал болон үр дүнтэй танилцах	17. "Ес зүйн дүрэм"-ийг засаглалын түвшинд боловсруулах болов. 18. Дотоод аудитын хэлтэст ач холбогдол ихтэй, эрсдэл өндөртэй газруудыг тодорхойлоод, 3 сар тутам шалгадаг болох гэсэн төлөвлөгөөг гарган ажиллах үүрэг өгөв. Шинэ зохион байгуулалтаар, бүтээмжээ нэмэгдүүлэн, сайжруулалт хийн ажилласан ч одоогийн хүн хүч нь хүрэлцэхгүй бол ДАХ-ийн хүн хүчийг нэмэх асуудлыг дахин авч хэлэлцэхээр болов. 19. Удирдлагын багийн ажилтнуудын хагас жилийн гүйцэтгэл, үр дүнг үнэлээд 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний цалингаар урамшуулахаар шийдвэрлэв. Бусад ажилтнуудыг урамшуулах асуудлыг Гүйцэтгэх захирал шийдэхээр болов. 20. Инженер, засварчид, дизайнерүүд гэсэн салбарын дундажтай харьцуулахад өрсөлдөх чадвар бага байгаа албан тушаалууд дээр цалингийн тооцоолол хийн 7 сарын 1-ээс цалинг нь өсгөхөөр шийдвэрлэв. 21. Гүйцэтгэх захиралд эрх мэдэл олгох тухай тогтоолыг батлав.
7	2018.08.24 /ээлжит хурал/	23. 2018 оны 7-р сарын санхүү, үр дүнтэй танилцах	-
		24. 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх асуудлыг хэлэлцэж, хурал зарлан хуралдуулах тухай шийдвэрийг гарган, тооллогын комиссыг томилох	22. 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 10 сарын 3-ны өдөр хуралдуулах тухай тогтоолыг батлав. 23. 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх асуудлыг батлав. 1. Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлах 2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах 24. Тооллогын комиссыг томилох тогтоолыг батлав.
		25. Хас банкнаас авсан зээлийн хугацааг сунгах тухай хэлэлцэж батлах	25. Хас банкнаас 2017 оны 10 сард авсан зээлийн хугацааг нэг жилээр сунгуулах тухай тогтоолыг батлав.
8	2018.11.01 /ээлжит хурал /	26. 2018 оны 9-р сарын санхүү, үр дүнтэй танилцах	-
		27. Компанийн "Ес зүйн дүрэм"-ийг хэлэлцэж батлах	26. Компанийн "Ес зүйн дүрэм"-ийг батлав. 27. 11-р сард Удирдлагын багийнханд зориулан Нэр дэвшүүлэх хорооноос Ес суртахуунлаг шийдвэр гаргалтын талаар сургалт зохион байгуулахаар болов.
		28. Эрсдэл, аудитын хорооны хурлаар хэлэлцсэн асуудал болон үр дүнтэй танилцах	-
9	2018.12.21 /ээлжит хурал/	29. 2018 оны 11-р сарын санхүү, үр дүнтэй танилцах	-
		30. 2018 оны хүлээгдэж буй үр дүнтэй танилцах, 2019 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг батлах	28. 2019 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг батлав.
		31. Монгол улсын хөгжлийн банкнаас санхүүжилт авах тухай хэлэлцэж батлах	29. 2019 оны түүхий эд бэлтгэлтэй холбоотой Монгол улсын хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зориулалттай зээл авахыг зөвшөөрөв.
		32. "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг батлах	30. Компанийн "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг батлав.
		33. Компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлангийн үр дүнг хэлэлцэх	31. Засаглалын өөрийн үнэлгээн дээр гишүүдийн саналыг тусган, сайжруулалт хийгээд тайлангаа олон нийтэд нээлттэй мэдээлэхээр болов. 32. 2019 оны ХЭХ-ийн хурал дээр ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг тавихаар болов.
		34. ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлаар хэлэлцсэн асуудал болон үр дүнтэй танилцах	33. ТУЗ-ийн дэргэдэх хороод тайлан бэлтгээд дараагийн ТУЗ-ийн хурал дээр танилцуулан, үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүй байдлаар тусгахаар болов.
35. Ес зүйн дүрмийн хэрэгжилттэй танилцах	-		

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавин чиглүүлэх, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл, аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Нандин-Эрдэнэ
 Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Шагдарсүрэн
 ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан

2018 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл, аудитын хороо нь 2018 онд 4 удаа ээлжит хурал, 2 удаа ээлжит бус хурал зохион байгуулж, 26 асуудлыг хэлэлцэн 27 шийдвэр, 5 тогтоол гаргав. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 43 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн эрсдэлийн удирдлага болон хяналтын тогтолцоог сайжруулах үндсэн чиг үүрэгтэйгээр ажилласан.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд Эрсдэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулах, эрсдэлийн мониторинг, ангилалыг сайжруулах зэрэг голлох ажлуудыг Эрсдэлийн удирдлагын багаар гүйцэтгүүлэн, хяналт тавьж, чиглүүлэн ажиллав.

Хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын горимуудыг нэвтрүүлэх, Говь ХК-ийн дотоод аудитын дүрмийг олон улсын стандартанд нийцүүлэн өөрчлөх зэрэг ажлуудыг Дотоод аудитын хэлтсээр гүйцэтгүүлэн, хяналт тавьж, чиглүүлэн ажиллалаа.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Нэр дэвшүүлэх хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр
 Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа
 ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Баатарсайхан

2018 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нэр дэвшүүлэх хороо нь 2018 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 9 асуудлыг хэлэлцэн, 11 шийдвэр, 2 тогтоол гаргав. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 9 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч ажиллав.

Энэ онд тус хороо нь ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, үр дүнд нь үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цаашид гүйцэтгэх ажлуудыг хэлэлцсэн бөгөөд Компанийн засаглалын өөрийн үнэлгээг хийж Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнан ажиллав.

Мөн компанийн тогтвортой үйл ажиллагааг өндөр чадвартай удирдлага, зохион байгуулалтаар тасралтгүй хангах хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Эрх бүхий албан тушаалтануудын талаар баримтлах бодлого”-ыг албан тушаалын зэрэглэлтэй уялдуулж сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшуулал, залгамж халааг бэлтгэх асуудалд баримтлах 7 зүйл бүхий заалттай боловсруулж баталлаа.

Түүнчлэн компанийн удирдлагын багийнхныг сурган хөгжүүлэх зорилгоор тус хорооны санаачилгаар 2 удаа нийт удирдлагын багийг хамарсан сургалтыг зохион байгуулав.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Цалин урамшууллын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа
 Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Такэши Камбэ
 ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг

2018 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2018 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 7 асуудлыг хэлэлцэн, 7 шийдвэр гаргав. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 15 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч чиглүүлэн ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлантай хагас жил тутам танилцан, ажлын үр дүнтэй холбогдсон урамшууллын системийг шинэчлэх, компанийн цалингийн доод хэмжээг тогтоох, Эрх бүхий албан тушаалтнуудын урамшууллын дээд хязгаарыг тогтоох зэрэг голлох ажлууд дээр шийдвэр, зөвлөмжийг өгч ажиллалаа.

Мөн хорооны чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, ирэх жилийн цалин урамшууллын төсвийг баталснаас гадна тус хорооны чиглүүлгийн дагуу компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн эхлээд байна.

ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Манай компанийн Дотоод аудитын хэлтэс нь хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болж компанийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хараат бус хяналтыг тавьж ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд улирал бүр ажлаа тайлагнадаг.

Дотоод аудитын хэлтэс нь компанийн хэмжээнд хараат бусаар Дотоод Аудитын Олон Улсын Стандартын дагуу нийцлийн аудит, гүйцэтгэлийн аудитыг хослуулан хийж асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж, учирч болох эрсдэлийг тодорхойлон бууруулах арга хэмжээг зөвлөн, Удирдлагын багтай хамтарч үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж байна.


2018 онд хийгдсэн онцлох ажлаас дурдвал:

- Дотоод Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандартын дагуу үйл ажиллагаандаа дэлхийн сүүлийн үеийн чиг хандлагыг нэвтрүүлж, аудитын горимуудыг хэрэгжүүлж ажилласнаар нийт 155 асуудлыг илрүүлэн, тэдгээрийн эрсдэлүүдийг тодорхойлж, бууруулах чиглэлээр зөвлөмжийг өгч ажилласан.
- Эрсдэлийг бууруулан, арилгахаар шат шатны удирдлагуудтай хамтарч, илэрсэн асуудлыг 82%-ийн гүйцэтгэлтэйгээр сайжруулсан.
- Дотоод аудитын дүрмийг стандартад нийцүүлэн шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.
- Компанийн дотоод хяналтын тогтолцоог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Дотоод хяналтын цогц үзэл баримтлал” буюу COSO загвараар үнэлж, хяналтыг сайжруулах зөвлөмжийг өгч, Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийг хяналтын чиг үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг өгч ажилласан.

Цаашид Дотоод аудитын хэлтэс нь Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандартад нийцүүлэн компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, сайжруулахад бие даасан бөгөөд бодитой баталгаажуулах, зөвлөх үйл ажиллагааг явуулж, чанарын баталгаажуулалтыг дотооддоо хийж, чадварлаг хүний нөөцийг бэлтгэнэ. Мөн компанийн эрсдэлийн удирдлага, засаглал, хяналтын тогтолцоог олон улсад хэрэгжүүлж буй загвар, аргачлалаар үнэлж, Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийг бодит мэдээллээр ханган, хяналтын чиг үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Манай компани нь дотоод хяналтдаа “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. Энэ загвар нь шат шатны удирдлагууд өдөр тутмын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах, зохицуулах үндсэн чиг үүргүүдээ хэрэгжүүлэн ажиллахад ач холбогдолтой байдаг.



Хамгаалалтын I шугам:

Компанийн үндсэн үйл ажиллагааг явуулж буй нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, тайлагнадаг.

Хамгаалалтын II шугам:


Компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг давхар хэрэгжүүлж, тайлагнадаг.

Хамгаалалтын III шугам:

Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтын тогтолцоо нь хэрэгжиж байгаа эсэх, оновчтой байгаа эсэх дээр баталгаажуулалтыг хийж, үндсэн чиг үүргийн хувьд Эрсдэл, аудитын хороонд, захиргааны хувьд Гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг.

Ийнхүү чиг үүргийнхээ дагуу давхар тайлагнаснаар Дотоод аудитын хараат бус байдал хангагдаж, бодитой, зохисгүй нөлөөллөөс ангид ажиллаж байна.

КОМПАНИЙН БҮТЭЦ



КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Дээд шатны удирдлагын харьяатай холбоотой:
 - Хуулийн зөвлөхийн орон тоог өргөжүүлэн шинээр Хуулийн хэлтэстэй болгосон.
- Захиргаа, хүний нөөцийн газартай холбоотой:
 - Хүний нөөцийн хэлтсийг Хөдөлмөрийн харилцааны алба, Сургалт хөгжлийн албатай болгосон.
- Санхүү, бүртгэл, удирдлагын газартай холбоотой:
 - Шинээр Санхүү төлөвлөлтийн хэлтэстэй болсон бөгөөд Санхүү бүртгэлийн хэлтсийг дотор нь Бүртгэлийн албатай болгосон.
- Дотоод худалдааны газартай холбоотой:
 - Пальто хаус салбар дэлгүүрийг хааж, Галлериа Улаанбаатар салбар дэлгүүрийг шинээр нээсэн.
- Гадаад худалдааны газартай холбоотой:
 - Маркетинг төлөвлөлтийн албыг Төлөвлөлтийн алба, Маркетингийн алба болгон 2 хуваасан.
- Анхан шатны үйлдвэртэй холбоотой:
 - Шинээр Говь-2 албатай болж анхан шатны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлсэн.
- Нэхмэлийн үйлдвэртэй холбоотой:
 - Нэхмэлийн гүйцэтгэн боловсруулах албыг дотор нь Нэхмэлийн гүйцэтгэх нэгж, Нэхмэлийн боловсруулах нэгж гэсэн 2 нэгжтэй болгосон.
- Сүлжмэлийн үйлдвэртэй холбоотой:
 - Сүлжмэлийн үйлдвэрийн 1, 2-р албыг нэгтгэн Сүлжих алба, Оёх алба, Гүйцэтгэн боловсруулах алба, Сүлжмэлийн чанар технологийн алба, Whole Garment нарийн гейчийн алба гэсэн 5 албатай болгосон.

ОХИН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Охин компанийн нэр	Хувьцаа эзэмшигч	Үүсгэн байгуулагдсан огноо	Байршил	Үйл ажиллагааны чиглэл
1	Говь Кашмер Европ ХХК	Говь ХК 100%	2016.11.07	Герман улс, Шонефелд хот	Худалдаа үйлчилгээ
2	Говь Кашмер (Өвөр Монгол) ХХК	Говь ХК 100%	2016.12.19	Хятад улс, Эрээн хот	Худалдаа үйлчилгээ
3	Говь Кашмер Эс Фи Ар Эл ХХК	Говь ХК 100%	2017.01.17	Бельги улс, Брюссель хот	Худалдаа үйлчилгээ

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



ЦАГААЧИЙН БААТАРСАЙХАН

Гүйцэтгэх захирал

Политехникийн их сургуулийг Холбооны инженер, Япон улсын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургуулийг Электроникийн инженер мэргэжлээр төгссөн.

Алтай компанид Орлогч захирал, Таван Богд Трейд ХХК, Жуулчин ХХК, МИАТ компаниудын Ерөнхий захирал, Палас зочид буудлын Гүйцэтгэх захирлын албан тушаалуудыг хашиж байсан.

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Хаан банкны ТУЗ-ийн гишүүн, 2008 оны 8 сараас одоог хүртэл Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



НЯМЖАВЫН СҮРЭНРАГЧАА

Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

Япон улсын Хитоцүбаши-гийн их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр магистрын зэрэгтэйгээр төгссөн.

Таван Богд Трейд ХХК-д Төслийн мэргэжилтэн, Төслийн туслах менежерээр ажиллаж байсан.

2015 оны 4 сараас Говь ХК-ийн Бизнес удирдлагын газрын захирал, 2015 оны 11 сараас одоог хүртэл Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.



БАТЧУЛУУНЫ АРИУНАА

Гадаад худалдаа хариуцсан дэд захирал

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг Англи хэлний орчуулагч мэргэжлээр, АНУ-ын Колумб коллежийг Бизнесийн удирдлага мэргэжлээр тус тус төгссөн.

2009-с 2014 оны хооронд Говь ХК-д Гадаад худалдааны менежер, Гадаад худалдааны газрын захирлаар ажиллаж байсан.

2018 оны 9 сараас одоог хүртэл Говь ХК-ийн Гадаад худалдаа хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.



БОЛДЫН ЖАВХЛАН

Дотоод худалдааны газрын захирал

Япон улсын Кобэ их сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр, Хитоцүбаши их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Монгол улсын хөгжлийн банкинд Эрсдэлийн мэргэжилтэн, Голомт банкинд Эрсдэлийн мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан.

2018 оны 5 сараас Говь ХК-ийн Дотоод худалдааны хэлтсийн даргаар ажиллаж байгаад 9 сараас одоог хүртэл Дотоод худалдааны газрын захирлаар ажиллаж байна.



ГАНБОЛДЫН СЭЛЭНГЭ

Санхүү бүртгэл, удирдлагын газрын захирал

МУИС-ийг Санхүү, бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн.

Гермес Тэсүн ХХК-д Ерөнхий нягтлан бодогч, Хаан Палас ХХК-д ахлах нягтлан бодогч, Таван Богд Групп-д нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан.

2013 оноос одоог хүртэл Говь ХК-ийн Санхүү бүртгэл, удирдлагын газрын захирлаар ажиллаж байна.



БАТСУУРИЙН БОЛОРМАА

Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын захирал

ШУТИС-ийг Оёмол бүтээгдэхүүний технологи, загвар зохион бүтээгч мэргэжлээр магистрын зэрэгтэйгээр төгссөн.

Дархан Минж ХХК-д Дизайнерээр ажиллаж байсан.

2007 оноос Говь ХК-д чанар шалгагч, 2008 оноос дизайнер, загвар зохион бүтээгч, 2016 оноос одоог хүртэл Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын захирлаар ажиллаж байна.



ЧУЛУУНБАТЫН СОЛОНГО

Захиргаа, хүний нөөцийн газрын захирал

ШУТИС-ийг Архитектор мэргэжлээр төгссөн.

Алтандорнод Монгол ХХК-д Гадаад харилцааны менежер, Боловсон хүчин, Таван Богд Групп-д Гадаад худалдааны менежер, Борлуулалт хариуцсан ахлах менежерээр тус тус ажиллаж байсан.

2014 оноос одоог хүртэл Говь ХК-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын захирлаар ажиллаж байна.



ЦОГТБАЯРЫН ЦАСЧИХЭР

Хуулийн хэлтсийн дарга

Цагдаагийн академийг Эрх зүйч мэргэжлээр, Их засаг их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн.

Хэнтий аймгийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Жаст Ойл ХХК-д Хуулийн зөвлөх, Эм Си Эс ХХК-д Хуульчаар тус тус ажиллаж байсан.

2014 оноос Говь ХК-ийн Хуулийн зөвлөх, 2018 оны 10 сараас одоог хүртэл Хуулийн хэлтсийн даргаар ажиллаж байна.



МӨНХБАТЫН СЭЛЭНГЭ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Япон улсын Чива их сургуулийг Хотын ерөнхий төлөвлөгөөний инженер мэргэжлээр, Монгол улсын СЭЗИС-ийг Нягтлан бодогч мэргэжлээр тус тус төгссөн.

Нью Хакуба ХХК-д Нягтлан бодогч, Бүрд Петролиум ХХК-д Нягтлан бодогч, Таван Богд Трейд ХХК-д Төслийн туслах менежер, Менежмент удирдлага хариуцсан менежер, Захирлын ажлын албаны менежерээр тус тус ажиллаж байсан.

2017 оноос одоог хүртэл Говь ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

Говь ХК нь Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд ордог бөгөөд компанийн хувьцаа нь сүүлийн жилүүдэд тасралтгүй Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн багцад орж байна. Компанийн 2018 оны хувьцааны хаалтын ханш нь өмнөх оноос 43.5% өсөлттэй, хувьцааны арилжаалагдсан тоо өмнөх оноос 7.9% өсөлттэй, мөн компанийн зах зээлийн үнэлгээ 260.5 тэрбум төгрөгт хүрч Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд дотор 4-рт жагссан үзүүлэлттэй байна.

ХУВЬЦАА ХУВААСАН ТУХАЙ

Говь ХК-ийн 2018 оны 10 сарын 03-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар /ирц 88.72%/ хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, арилжааг идэвхжүүлэх, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч нарын тоог нэмэгдүүлэх зорилгоор компанийн нэгж хувьцааг 100 хуваах тухай асуудлыг хэлэлцэн 99.99% саналаар батлав.

Хувьцаа хуваах төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил дээр “Голомт Капитал” ҮЦК, хуульчийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлж хуулийн дүгнэлт гаргах ажил дээр “Ананд Адвокатс ХНН” хуулийн фирм тус тус хамтран ажилласан билээ.


Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 11 сарын 30-ны өдрийн хурлаар Говь ХК-ийн хувьцаа хуваах асуудлыг хэлэлцэж зөвшөөрсөн шийдвэрийг гаргав. Улмаар компанийн хувьцааны арилжааг 2018 оны 12 сарын 1-нээс 12 сарын 13-ны хооронд түр зогсоож, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулан 2018 оны 12 сарын 14-ний өдрөөс эхлэн арилжааг сэргээв.

52 ДОЛОО ХОНОГИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ХАНШ

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2017 он	2016 он	Өсөлт, бууралт	
				2018/2017	2017/2016
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО /шир/	780,112,500	7,801,125	7,801,125	энгийн хувьцаа	
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төг/ *					
Хаалтын үнэ	333.89	232.60	101.50	43.5% ↑	129.2% ↑
Хамгийн их үнэ	369.77	351.80	116.50	5.1% ↑	202.0% ↑
Хамгийн бага үнэ	205.20	96.00	71.00	113.8% ↑	35.2% ↑
Дундаж үнэ	266.80	165.35	85.40	61.4% ↑	93.6% ↑
АРИЛЖААЛАГДСАН ТОО /шир/					
Хамгийн их /өдөрт/	428,390	15,286	4,899	2,702.5% ↑	212.0% ↑
Хамгийн бага /өдөрт/	18	1	1	1,700.0% ↑	0.0%
Дундаж /өдөрт/	7,862	579	273	1,257.9% ↑	112.1% ↑
Нийт	1,886,927	140,047	59,302	1,247.4% ↑	136.2% ↑
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төг/					
Хамгийн их /өдөрт/	328,449,260	309,023,660	40,171,855	6.3% ↑	669.3% ↑
Хамгийн бага /өдөрт/	429,000	13,910	8,200	2,984.1% ↑	69.6% ↑
Дундаж /өдөрт/	17,980,871	10,739,199	2,369,085	67.4% ↑	353.3% ↑
Нийт	4,315,409,014	2,598,886,145	514,091,470	66.0% ↑	405.5% ↑
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төг/	260,471,762,625	181,454,167,500	79,181,418,750	43.5% ↑	129.2% ↑

* Говь ХК хувьцаагаа 100 хуваасантай холбоотой өмнөх хугацаан дахь хувьцааны бодит ханшийг 100 хуваасан ханш руу хөрвүүлж илэрхийлэв.

Хувьцаа хувааснаас хойш Говь ХК-ийн хувьцааны арилжааны хөрвөх чадвар болон идэвх нэмэгдэж, өдрийн дундаж арилжааны тоо ширхэг өмнөх оноос 13.6 дахин, өдрийн дундаж арилжааны дүн 67.4%, нэгж хувьцааны жигнэсэн дундаж хаалтын ханш 61.4% тус тус нэмэгдсэн зэрэг арилжааны бүх үзүүлэлт ногоон сум заасан эерэг үр дүнтэй байлаа.



Жич: Хувьцааны ханшийг 100 хуваасан ханш руу хөрвүүлж илэрхийлэв.

НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

Ногдол ашиг зарласан он	Хувьцааны тоо /шир/	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	Нийт зарласан ногдол ашгийн дүн /төг/	Ногдол ашиг тараалт
1996	7,801,125	61.00	475,868,625	Говь ХК нь 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
1997	7,801,125	153.80	1,199,813,025	
1998	7,801,125	150.00	1,170,168,750	
1999	7,801,125	166.00	1,294,986,750	
2000	7,801,125	100.00	780,112,500	
2001	7,801,125	20.16	157,270,680	
2005	7,801,125	60.00	468,067,500	
2006	7,801,125	60.00	468,067,500	
2010	7,801,125	100.00	780,112,500	
2011	7,801,125	100.00	780,112,500	
2012	7,801,125	125.00	975,140,625	
2013	7,801,125	130.00	1,014,146,250	
2014	7,801,125	140.00	1,092,157,500	
2015	7,801,125	140.00	1,092,157,500	
2016	7,801,125	200.00	1,560,225,000	
2017	7,801,125	220.00	1,716,247,500	
2018	780,112,500	6.80	5,304,765,000	2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2019 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд нь шилжүүлэх болно.


Жич: 2018 онд компанийн хувьцааг 100 хуваан 780,112,500 ширхэг энгийн хувьцаатай болсон.

2018 ОНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 2 сарын 13-ны өдрийн №2 тоот тогтоолын дагуу компанийн 2018 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 6.8 төгрөг буюу цэвэр ашгийн 30 хувь болох нийт 5,304,765,000 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ 3 дахин өссөн үзүүлэлт юм.

Ногдол ашгийг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдорлох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2019 оны 3 сарын 28-ны байдлаар Говь ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олгох болно.

Компанийн зарласан ногдол ашгийг 2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь компани дээрээ бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2019 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх болно.



* 2018 онд компанийн хувьцааг 100 хуваасантай холбогдуулан, 2018 онд зарласан ногдол ашгийн өсөлтийн хэмжээг өмнөх онуудтай харьцуулах зорилгоор хөрвүүлэн илэрхийлэв.



ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Говь ХК нь ноос ноолуурын салбарын тэргүүлэгч компанийн хувьд салбарын болоод улс орныхоо эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахыг эрхэмлэн ажилладаг. Бид хүрээлэн буй байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг ямагт тооцоолж, түүнээс сэргийлэн, нийгмийн хариуцлагаа ухамсарлан, малчид болон орон нутгийн байгууллагуудтай хамтран бэлчээрийн зөв зохистой ашиглалтыг дэмжин ажиллаж, байгальд ээлтэй техник технологийг эрэлхийлэн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, нөөцийн зүй зохистой хэрэглээг хэвшүүлэхийг зорьдог.

Энэхүү зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны үе шат бүртээ тогтвортой хөгжлийн түлхүүр болсон үзүүлэлтүүдийг орхигдуулалгүй уялдуулан, хэвшүүлж чадсанаар эрүүл эргэх холбоог цогцлоож чадах бөгөөд манай компанийн бизнесийн үйл ажиллагаа урт хугацаандаа улам бүр батжин, улс орныхоо ирээдүй, хойч үед өвлүүлэх баялаг бүтээгч болох болно.

Бид тогтвортой хөгжлийн хүрээнд:

- 2017 онд Олон улсын төрийн бус байгууллага Sustainable Fibre Alliance (SFA) буюу Тогтвортой ноос ноолуурын эвслийн гишүүнээр элссэн бөгөөд "Бэлчээрийн зохистой ашиглалт болон малын арчилгаа, маллагааны мөрдөх заалт"-ыг хэрэгжүүлэн тогтвортой байдлын үзэл баримтлалд нийцсэн ноолуур нийлүүлэх чадамжийг бий болгох тал дээр малчид, хоршоодтой хамтран ажиллаж байна.
- 2018 онд Монгол улсынхаа тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, тогтвортой бизнес эрхлэгчийн байр сууриа бататгах зорилгоор Монголын тэргүүлэгч компаниудтай нэгдэн Компанийн засаглалын хөгжлийн төв, ХБНГУ-ын Конрад Аденауэрын Сантай хамтран "Нийгмийн хариуцлагатай байж Монгол улсын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах компаниудын нэгдсэн эрмэлзэл"-д санаачилга гарган нэгдэж, салбарынхаа төлөөлөл, жишиг байгууллагаар сонгогдон ажиллаж байна.
- Мөн компанийн хэмжээнд тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахаар "Тогтвортой хөгжлийн баг"-ийг томилон шат дараатай ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2018 ОНД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД



SFA БУЮУ ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛТЭЙ ХАМТРАН "МАЛЧНЫ ХОТНООС ДЭЛХИЙН БРЭНД" ТӨСЛИЙГ САНААЧЛАН ЭХЛҮҮЛЭВ

Дорноговь аймгийн Дэлгэрэхийн улаан ямааны хоршоо, Баянхонгор аймгийн Залаа жинстийн торгон сүрэг хоршоонд Мал маллагаа болон Бэлчээр ашиглалтыг сайжруулах зорилгоор энэхүү төслийг эхлүүлсэн.

Тус төслийн хүрээнд Сургагч багшийн сургалтыг зохион байгуулан Хоршоодын төлөөлөлд төслийн талаар танилцуулж, мал арчилгаа, бэлчээр ашиглалтын талаар сургалт явуулж, тэднийг хоршооны гишүүддээ сургалт явуулахад нь туслах зааварчилгаа өгөв.

Цаашид хоршоодууд мал хэрхэн арчилж байгаа, бэлчээрээ мөн хэрхэн ашиглаж байгаа талаар хөндлөнгийн үнэлгээг хийж, дүгнэхээс гадна сургалт болон хөндлөнгийн үнэлгээгээр дамжуулан малчдад шийдэж зохицуулах шаардлагатай байгаа асуудлуудыг тодорхой болгож шийдвэрлэн, заавар зөвлөмжийг нарийвчлан гарган 2020 оны 6 сар хүртэл төслийг хэрэгжүүлэн ажиллана.



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАВ

Говь ХК нь ахуйн хог хаягдлыг "Эко-Орчин" ХХК-тай гэрээ байгуулан тээвэрлэн ачуулдаг бөгөөд эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг "Элемент" ХХК-иар тээвэрлүүлэх, ариутгах ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна.

2018 онд хог хаягдлын менежментийг сайжруулж, хогийн цэгийг шинэчилж хөрсөнд шингэхээс тусгаарлан битүүмжлэлтэй болгож хог хаягдлын цэг хүртэлх замыг хайрга дэвсэн сайжруулсан.

Мөн хог хаягдлыг цаас, хуванцар, лаг шороо, бусад гэсэн 4 төрлөөр ангилан ялгаж дахин ашиглагдах боломжтойг нь дахиварын үйлдвэрүүдэд өгч хог хаягдлаа эх үүсвэр дээр нь багасгах гэсэн менежмент хэрэгжүүлэн ажиллаж байна.



ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ХҮРЭЭНД ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭВ

2018 онд үйлдвэрлэлийн хүчин чадлаа өсгөн, 384 ажлын байрыг шинээр бий болгов. Үүнээс кеттель машин баригчийн сургалтын танхимаар 384 хүн сургасан бөгөөд 164 ажилтан үндсэн ажилтан болон ажиллаж байна. Түүнчлэн алслагдмал дүүрэг, захын хорооллын ажилгүй эмэгтэйчүүдийг цалинтай дадлагажуулан ажиллуулах болон амьдрах байраар хангаж байна.



Цаашид Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн удирдлагын тогтолцоо ISO 14001:2015 стандарт, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 45001:2018 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Говь ХК нь бүхий л үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагаа ухамсарлан бизнесийн үйл ажиллагаагаа шударгаар явуулж, нийгмийн хариуцлагын өндөр жишиг баримталдаг.

Бид хууль, дүрмийг чандлан сахиулан байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хүрээлэн буй орчин болон нийгмийн сайн сайханд чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаас гадна ажилтнуудынхаа ая тухтай, аюулгүй, ажиллах орчинг бүрдүүлэн нийгмийн асуудалд нь анхаарч, сурч боловсрох нөхцөлөөр ханган ажилладаг.

2018 ОНД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД НИЙГЭМ РҮҮ БОЛОН АЖИЛТНУУД РҮҮ ЧИГЛЭН ХИЙГДСЭН АЖЛУУД



КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГЫГ ШИНЭЧЛЭВ

Говь ХК-ийн нийгмийн хариуцлагын бодлогыг шинэчлэн боловсруулж, борлуулагдсан ноолууран пальто болон пиджак бүрээс 1,000 төгрөгийг хуримтлуулан нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд зориулахаар боллоо.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЦЭЦЭРЛЭГ ЯСЛИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭВ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолборт ГЭРЭЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ӨРӨӨ-г олон улсын стандартын дагуу зориулалтын тоноглоор тохижуулж, өрөөний дотор заслыг хийж гүйцэтгэв. Цаашид тус цэцэрлэг яслийн анги танхимын тохижилт, засварын ажлууд болон шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг ханган нийлүүлэхэд нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжин ажиллана.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭВ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бусдын тусламжгүйгээр ажиллаж хөдөлмөрлөх боломжтой ажлын байрны орчин, нөхцөлийг бий болгох зорилгоор компанийн орчныг сайжруулан, стандартын дагуу тохижуулах ажлыг шат дараатайгаар хийж байна.



ИРЭЭДҮЙН БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭЛТГЭН ХӨГЖҮҮЛЭВ

Боловсролын салбартай хамтын ажиллагааны хүрээнд оюутнуудын цалинтай болон цалингүй дадлагыг үйлдвэрийн байрандаа хийлгэх нөхцөлөөр ханган, мэргэжлийн сургалтын төв, коллеж, коосэн, их сургуулиудтай хамтран ажиллаж байна.

2018 онд нийт 237 оюутан богино хугацааны дадлага, 54 оюутан урт хугацааны дадлага хийсэн бөгөөд үүнээс 13 оюутанд Говь ХК-нд ажиллах урилга өгсөн билээ. Урилга авсан оюутнуудаас одоогийн байдлаар 11 оюутан ажиллаж байна.

Мөн Монгол-Солонгосын политехникийн коллежийн лабораторийг кеттель машинаар хангаж, ирээдүйн мэргэжилтэй, тогтвортой ажиллах хүчнийг бэлтгэх суурийг тавилаа.



АЖИЛТНУУДАА ХӨГЖҮҮЛЭН, ГАДААД УЛСАД СУРГАЛТУУДАД ХАМРУУЛАВ

Компанийн үнэ цэнэтэй баялаг болсон ажилтнуудынхаа өсч хөгжих, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд 2018 онд Итали, Япон, Унгар, Герман, Хятад гэсэн улсуудад нийт 32 ажилтныг урт болон богино хугацааны 10 төрлийн сургалтад хамруулан ажилтнуудынхаа хувь хүний өсөлт болон карьер хөгжилд нь үнэтэй хувь нэмэр оруулав.



АЖИЛЧДЫН ЦАЙНЫ ГАЗРЫГ ӨРГӨТГӨН ТОХИЖУУЛАВ

Эрүүл шим тэжээлтэй хоолоор ажилтнуудаа үнэ төлбөргүй ханган ажилладаг нь Говь ХК-ийн нэгэн давуу тал бөгөөд 2018 онд ажилчдын цайны газрыг өргөтгөн, тоног төхөөрөмжийг нь сайжруулан шинэчлэв. Улмаар нэг ээлжинд 600 хүн хүлээн авах хүчинтэй болсноор ажилтнууд 5 ээлжээр өдрийн хоолонд ордог байсныг 3 ээлжтэй болгож түргэн шуурхай үйлчлэх боломжтой боллоо.



АЖЛЫН БАЙРАН ДЭЭРХ ТОГТМОЛ ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЭВШҮҮЛЭВ

Ажилтнуудаа хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор үйлдвэр болон захиргааны нийт ажилтнуудыг өдөрт 2 удаа тогтмол дасгал хөдөлгөөн хийлгэх ажлыг эхлүүлэн, хэвшүүлж чадсан бөгөөд амжилттайгаар хэрэгжиж байна.



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ АЖИЛТНУУДАА ХАМРУУЛАВ

Ажилтнуудаа өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг бөгөөд 2018 оны хувьд Сөүл Сонгдо эмнэлэгтэй 2 дах жилдээ хамтран ажиллаж 1,556 ажилтныг үнэ төлбөргүй эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Засаглалын хувьд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь компанийн үйл ажиллагааг эрсдэлийн ерөнхий удирдлагаар ханган чиглүүлж, хяналт тавих чиг үүрэгтэй бөгөөд түүнээс томилогдсон Эрсдэлийн удирдлагын баг өдөр тутмын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Эрсдэлийн удирдлагын багийг компанийн удирдах албан тушаалтнууд бүрдүүлж байгаа бөгөөд Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал ахлан ажиллаж байна.

2018 оны хувьд эрсдэлийн удирдлагын зарчим ба заавар ISO 31000:2011 стандарт, COSO-ын заавар зөвлөмжүүдийг мөрдлөг болгон, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн сайжруулахад чиглэн дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

1. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог цогцоор нь бүрдүүлэн, хэрэгжүүлэх зорилгоор ТУЗ-ийн 2018 оны 12 сарын 21-ний №33 тоот тогтоолоор ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО-ыг баталсан.
2. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2018 оны 11 сарын 14-ний А/5008 тоот тушаалаар ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ-ыг шинэчлэн баталсан.
3. Эрсдэлийн удирдлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хяналт тавин ажиллах зорилгоор ЭРСДЭЛИЙН МЕНЕЖЕР-ийн орон тооны албан тушаалыг бий болгосон.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Энэхүү бодлого нь ТУЗ-өөс батлагдсан бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүн дотроо эрсдэлийн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийг хариуцах албан тушаалтныг тодорхойлох үйл ажиллагааг зохицуулна.

Эрсдэлийг эрэмбэлэх хүснэгт:

Компанид учирч болзошгүй эрсдэлт хүчин зүйлийг үзүүлэх үр нөлөө ба тохиолдох магадлалын шалгуураар үнэлэн, эрсдэлд эрэмбэ, дараалал тогтоосон.


2019 онд эрсдэлийн зөвшөөрөх хэмжээг 4 эрэмбэ /бага, дунд, их, маш их/ болгон өөрчилж баталсан.

			Үр нөлөө				
			Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
			1	2	3	4	5
Магадлал	Маш их	5	5	10	15	20	25
	Их	4	4	8	12	16	20
	Дунд	3	3	6	9	12	15
	Бага	2	2	4	6	8	10
	Маш бага	1	1	2	3	4	5

- Ногоон: Бага эрэмбийн эрсдэл /Эрсдэлийг хяналттайгаар хүлээн зөвшөөрч болох бөгөөд Хэлтсийн дарга болон Үйлдвэрийн дарга нар хариуцан удирдана./
- Шар: Дунд эрэмбийн эрсдэл /Эрсдэлийг байнгын хяналтад байлгах бөгөөд Газрын захирал болон Үйл ажиллагаа хариуцсан захирал хариуцан удирдана./
- Улбар шар: Их эрэмбийн эрсдэл /Эрсдэлийг байнгын хяналтад байлгах бөгөөд Эрсдэлийн удирдлагын баг хариуцан удирдана./
- Улаан: Маш их эрэмбийн эрсдэл /Эрсдэлээс зайлсхийх, нэгэнт тохиолдсон бол эрсдэлийн үр нөлөөг нэн яаралтай бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ, Гүйцэтгэх захирлын хүрээнд шийдвэрлэж, үлдсэн эрсдэлийг удирдах, хяналтын арга хэмжээнүүдийг байнга хэрэгжүүлнэ./

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Эрсдэлийг удирдахын тулд таван үе шаттай мөчлөг бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.




Журмын шинэчлэлтийн хүрээнд:

- Эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, мониторинг хийх аргачлалуудыг улам сайжруулсан.
- Эрсдэлийн ангиллуудыг бий болгож, эрсдэл тодорхойлох мөчлөг, эрсдэлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг нэмж, шинэчилсэн.
- Эрсдэлийн арга хэмжээний хэд хэдэн хувилбарыг боловсруулах болон шаталсан түвшний шийдвэр гаргалтуудыг журмаар тодорхойлсон байна.

2018 ОНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЙЛАН

2018 онд компанийн хэмжээнд нийт 203 эрсдэлийг тодорхойлсон. Үр нөлөөгөөр нь авч үзвэл:



Эрсдэлийн удирдлагын баг болон нийт ажилтнуудын хичээл зүтгэлээр эрсдэлийн эрэмбийг амжилттай бууруулсан ба цаашид бага эрэмбэд орсон эрсдэлийг байнга хянаж, дунд түвшинд хүргэхгүй байхыг эрмэлзэн ажиллаж байна.

Гэсэн хэдий ч, гадаад орчны нөлөөллөөс үүдэн бий болох түүхий эдийн үнийн өсөлт, валютын ханшийн алдагдалд өртөх эрсдэл байсаар байна.

Цаашид байгалийн гамшиг, гэнэтийн аюул осол тохиолдсон үед Эрсдэлийн удирдлагын баг болон Гамшгаас хамгаалах бүлгийн гишүүд батлагдсан "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-ний дагуу арга хэмжээг авч ажиллана. Мөн компанид үүсч болзошгүй эрсдэлт хүчин зүйлийг Эрсдэлийн удирдлагын багийн түвшинд улирал бүр илрүүлэн, үнэлж шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллах болно.

ЧАНАРЫН УДИРДЛАГА

Говь ХК нь түүхий эдээ малчдын гараас хүлээн авахаас эхлэн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л шат дамжлагад 230 үзүүлэлтээр чанарын шалгалтыг хийж, технологийн горимыг чанд мөрдөн, бүтээгдэхүүнээ олон улсын ISO 9001:2008/MNS ISO 9001:2010, ISO/IEC 17025 стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж, баталгаажуулан дотоод, гадаадын хэрэглэгчдэд хүргэдэг.

Бид хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр үйлдвэрлэлийн шат дамжлага бүрээр чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн, чанарын 69 MNS стандарт, компанийн нийт 73 журам, стандарт, технологийн горим, ажлын зааварчилгааг мөрдөж, чанарын хяналт шалгалтыг 100% хийж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

2019 онд бид Олон улсын чанарын ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх бөгөөд, Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандарт болон Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх бэлтгэлийг ханган ажиллахаар төлөвлөж байна.



1994 онд- ISO 9001 олон улсын стандарт Чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ



1997 онд- "Үндэсний тохирлын тэмдэг" тэмдэг хэрэглэх гэрчилгээ



1999 онд- ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC 17025:2007) стандартын шаардлага хангасан "Хэмжих хэрэгслийн лаборатори"



1999 онд - ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC 17025:2007) стандартын шаардлага хангасан "Нэгдсэн лаборатори"



ГОВЬ ХК
БОЛОН ТҮҮНИЙ ОХИН
КОМПАНИУДЫН

НЭГТГЭСЭН
САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОР

Говь ХК-ийн Эрсдэл аудитын хороо нь хараат бус аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэх ба хараат бус аудиторын уг шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд дүгнэлт хийн, бие даан шууд сонгох, аудитортой байгуулах гэрээг батлах, хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавих, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, гэрээг цуцлах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Говь ХК-ийн 2018 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн тайланд Деллоитт Онч Аудит ХХК аудит хийсэн. Деллоитт нь олон улсын 4 том аудитын компанийн нэг бөгөөд 2012 оноос эхлэн Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа, 2014 онд Санхүүгийн зохицуулах хороонд Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх Аудитын компаниар бүртгэгдсэн.

Деллоитт Онч Аудит ХХК-тай хийсэн гэрээт ажлын хөлс 110,000,000 /нэг зуун арван сая/ төгрөг.

GOBI
MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
 БОЛОН ХАРААТ БУС АУДОРЫН
 ТАЙЛАН**

2018 ОНЫ 12 САРЫН 31

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2018 ОНЫ 12 САРЫН 31

АГУУЛГА

Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл
Хараат бус аудиторын тайлан

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	1
Нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлан	2
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	3
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд	5

ХУУДАС



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот 17062, Хан-Уул дүүрэг
3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Утас: 70135511
Факс: 70143081, УБ-36 Ш/х №434
И-мэйл: info@gobi.mn Вэб сайт: www.gobi.mn
УБД: 9010001061

2019.03.07 № 01/139
төний _____ ны № _____ -д

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Цагаач овогтой Баатарсайхан би “Говь” ХК болон түүний охин компаниуд (цаашид Групп гэх)-ын Гүйцэтгэх захирлын хувьд, Ганболд овогтой Сэлэнгэ би тус Группын Санхүү Бүртгэл Удирдлагын Газрын захирлын хувьд ард хавсаргасан 1-ээс 4-р хуудас дахь “Говь” ХК болон түүний охин компаниудын нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх Группын санхүүгийн байдал ба уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг шударгаар үзүүлж байна гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Ц. Баатарсайхан
Гүйцэтгэх захирал

Г. Сэлэнгэ
Санхүү Бүртгэл Удирдлагын Газрын захирал



Делоитт Онч Аудит ХХК
15 давхар, Ай Си Си цамхаг
Жамьяан гүнгийн гудамж
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар, 14240
Монгол улс

Утас: +976 70100450
+976 70120450
Факс: +976 70130450
www.deloitte.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчид танаа,

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид Говь ХК (цаашид "Компани" гэх) ба түүний охин компаниуд (хамтад нь "Групп" гэх)-ын 2018 оны 12 сарын 31-ний нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Группын 2018 оны 12 дугаар сарын 31-ний нэгтгэсэн санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу Группээс хараат бус ба НБЁЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр Аудитын гол асуудлууд нь тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудлууд юм. Нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлууд тус бүрт тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудлууд

Бараа материалын үнэлгээ

Удирдлага удаан гүйлгээтэй болон хуучирсан бараа материалын хасагдуулгыг тодорхойлохдоо үлэмж хэмжээний төсөөлөл болон үнэлэмж ашигладаг учраас бид бараа материалын үнэлгээг аудитын гол асуудал гэж үзсэн. Группын нягтлан бодох бүртгэлийн бодлогоор бараа материалын үнэлгээг тооцохдоо бараа материалын насжилт дээр үндэслэн өмнөх жилүүдийн туршлага, түүхэн мэдээлэлд үндэслэн тооцсон алдагдлын хувийг ашиглан тооцдог.

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 3 болон Тодруулга 8-д тусгаснаар, Группын 2018 оны 12 сарын 31-нээрх бараа материалын дансны үнэ нь 142,538,944 мянган төгрөг (856,406 мянган төгрөгийн бараа материалын хасагдуулгыг хасч тооцсон цэвэр дүн) байна.

Бидний гүйцэтгэсэн аудитын горим

Бараа материалын үнэлгээтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо ашигласан удирдлагын үнэлгээ болон бараа материалыг тэдгээрийн цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл залруулж, бараа материалын сан байгуулах дотоод горимыг судлах, ойлгох;
- Борлуулалтын түүхэн мэдээ, өнөөгийн зах зээлийн орчин, маркетинг болон урамшууллын төлөвлөгөө, бараа материалын насжилт болон бараа материалын борлуулалтын үнэ зэрэгт үндэслэн бараа материалын хасагдуулга нь зохистой эсэхийг үнэлэх;
- Түүврийн аргаар бараа материалын насжилтыг холбогдох анхан шатны баримтууд руу тулгаж шалгах;
- Түүврийн аргаар бараа материалын борлуулалтын үнийг холбогдох анхан шатны баримтууд руу тулгаж шалгах.

Делоитт нь Нэгдсэн Вант улсад анх үүсгэн байгуулагдсан Делоитт Түш Тохмац Лимитед (ДТТЛ) болон түүний гишүүн байгууллагууд, харьяа компаниудаас бүрдэнэ. ДТТЛ болон түүний гишүүн компаниуд нь бие даасан хуулийн этгээдүүд байх бөгөөд үйл ажиллагааны хувьд хараат бус байна. ДТТЛ (мөн "Делоитт Глобал" гэх) нь харилцагчдад үйлчилгээ үзүүлдэггүй. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.deloitte.com/about цахим хуудаснаас авна уу.

Делоитт нь аудит, консалтинг, санхүүгийн зөвлөх үйлчилгээ, эрсдлийн удирдлага, татвар болон холбогдох чиглэлээр төрөл бүрийн салбар дахь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Делоитт Онч ХХК болон түүний охин компаниуд нь аудит, эрсдлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө үзүүлэх мэргэжлийн үйлчилгээгээрээ дамжуулан Монголын харилцагчдад мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд Делоиттын олон улсын сүлжээний гишүүн байгууллага юм.

© 2019. Делоитт Онч ХХК болон харьяа компаниуд



Аудитын гол асуудлууд

Татварын тооцооллын үнэн, зөв байдал

Группын татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Групп татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Групп-д татварын эрсдэл байсаар байна.

Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдал

2018 оны 12 сарын 31-нээрх хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт 462,385 мянган төгрөг байсан. Энэхүү дүн нь тайлант жилийн эцсээрх хүлээгдэж буй авлагын алдагдлыг илэрхийлнэ. Групп 2018 оны 1-р сарын 1-нд "СТОУС 9 Санхүүгийн Хэрэгсэл"-ийг хэрэгжүүлсэн. СТОУС 9-ын хэрэгжүүлэлтээр санхүүгийн хөрөнгийн ангилалд нөлөөлөөгүй хэдий ч Хүлээгдэж буй Авлагын Алдагдлын загварыг нэвтрүүлсэн. Зохистой хэмжээний үнэ цэнийн бууралтын алдагдлыг тодорхойлох нь аудитын гол асуудлын нэг бөгөөд уг дүнг тодорхойлохын тулд удирдлагын үнэлэмжийг шаарддаг ба тооцооллын тодорхойгүй байдал болон боломжит бэлэн байгаа мэдээллийг ашигладаг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотой тооцооллын тодорхойгүй байдлын гол эх сурвалж болон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга 2.10 болон 3.2-д тодруулсан.

2018 оны 12-р сарын 31-нээрх Группын дансны ба бусад авлагын дансны дүн нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 3 болон Тодруулга 6-д тусгаснаар, 12,183,569 мянган төгрөг (462,385 мянган төгрөгийн хүлээгдэж буй авлагын алдагдлыг хасч тооцсон цэвэр дүн) байна.

Бидний гүйцэтгэсэн аудитын горим

Татварын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- Татварын тооцоолол ба түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын талаарх удирдлагын байр суурь, үнэлгээг судлах, ойлгох;
- Татварын хууль, журам болон практикийн туршлагатай өөрсдийн татварын мэргэжилтнүүд болон Групп ба эрх бүхий татварын албадууд хоорондын харилцааг ашиглан санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөрүүд нь зохистой эсэх, эсвэл татварын өр төлбөрийг бүртгээгүй үндэслэл шалтгааныг үнэлэх;
- Санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөр болон тодруулга нь хангалттай эсэх, уг өр төлбөр нь татварын хуулийн сүүлийн өөрчлөлтүүдийн дагуу тооцоологдсон эсэх, боломжит татварын торгууль болон хүүг агуулсан эсэхийг үнэлэх.

Бид удирдлагын тооцооллын арга нь зохистой эсэхийг дараах байдлаар авч үзсэн:

- Бид Группын үнэ цэнийн бууралтыг тооцоолох шинэ аргыг үнэлсэн ба СТОУС 9-ын шаардлагуудтай харьцуулсан.
- Бид тооцоололд ашигласан мэдээллийн үнэн зөв болон бүрэн байдлыг шалгасан.
- Бид СТОУС 9- тэй нийцүүлэхийн тулд СТОУС 7-д хийгдсэн тодруулгын өөрчлөлтийг хянасан.

Бидний гүйцэтгэсэн шалгалтаар үнэ цэнийн бууралтын сан нь зохих хэмжээнд байсан.

Deloitte.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ын дарга болон Гүйцэтгэх захирлын мэндчилгээ орно. Бусад мэдээлэл нь энэхүү аудитын тайланг гаргасан өдрөөс хойш бэлтгэгдэж, бидэнд хүргүүлэхээр байна.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд бид бусад горимыг гүйцэтгэж, дараах зүйлсийг тодорхойлно:

- Бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний алдаатай эсэх;
- Группын санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай эсэх; эсвэл
- Группын болон түүний орчны талаарх бидний ойлголтыг шинэчлэх хэрэгтэй эсэх.

Хэрэв бид бусад мэдээлэлд материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг нь залруулаагүй бол, бид залруулагдаагүй материаллаг хэмжээний алдааг манай тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд зохистой арга хэмжээ авахыг засаглах эрх бүхий этгээдээс хүсэх болно.

Хэрэв бид Группын аудитлагдсан санхүүгийн тайлан болон Группын болон түүний орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээг авна.

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Группыг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага Группын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Группын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудитын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглан, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлон үнэлж, үг эрсдлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авсан. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс өндөр байдаг. Учир нь залилангийн үед хуйвалдаан, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл хэрэгжүүлэх явдлууд тохиолдсон байж болдог.

Deloitte.

- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Группын дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн таамаглал болон холбогдох тодруулгуудын бодитой байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцлийг үргэлжлүүлэн хангах Группын чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл аудитын дүгнэлт болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулдаг ба уг тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь манай аудитын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэсэн байдаг. Хэдий тийм боловч ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Группыг үйл ажиллагаагаа явуулахад нь саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлдэг. Үүнд тодруулгаас гадна санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг үнэлэхийн тулд ажил гүйлгээ, үйл явдлуудыг толилуулсан эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд Группын доторх компаниуд болон бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээллийн талаарх зохистой аудитын нотолгоо олж авсан. Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэл болон түүнийг удирдан зохион байгуулахтай холбоотой үүргийг хүлээдэг. Мөн бид өөрсдийн аудитын дүгнэлтийн талаар үүрэг хүлээдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудаар холбогддог ба үүнд аудитын үеэр аудитын илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц алдаа болон дутагдал орно.

Бусад хууль эрх зүйн шаардлагуудын талаарх тайлан

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92 болон 94-р зүйлийн дагуу бид дараах тохиолдлуудад та бүхэнд тайлагнах үүрэгтэй:

- Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ;
- Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалттай холбоотой зөрчил;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл; болон
- Компанийн дүрмийн дагуу болон аудитын гэрээний дагуу шаардагдах бусад мэдээлэл

Дээрх зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Энэхүү хараат бус аудитын тайлангийн аудитын партнер нь Ш.Норжинбат юм.

Ш.Норжинбат
Захирал, МНБ
Делойтт Онч Аудит ХХК
2019 оны 3-р сарын 7

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2018 ОНЫ 12 САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2018	2017
Хөрөнгө			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	4,940,940	7,183,762
Дансны ба бусад авлага	6	12,183,569	11,644,199
Урьдчилгаа төлбөр	7	4,690,681	2,811,450
Бараа материал	8	142,538,944	101,271,760
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	9	268,017	-
		164,622,151	122,911,171
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	10	82,380,060	57,274,775
Хойшлогдсон татварын хөрөнгө	22.3	1,250,554	83,931
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	12	355,697	459,043
		83,986,311	57,817,749
Нийт хөрөнгө		248,608,462	180,728,920
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч			
<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
Дансны ба бусад өглөг	13	4,741,052	6,372,509
Орлогын албан татварын өглөг	22.2	1,755,234	1,971,410
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	14	466,329	-
Гэрээний өр төлбөр	13.1	1,037,239	-
Богино хугацаат банкны зээл	15	113,722,628	40,469,033
		121,722,482	48,812,952
<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
Урт хугацаат өглөг	16	3,231,805	-
Урт хугацаат банкны зээл	15	6,000,000	30,202,780
		9,231,805	30,202,780
Нийт өр төлбөр		130,954,287	79,015,732
Эзэмшигчдийн өмч			
Хувьцаат капитал	17	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	20	15,647,697	15,647,697
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	21	(135,203)	(28,274)
Хуримтлагдсан ашиг		101,361,568	85,313,652
		117,654,175	101,713,188
Нийт өр төлбөр ба Эзэмшигчдийн өмч		248,608,462	180,728,920

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2018	2017
Борлуулалтын орлого	23.1	173,439,375	124,425,107
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	23.2	(102,147,527)	(73,880,650)
Нийт ашиг		71,291,848	50,544,457
Санхүүгийн ба бусад орлого	24	542,045	848,816
Бусад (гарз) ба олз	25	(6,561,605)	(571,863)
Хүүгийн зардал		(10,521,942)	(6,496,773)
Борлуулалт ба маркетингийн зардал	23.3	(20,210,195)	(12,121,296)
Ерөнхий ба удирдлагын зардал	23.3	(11,290,196)	(8,761,080)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт		(1,523)	-
Татварын өмнөх ашиг		23,248,432	23,442,261
Орлогын татварын зардал	22	(5,484,268)	(5,939,277)
Тайлант жилийн цэвэр ашиг		17,764,164	17,502,984
Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдах бусад иж бүрэн орлого:			
Гадаад дахь охин компаниас үүссэн валют хөрвүүлэлтийн зөрүү	21	(106,929)	(28,274)
Бусад иж бүрэн алдагдал		(106,929)	(28,274)
Нийт иж бүрэн орлого		17,657,235	17,474,710
		(Дахин тайлагнасан)	
Нэгж хувьцаанд ногдох ашиг - суурь	19	0.02	0.02
Нэгж хувьцаанд ногдох ашиг - хорогдуулсан		0.02	0.02

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тод-руулга	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл (тодруулга 20)	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц (тодруулга 21)	Хуримтлагдсан ашиг	Нийт
2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		780,113	15,647,697	-	69,370,893	85,798,703
Тайлант жилийн цэвэр ашиг		-	-	-	17,502,984	17,502,984
Бусад иж бүрэн алдагдал	21	-	-	(28,274)	-	(28,274)
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого		-	-	(28,274)	17,502,984	17,474,710
Зарласан ногдол ашиг	18	-	-	-	(1,560,225)	(1,560,225)
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		780,113	15,647,697	(28,274)	85,313,652	101,713,188
Тайлант жилийн цэвэр ашиг		-	-	-	17,764,164	17,764,164
Бусад иж бүрэн алдагдал	21	-	-	(106,929)	-	(106,929)
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого		-	-	(106,929)	17,764,164	17,657,235
Зарласан ногдол ашиг	18	-	-	-	(1,716,248)	(1,716,248)
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		780,113	15,647,697	(135,203)	101,361,568	117,654,175

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2018	2017
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн цэвэр ашиг		17,764,164	17,502,984
Тохируулгууд:			
Элэгдэл ба хорогдлын зардал	10, 12.1	6,558,878	5,633,556
Орлогын татварын зардал	22	5,484,268	5,939,277
Хүүгийн зардал		10,521,942	6,496,773
Хүүгийн орлого	24	(228,987)	(606,757)
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алдагдал		5,394,904	149,478
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	6.3	1,523	-
Бараа материалын хасагдуулгын зардал/(буцаалт)	8	120,103	(169,909)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	25	181,707	181,228
Үндсэн хөрөнгө болон бараа материалыг бүртгэлээс хассанаас илүү давсан даатгалын нөхөн олговор	25	-	(383,784)
		45,798,502	34,742,846
Дансны ба бусад авлагын өсөлт		(1,146,933)	(5,545,377)
Урьдчилгаа төлбөрийн өсөлт		(1,564,247)	(353,745)
Бараа материалын өсөлт		(41,387,287)	(43,127,472)
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгийн өсөлт		(268,017)	-
Дансны ба бусад өглөгийн өсөлт		439,989	2,235,534
Гэрээний өр төлбөр болон буцаах эрхтэй барааны өр төлбөрийн бууралт		(134,913)	-
		1,737,094	(12,048,214)
Төлсөн орлогын татвар	22.2	(6,867,067)	(6,312,721)
Төлсөн хүү		(9,444,335)	(6,183,446)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(14,574,308)	(24,544,381)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хүлээн авсан хүүгийн орлого		228,987	606,757
Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө		99,506	245,456
Даатгалын нөхөн олговороос орж ирсэн мөнгө		-	4,400,000
Худалдан авсан үндсэн хөрөнгө		(28,077,935)	(14,530,295)
Худалдан авсан бусад эргэлтийн бус хөрөнгө	12.1	(105,736)	(38,503)
Холбоотой талд өгсөн санхүүжилт	26.2	(3,000,314)	(11,430,480)
Холбоотой талд өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	26.2	3,000,314	25,430,480
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(27,855,178)	4,683,415
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Авсан зээл	15.2	186,137,535	100,162,894
Төлсөн зээл	15.2	(144,231,210)	(74,023,755)
Төлсөн ногдол ашиг	18	(1,717,781)	(1,681,761)
Холбоотой талаас авсан санхүүжилт	15.2	5,586,782	17,046,070
Холбоотой талаас авсан санхүүжилтинд төлсөн дүн	15.2	(5,586,782)	(17,046,070)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		40,188,544	24,457,378
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл		(1,880)	(26,920)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн (бууралт)/өсөлт		(2,242,822)	4,569,492
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		7,183,762	2,614,270
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5	4,940,940	7,183,762

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Говь ХК (цаашид "Компани" гэх) нь 1981 онд Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан. Компанийн толгой компани нь Таван Богд Кашмер ХХК бөгөөд уг толгой компанийн голлох хувьцаа эзэмшигч нь Ц.Баатарсайхан юм.

2018 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Компани болон түүний охин компаниуд (хамтад нь "Групп" гэх)-ын нэгтгэсэн санхүүгийн тайлангаас бүрдэж байна.

Группын охин компаниудын мэдээллийг тодруулга 11-с харна уу.

Групп нь 2017 болон 2018 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд сүлжмэл, оёмол, нэхмэл бүтээгдэхүүн, түүхий эд материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг борлуулах болон хуурай хими цэвэрлэгээ, оёх, сүлжих захиалгат ажил зэрэг холбогдох үйлчилгээг үзүүлсэн.

Группын албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо Говь Хувьцаат Компанийн байр болно.

Группын удирдлага аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг 2019 оны 3-р сарын 7-нд батлан гаргасан.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

2.1 Мөрдсөн стандарт

Группын нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-с гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Группын үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн.

Бүх санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлсэн.

2.3 Нэгтгэлийн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Компанийн болон Компанийн хяналтанд байдаг охин компаниудын санхүүгийн тайлангуудаас бүрддэг. Хяналт байгаа эсэхийг дараах элементүүдээр хэмждэг:

- Санхүүжигчид үзүүлэх нөлөө;
- Санхүүжигчийн өгөөжөөс хүртэх эрх;
- Санхүүжигчийн өгөөжөөс хүртэх дүнд нөлөөлөх чадвар.

Компани санхүүжигчид хяналт тогтоож байгаа эсэхийг дээрх гурван элементүүдэд өөрчлөлт гарсан эсэхээр дахин үнэлдэг.

Компани охин компанийг хяналтандаа оруулсан өдрөөс эхлэн нэгтгэсэн санхүүгийн тайланд уг охин компанийг нэгтгэх ба охин компани дахь хяналтаа алдсан өдрөөс эхлэн нэгтгэхээ зогсоодог. Тусгайлан, охин компанийн тайлант жилийн орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахдаа тухайн охин компани дахь хяналтыг олж авсан өдрөөс тухайн охин компани дахь хяналтаа алдсан өдөр хүртэлх тайлант жилийн орлого, зардлыг ашиг алдагдал болон бусад нэгтгэсэн иж бүрэн орлогын тайланд нэгтгэдэг. Хэрэв шаардлагатай бол, Группын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд охин компанийн санхүүгийн тайланд тохируулга хийж болно.

Толгой болон охин компаниудын хооронд гарсан орлого, зардал, мөнгөн гүйлгээ болон хөрөнгө, өр төлбөр, өмчийн дансдын үлдэгдлийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн устгана.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.4 Бараа материал

Бараа материалыг жигнэсэн дундаж өртгийн арга, цэвэр боломжит үнэ цэнээр тооцоолсон худалдан авалт ба үйлдвэрлэлийн өртгөөр хэмжинэ. Худалдан авах зардал нь тайлант хугацаанд худалдан авалтын холбогдох нэмэлт зардлыг агуулдаг. Үйлдвэрлэлийн зардал нь шууд хамааралтай зардлууд ба бүтээгдэхүүнтэй холбоотойгоор шууд бус зардлын зарим хэсгийг багтаана. Цэвэр боломжит үнэ цэнэ нь тооцоолсон борлуулалтын үнээс холбогдох гүйцэтгэлийн зардал болон борлуулалтын зардлыг хассан дүн юм.

Бараа материалын хэрэглээний болон цэвэр боломжит үнэ цэнийг харгалзан материал, бүтээгдэхүүний хувьд хасагдуулга нөөцийг шаардлагатай үед тодорхойлно.

2.5 Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөр эсвэл бараа материалаа хүлээн аваагүй төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдал руу, бараагаа хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө руу ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагдах бол урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст Групп урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнийн цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

2.6 Үндсэн хөрөнгө

Групп газрын эрхийг санхүүгийн түрээсээр хөрөнгөөр бүртгэдэг ба хөрөнгийг олз эзэмшсэн бодит үнэ цэнээр анх бүртгэдэг. Монгол улсын Газрын тухай хууль гарахаас өмнө олж эзэмшсэн газрын эрх нь ерөнхийдөө тэг үнэтэй байдаг ба уг хууль 2003 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Монгол улсын Газрын тухай хууль нь Монгол улсын аж ахуйн нэгжүүдэд газрын эрх эзэмших эрх зүйн үндсийг тогтоосон.

Газрын эрхийг хувь хүн болон бусад аж ахуйн нэгжүүдээс худалдан авсан бол худалдан авсан өдрөөрх зах зээлийн үнээр бүртгэсэн. Групп газрын эрх эзэмшиж буй бол Засгийн Газарт их хэмжээний бус газрын төлбөр төлдөг.

Газрын дансны үнэ нь худалдан авахад төлсөн нийт төлбөрийн дүнтэй тэнцүү ба газрын эрхийн хугацааг ирээдүйд урт хугацаагаар сунгах боломжтой.

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Тайлант үеийн эцэст газар болон барилгаас бусад үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

Дахин үнэлсэн дүнгээр илэрхийлэгдсэн газар болон барилгыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тэдгээрийн дахин үнэлсэн дүнгээр тайлагнах ба мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээчний зах зээлийн бодит нотолгоонд үндэслэн дахин үнэлсэн өдрийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмждэг. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлдог.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.6 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг. Дахин үнэлсэн хөрөнгийг худалдах эсвэл ашиглалтаас хасах үед дахин үнэлгээний санд үлдсэн нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлнэ.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар Групп-д эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дүнгээр хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг.

Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ.

Газар болон дуусаагүй барилгаас бусад үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг. Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

Газар	Элэгдэл байгуулдаггүй
Барилга байгууламж	10 - 40 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Тавилга, эд хогшил, компьютер	3 - 10 жил
Тээрийн хэрэгсэл	10 жил

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

2.7 Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолсон. Тооцоолсон ашиглалтын жил болон элэгдэл бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн.

Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 3-аас 10 жил.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

2.8 Биет ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант үеийн эцэст биет хөрөнгийн дансны үнийг үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлох шалгалтанд хамруулдаг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын алдагдал (ийм алдагдал гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол үг хөрөнгийн харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах боломжийн бөгөөд тууштай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд тууштай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хамааруулан шалгадаг.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.8 Биет ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Хөрөнгийн эсвэл "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийн бодит үнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн ба хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж хоёрын аль ихээр нь тогтоогдоно. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Үнэ цэнэ бууралтын шалгалтын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг цаашид ашигласнаар бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс ("мөнгөн орлого үүсгэгч нэгж") хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжтой тооцоолсон үнээс их байвал үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэж, нэгтгэсэн иж бүрэн орлогын тайланд тусгана. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн хувьд тодорхойлсон үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэхдээ эхлээд тухайн нэгжид хуваарилагдсан гүүдвилийн дансны үнийг бууруулах ба үлдсэн алдагдлын дүнгээр тухайн нэгж (бүлэг нэгж)-д багтсан бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна.

Өмнөх жилүүдэд бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдал буурсан эсвэл алдагдал үгүй болсон эсэхийг илрүүлэхийн тулд үнэ цэнэ бууралтын алдагдлыг тайлангийн өдрөөр дахин хянана. Нөхөгдөх боломжтой дүнг тодорхойлоход хэрэглэсэн тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана. Үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан элэгдэл хорогдлыг хассан хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

2.9 Санхүүгийн хэрэгслүүд

Групп тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Санхүүгийн хэрэгсэл (бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл ба өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасч бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг шууд тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

2.10 Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран санхүүгийн хөрөнгийг анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

2.10.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал

Дараах нөхцлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ:

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг;
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

2.10.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал (үргэлжлэл)

Дараах нөхцлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг хэмжихдаа бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор тусгана (БУЦБИБОУ):

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг;
- Тодорхойлон заасан өдрүүдэд зөвхөн төлөгдөөгүй үлдсэн үндсэн төлбөр ба хүү төлөлтийн мөнгөн урсгалыг хүлээн авах санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлтэй байх

Бусад санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг (БУЦАА).

Дээр дурдсанаас үл хамааран, Групп санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед дараах ангиллыг сонгон бүртгэж болно:

- Групп тодорхой шалгууруудыг хангасан тохиолдолд буцаах сонголтгүйгээр өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтыг дараа үеүдэд хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад иж бүрэн орлогоор тусгана.
- Групп өрийн хэрэглүүрээр хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад иж бүрэн орлогоор бүртгэх зарчмыг сонгосон байсан боловч бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тайлагнах нь илүү тохиромжтой, бүртгэлийн нийцгүй байдлыг арилгана гэж үзэж байвал бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлыг тусгаж болно.

Группын санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгөөс бүрдэж байна.

(i) Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцолон, хүүгийн орлогыг хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад (анхлан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө) санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууралтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм. Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн урсгалыг тооцоолох үед ирээдүйн нийт хугацаанд хүлээгдэж буй авлага ба зээлийн алдагдлыг оруулан тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг ашиглан өрийн хэрэглүүрийг анхлан хорогдуулан бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, анхны дүн ба дуусгавар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүний арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно. Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь дараа үеүдэд тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор тусгах эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан бүртгэлд тусгадаг. Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд, дараа үед үнэ цэнэ буурсан зээл ба авлагаас бусад, санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүний түвшинг ашиглан авлага ба зээлийн дансны дүнгээс хүүгийн орлогыг тооцно. Санхүүгийн хөрөнгийн анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээл ба авлагын үнэ цэнийн бууралт бий болсон санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүний түвшинг ашиглан аливаа алдагдлын нөөцийг багтаасан цэвэр дансны дүнгээс хүүний орлогыг тооцно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

2.10.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал (үргэлжлэл)

Хэрэв дараагийн тайлагналын үеүдэд, үнэ цэнэ буурсан зээл ба авлагын санхүүгийн хэрэгслийн эрсдэл буурч, үнэ цэнийн бууралтгүй болох үед үр ашигт хүүгийн түвшинг ашиглан санхүүгийн хөрөнгийн дансны дүнгээс хүүгийн орлогыг тооцно.

Групп худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд анх хүлээн зөвшөөрсөн гэрээний мөнгөн урсгалыг тооцоолох үед ирээдүйн нийт хугацаанд хүлээгдэж буй авлага ба зээлийн алдагдлыг оруулан тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг тооцоолон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлагналын үеүдэд, үнэ цэнэ буурсан зээл ба авлагын санхүүгийн хэрэгслийн эрсдэл буурч, үнэ цэнийн бууралтгүй болсон тохиолдол цэвэр дансны дүнгээс тооцно.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба "санхүүгийн болон бусад орлого - хүүгийн орлого" хэсэгт ангилна.

2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Групп хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтанд хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрөн бүртгэдэг. Тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээгдэж буй алдагдлын дүн анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш эрсдэлийн өөрчлөлтийг үнэлж тайлант хугацаа болгонд шинэчилнэ.

Групп дансны авлагад нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолон бүртгэдэг. НББОУС 39-ийн дагуу үнэ цэнийн бууралттай авлагаас бусад дансны авлагын үлдэгдэл нь 400 сая төгрөгөөс давсан бөгөөд даатгагдаагүй авлагыг тусгайлан үнэлж, үлдсэн авлагын дүнг хугацаа хэтэрсэн хоногт үндэслэн багцын аргаар тооцсон. Эдгээр санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо алдагдлын түүхэн мэдээллийг зээлдэгчдэд тусгайлан тодорхойлсон хүчин зүйлс, үндсэн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нөхцөл байдал, одоогийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг тайлагналын өдрөөр харгалзан тохируулсан матрицыг ашиглан тооцоолж болох бөгөөд уг тооцоололд тохиромжтой гэж үзвэл мөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалзан үзэж болно.

Нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдал нь санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид гарах бүхий л боломжит дефолт үйл явдлаас үүсэх алдагдлыг илэрхийлнэ.

(i) Зээл ба авлагын эрсдлийн мэдэгдэхүйц өсөлт

Санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэл нь анх бүртгэлд тусгаснаас хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ Групп анх бүртгэлд тусгасан өдрийн санхүүгийн хэрэгслээс үүссэн эрсдлийг, тайлант өдрөөрх эрсдлийн дүнтэй харьцуулдаг. Энэхүү үнэлгээг хийхдээ Групп үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц тоон болон чанарын мэдээллийн аль алиныг нь харгалзан үзэх ба эдгээр нь түүхэн туршлага болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахааргүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд байна.

Ирээдүйг таамаглаж буй мэдээлэл нь Группын зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын ирээдүйн хэтийн төлвийг агуулсан, эдийн засгийн шинжээчийн тайлангаас авсан мэдээлэл болон санхүүгийн шинжээч, засгийн газрын байгууллага, холбогдох судалгааны байгууллага, бусад ижил төстэй байгууллагаас гаргасан мэдээллүүд болон Группын үндсэн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн бодит болон урьдчилан таамагласан янз бүрийн гадаад эх сурвалжийн мэдээллүүдийг авч үздэг.

Зээл ба авлагын эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ дараах мэдээллийг харгалзан үзнэ:

- Санхүүгийн хэрэгслийн гадаад (хэрэв байгаа бол) эсвэл дотоод зээл ба авлагын үнэлгээний бодит эсвэл хүлээгдэж буй мэдэгдэхүйц бууралт;

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

- Тухайн санхүүгийн хэрэгслийн гадаад зах зээлийн эрсдлийн үзүүлэлтүүдийн бууралт. Үүнд: ижил төстэй хэрэглүүрийн өгөөжийн түвшин ихээхэн ялгаатай байх, зээл ба авлагын эрсдлийг солилцох гэрээний үнэ эсвэл шаардагдах цаг хугацаа болон үргэлжлэх байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь хорогдуулсан өртгөөсөө бага байх зэрэг юм;
- Одоо байгаа эсвэл урьдчилан таамагласан бизнест нөлөөлж болохуйц сөрөг өөрчлөлт, зээлдэгчийн өрийг эргэн төлөх чадварыг бууруулж болзошгүй нөлөөлөх санхүүгийн эсвэл эдийн засгийн нөхцөл байдлууд;
- Зээлдэгчийн үйл ажиллагааны бодит эсвэл хүлээгдэж буй үр дүнгийн мэдэгдэхүйц бууралт;
- Зээлдэгчийн бусад санхүүгийн хэрэгслүүдийн зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц өсөлт;
- Зээлдэгчийн хууль эрх зүй, эдийн засаг, технологийн орчинд гарч буй бодит буюу хүлээгдэж буй томоохон сөрөг өөрчлөлтүүд нь төлбөрийн үүргээ биелүүлэх чадварыг мэдэгдэхүйцээр бууруулах.

Дээрх үнэлгээний үр дүнгээс үл хамааран Групп анх бүртгэлд тусгаснаас хойш гэрээний төлбөр 30 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн үед санхүүгийн хөрөнгийн зээл ба авлагын эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн гэж үзнэ. Хэрвээ зээл ба авлагын эрсдэл мэдэгдэхүйцээр нэмэгдээгүйг илтгэх үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц нотолгоо байгаа тохиолдолд эрсдлийг мэдэгдэхүйцээр нэмэгдсэн гэж үзэхгүй байж болно.

Хэрэв санхүүгийн хэрэгсэл нь тайлант өдрөөр эрсдлийн түвшин бага гэж тодорхойлогдсон бол дээр дурдсанаас үл хамааран Групп санхүүгийн хэрэгслийн зээл ба авлагын эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өсөлт гараагүй гэж үздэг. Санхүүгийн хэрэгсэл нь дараах нөхцөлд зээл ба авлагын эрсдэл бага гэж тодорхойлогдоно:

- Санхүүгийн хэрэгсэл нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэл багатай,
- Зээлдэгч ойрын хугацаанд гэрээний мөнгөн урсгалын үүргийг биелүүлэх бүрэн чадавхитай, мөн
- Урт хугацаанд эдийн засгийн болон бизнесийн нөхцөл байдалд гарах сөрөг өөрчлөлт нь зээлдэгч гэрээний мөнгөн урсгалын үүргээ биелүүлэх чадварыг бууруулж болзошгүй боловч энэ нь заавал бууруулна гэж тооцохгүй байж болно.

Хэрэв Группын хөрөнгө нь дэлхийн түвшинд танигдсан зээл ба авлагын үнэлгээний тодорхойлолттой нийцсэн эсвэл хөндлөнгийн үнэлгээний мэдээллийн олдоц хомс тохиолдолд, дотооддоо "хэвийн" гэж үнэлсэн санхүүгийн хөрөнгийг эрсдэл багатай гэж үзнэ. Хэвийн" гэсэн үнэлгээ нь оролцогч тал санхүүгийн хувьд өндөр чадавхтай бөгөөд өнгөрсөн хугацаанд хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй үүрэг үүсээгүй байхыг хэлнэ.

Групп зээл ба авлагын эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг тодорхойлоход ашигласан шалгуурууд нь зээл ба авлагын төлөгдөх хугацаа хэтрэхээс өмнө эрсдлийн мэдэгдэхүйц өсөлтийг тодорхойлох үр ашигтай үзүүлэлтүүд гэдгийг тогтмол хянадаг ба шаардлагатай тохиолдолд өөрчилдөг.

(ii) Дефолтын тодорхойлолт

Групп дотоод удирдлагын зорилгоор түүхэн туршлагад үндэслэн зээл ба авлагын эрсдлийн дараах шалгууруудын аль нэгийг нь хангасан санхүүгийн хөрөнгүүд нь нөхөгдөх боломжгүй болсон үед үүнийг дефолт үйл явдал гэж үздэг:

- Зээлдэгч гэрээнд заасан санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийг зөрчсөн тохиолдолд; эсвэл
- Зээлдэгчийн талаар дотооддоо боловсруулсан эсвэл гадаад эх сурвалжаас авсан мэдээлэл нь зээлдэгч бусад зээлдүүлэгчдэд болон Групп-д зээл ба авлагаа бүрэн эргүүлэн төлөх магадлал багатайг илэрхийлж буй тохиолдолд (Группын эзэмшиж буй барьцаа хөрөнгийг харгалзан үзэхгүй).

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Дээрх шалгуураас үл хамааран Группын санхүүгийн хөрөнгийн төлбөр төлөх хугацаа 90 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн бол дефолт үйл явдал гэж үзнэ. Хэрвээ гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нэмэлт хугацаа хэрэгтэй болсныг батлах үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц мэдээлэл байгаа бол дээрх тодорхойлолтонд хамаарахгүй байж болно.

(iii) Зээл ба авлагын үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд

Нэг болон түүнээс дээш үйл явдал тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээн авахаар тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлагын үнэ цэнийн бууралттай гэж үзнэ. Дараах тодорхойлолтууд нь санхүүгийн хөрөнгийн зээл ба авлагын үнэ цэнэ буурсан илэрхий нотолгоо болох юм:

- Үнэт цаас гаргагч эсвэл зээлдэгч талд томоохон хэмжээний санхүүгийн хүндрэл үүссэн;
- Гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал эргэн төлөлтийг төлбөрийн хугацааг хэтрүүлэх эсвэл төлөх чадамжгүй болох (дээр дурдсан (ii)- ийг харна уу);
- Зээлдэгчийн санхүүжүүлэгч нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдлаас үүссэн эдийн засгийн болон гэрээний шалтгааны улмаас зээлдэгчидтэй тохирсон үүрэг амлалтаа хэрэгжүүлэх боломжгүй болох;
- Зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон;
- Санхүүгийн хүндрэлээс болж тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл байхгүй болох.

(iv) Бүртгэлээс хасгах

Групп санхүүгийн хөрөнгийг зээлдэгч нь томоохон санхүүгийн хүндрэлд орсон ба зээлдэгчийн татан буугдах эсвэл дампуурах үйл явц эхэлсэн, авлага төлөгдөх хугацаа 2 жилээс дээш хугацаагаар хэтэрсэн зэрэг үйл явдлын аль нэг нь бий болсон үед буюу авлагын эргэн төлөлт хийгдэх бодит боломж байхгүй болсон үед бүртгэлээс хасна. Бүртгэлээс хасагдсан санхүүгийн хөрөнгийг Группын бодлогын дагуу авлага цуглуулах үйл явц хийгдэж, хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч болно. Бүртгэлээс хасагдсан авлага нь эргэн төлөгдсөн тохиолдолд тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

(v) Хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлыг хүлээн зөвшөөрөх, хэмжих

Хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдал нь төлбөр төлөгдөхгүй байх магадлал, алдагдал үүсэх магадлал болон эрсдэлд өртөх боломжтой зээл ба авлагын дүнгийн үржвэр юм. Төлбөр төлөгдөхгүй байх магадлал болон алдагдал үүсэх магадлалын үнэлгээ нь ирээдүйг таамаглаж буй мэдээллээр залруулагдсан түүхэн мэдээлэлд үндэслэгддэг.

Тайлагналын өдрийн байдлаар дансны үнээрээ толилуулагдсан эрсдэлтэй зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийг Группын зээлдэгчийн ирээдүйд шаардагдах санхүүжилтийн хэмжээ болон ирээдүйг таамаглаж буй мэдээлэлүүд ашиглан тодорхойлно.

Тайлангийн өдрөөрх эрсдэлд өртөх магадлалтай зээл ба авлага нь тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнээрээ илэрхийлэгдсэн.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдал нь гэрээний дагуу Группын хүлээн авах эрх бүхий нийт мөнгөн урсгал болон Группын хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн гүйлгээг үр ашигт хүүгийн аргаар дискаунтчилсан дүнгийн зөрүүгээр тооцоологддог. Түрээсийн авлагын хувьд хүлээгдэж буй авлагын алдагдлыг тооцоолоход ашигласан мөнгөн урсгал нь НББОУС 17 Түрээс-ийн дагуу түрээсийн авлагыг хэмжихэд ашигласан мөнгөн урсгалтай тэнцүү байна.

Хэрэв өмнөх тайлант үед санхүүгийн хэрэгслийн алдагдлын нөөц сан нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлаар хэмжигдсэн хэдий ч тайлант жилийн эцэст нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлын шалгуурыг хангаагүй бол Групп хялбарчилсан аргачлал ашигласан хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийн хувьд тайлант жилийн эцсээрх 12 сарын хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлыг тооцоолдог.

Групп бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор хэмждэг өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтаас бусад бүх санхүүгийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын алдагдал болон буцаалтыг үнэ цэнийн бууралтын нөөц сангийн дансаар дамжуулан тэдгээрийн дансны үнийг залруулж, ашиг алдагдлаар бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор хэмждэг өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтын алдагдал нь бусад иж бүрэн орлогоор бүртгэгдэж, хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөцөөр хуримтлуулан бүртгэж, тус дүнгээр санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулж тайлагнадаггүй.

2.10.3 Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах

Групп нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд данснаас хасна: санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн. Хэрэв Групп нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Групп-д үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээр үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ. Хэрэв Групп нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн ихэнхийг өөртөө хадгалсаар байгаа бол санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасахгүй ба санхүүгийн хөрөнгөөр барьцаалсан зээлийн өрийг бүртгэнэ.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.10.4 Санхүүгийн хөрөнгийн ангилал (2018 оны 1 сарын 1-ний СТОУС 9-ийн хэрэгжилтээс өмнө)

Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилдаг. Үүнд: бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хэрэгсэл, гэрээний хугацаа дуустал эзэмших хэрэгсэл, арилжаалах боломжтой хэрэгсэл ба зээл ба авлага болно. Энэхүү ангилал нь тухайн санхүүгийн хөрөнгийн мөн чанар болон тэдгээрийг ямар зориулалтаар эзэмшиж байгаагаас хамаарах ба анх бүртгэхдээ ангиллыг тогтоодог. Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг. Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Группын санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлага болон арилжаалах боломжтой санхүүгийн хөрөнгөөс бүрдэж байна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

2.10.4 Санхүүгийн хөрөнгийн ангилал (2018 оны 1 сарын 1-ний СТОУС 9-ийн хэрэгжилтээс өмнө) (үргэлжлэл)

2.10.4.1. Зээл ба авлага

Зээл ба авлага нь идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй бөгөөд тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөрийн хуваарьтай үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа зээл ба авлага (үүнд дансны ба бусад авлагууд, касс болон харилцах дансан дахь мөнгөн хөрөнгө багтана) нь үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжигдэж, тухайн тайлангийн өдрөөс хойш 12 сараас доош хугацаанд төлөгдөх хугацаатайгаас бусад тохиолдолд эргэлтийн хөрөнгөөр тайлагнагдана.

2.10.4.2 Арилжаалах боломжтой санхүүгийн хөрөнгө

Арилжаалах боломжтой санхүүгийн хөрөнгө нь бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хэрэгсэл, гэрээний хугацаа дуустал эзэмших хэрэгсэл болон зээл ба авлагаас ангилагдаагүй дериватив бус санхүүгийн хөрөнгө юм.

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй өмчийн үнэ цаасны бодит үнэ цэнийг нь найдвартай тодорхойлох боломжгүй учраас тайлант жилийн эцэст өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

2.10.4.3 Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах

Групп нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл санхүүгийн хөрөнгө шилжүүлсэн, хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг бусдад шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хэрэв Групп нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Групп-д үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээр үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ. Хэрэв Групп нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн ихэнхийг өөртөө хадгалсаар байгаа бол санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасахгүй ба санхүүгийн хөрөнгөөр барьцаалсан зээлийн өрийг бүртгэнэ.

Бүртгэлээс хассан хэсэгт хуваарилагдсан дансны үнээс түүний төлбөрт хүлээн авсан мөнгө ба бүртгэлээс хассан хэсэгтэй холбоотойгоор бусад иж бүрэн орлогоор тусгасан нийт олз гарзын нийлбэрийг хасаад гарсан зөрүүг ашиг алдагдалд тусгана.

2.10.4.4 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хэрэгслээс бусад санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнэ буурсан эсэхийг тайлант өдрөөр тодорхойлдог. Санхүүгийн хөрөнгийг анх бүртгэлд тусгаснаас хойш тохиолдсон нэг ба хэд хэдэн үйл явдал нь хөрөнгө оруулалтын ирээдүйн мөнгөн гүйлгээнд нөлөөлсөн гэдэг бодит нотолгоо байвал тухайн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үздэг.

Өртгөөр нь хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнийн цэнийн бууралтын гарзыг тухайн хөрөнгийн дансны үнэ болон ижил төрлийн санхүүгийн хөрөнгөөс олох бодит өгөөжийн хувийг ашиглан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр тооцдог.

Бусад бүх санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд:

- үнэт цаас гаргагч буюу харилцагч тал ихээхэн санхүүгийн хүндрэлтэй болох;
- гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал хүү ба үндсэн төлбөрийн хугацааг хэтрүүлэх, төлж чадахгүй болох;
- зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон; эсвэл
- санхүүгийн хүндрэлийн улмаас тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхитэй зах зээл үгүй болсон гэх зэрэг орно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

2.10.4 Санхүүгийн хөрөнгийн ангилал (2018 оны 1 сарын 1-ний СТОУС 9-ийн хэрэгжилтээс өмнө) (үргэлжлэл)

Дансны авлага гэх мэт зарим санхүүгийн хөрөнгө нь дангаараа үнэ цэнийн бууралтанд өртөөгүй гэж үзсэн ч нийт багцын хувьд үнэ цэнийн бууралт явагдсан эсэхийг шалгана. Группын авлагаа цуглуулдаг туршлага, 30 хоногийн дундаж зээлийн хоногоос хугацаа хэтэрсэн авлагын тоо нийт авлагын багцад өссөн, мөн авлага төлөгдөхгүй, төлбөрийн чадваргүй болж байгаа нь улсын болон орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөлттэй холбоотой байвал авлагын багцын үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо гэж үздэг. Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн анх олж бэлтгэх үеийн хүүгийн хувиар дискаунтласан ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлно.

Өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг ижил төстэй хөрөнгийн одоогийн зах зээлийн хүүгийн хувиар дискаунтласан ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлно. Ийм үнэ цэнийн бууралтын алдагдлыг хожим нь буцааж бүртгэдэггүй. Авлагаас бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн дансны үнийг бууруулж бүртгэнэ. Худалдааны авлагын хувьд найдваргүй авлагын сангийн дансаар дамжуулж үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэдэг. Авлагыг цуглуулах найдваргүй гэж үзвэл авлагыг найдваргүй авлагын сан руу хааж данснаас хасдаг. Данснаас хассан авлага дараа нь төлөгдөөл найдваргүй авлагын санд бичсэн бичилтийг буцаана. Найдваргүй авлагын сангийн дансны үлдэгдлийн өөрчлөлтийг ашиг алдагдалд тусгана.

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн хувьд дараагийн санхүүгийн жилд үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан ба ийнхүү буурсан нь үнэ цэнийн алдагдлыг бүртгэсний дараа бий болсон үйл явдалтай холбоотой гэдэг нь бодитойгоор нотлогдож байвал өмнө бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдлыг буцаана. Ингэхдээ үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан хөрөнгийн хорогдуулсан өртгийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

2.11 Санхүүгийн өрийн ба өмчийн хэрэгсэл

2.11.1 Өр төлбөр эсвэл өмчийн хэрэгслээр ангилах

Өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээгээр хүлээсэн нөхцлийн бодит байдал ба санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтонд үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилдаг.

2.11.2 Өмчийн хэрэгсэл

Группын бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

2.11.3 Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Группын санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

2.11.3.1 Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож, холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан) -ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.11 Санхүүгийн өрийн ба өмчийн хэрэгсэл (үргэлжлэл)

2.11.3 Санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)

2.11.3.2 Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Групп нь санхүүгийн өр төлбөрийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасч буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.12 Орлого хүлээн зөвшөөрөлт

Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого (СТОУС 15- ыг анх удаа хэрэгжүүлсэн)

Группын орлого нь дараах үндсэн эх үүсвэрээс бүрддэг:

- a) Барааны борлуулалт;
- b) Үйлчилгээний орлого;
- c) Бусад орлого.

Үйлчилгээний орлого нь холбоотой талууд болон бусад харилцагчдад үзүүлсэн хуурай цэвэрлэгээ болон оёдлын үйлчилгээтэй холбоотой.

Бусад орлого нь түүхий эд материал болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг дотоодын харилцагчдад борлуулсантай холбоотой.

СТОУС 15-ын дагуу Групп нь гэрээнд заасан гүйцэтгэлийн үүрэг хангагдсан буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг худалдан авагч талд шилжүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүрэг гэдэг нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх үүргийг хэлнэ.

Дараах шалгууруудын аль нэг нь хангагдсан тохиолдолд Групп холбогдох гүйцэтгэлийн үүргийг тодорхой хугацааны туршид биелэгдэх гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж тэрхүү хугацааны туршид орлогоо хэсэгчлэн хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Групп гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн цаг хугацаатай зэрэгцэн, уг ажлын гүйцэтгэлээр дамжуулан худалдан авагч үр өгөөж хүртэх;
- Группын гүйцэтгэлийн үүргийн биелэлт нь ямар нэг хөрөнгийг бий болгодог эсвэл хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд уг хөрөнгө бий болсон эсвэл үнэ цэнэ нь нэмэгдэх бүрт худалдан авагч хяналтыг өөртөө авах;
- Группын гүйцэтгэлийн үүргийн биелэлтээр дамжин бий болж буй хөрөнгийг Групп ашиглаж үр өгөөж хүртэх боломжгүй хэдий ч гүйцэтгэлийн үүрэг хангагдах бүрт төлбөр хүлээн авах эрхтэй байх.

Бусад тохиолдолд, худалдан авагч нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний хяналтыг авах үед тодорхой нэг хугацаанд хангагдах гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж орлогыг хүлээн зөвшөөрнө.

Орлогыг худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу Группын хүлээн авах эрхтэй гэж үзэж буй төлбөрийн дүнд үндэслэн хэмжинэ. Групп нь гэрээнд заасан гүйцэтгэлийн үүрэг хангагдсан буюу тусгайлан бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг худалдан авагч талд шилжүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гэрээний хөрөнгө нь хөрөнгийг худалдан авагчид шилжүүлсэн боловч бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээтэй холбоотой төлбөрийг Групп хүлээн авах эрх үүсээгүй үед бий болох хөрөнгө юм. Уг гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг СТОУС 9-ийн дагуу хэмжинэ. Авлага нь тодорхой хугацааны дотор төлөгдөх, цаг хугацаанаас өөр хүчин зүйлээс хамааралгүй, төлбөр хүлээн авах эрх юм.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.12 Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

Гэрээний өр төлбөр нь худалдан авагчаас төлбөр хүлээн авсан боловч худалдан авагчид барааг шилжүүлэх эсвэл үйлчилгээ үзүүлэх Группын үүргийг илэрхийлнэ. Нэг гэрээтэй холбоотой гэрээний хөрөнгө ба гэрээний өр төлбөрийг цэвэр дүнгээр нь тайлагнана.

2.12.1 Барааны борлуулалт

Барааны борлуулалт

Групп нэхмэл, оёмол болон сүлжмэл ноолууран бүтээгдэхүүнийг жижиглэнгийн болон бөөний худалдан авагчид борлуулдаг.

Бөөний худалдан авагчид хийсэн борлуулалтыг тухайн бүтээгдэхүүний хяналтыг худалдан авагчид шилжүүлсэн үед бүртгэдэг. Хяналт шилжсэн гэдэг нь бүтээгдэхүүнийг бөөний худалдан авагчид хүргэсэн, бөөний худалдан авагч нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтын суваг болон бүтээгдэхүүний үнэтэй холбоотой шийдвэр гаргах эрх худалдан авагчид бүрэн шилжсэнийг хэлнэ. Бөөний худалдан авагчтай байгуулсан гэрээнд заасан тодорхой цэгт барааг хүргүүлсэн, бараатай холбоотой бүхий л эрсдэл бөөний худалдан авагчид шилжсэн, худалдан авагч гэрээнд заасан барааг хүлээн авснаа зөвшөөрсөн зэрэг барааны өмчлөл ба эрсдэлтэй холбоотой бүх нөхцөл биелсэн үед барааг худалдан авагчид хүргэсэн гэж үзнэ.

Барааг худалдан авагчид хүргэсэн тухайн цаг үед буюу төлбөрийг хүлээн авах нь тодорхой бөгөөд төлбөрийг хүлээн авах нь зөвхөн цаг хугацааны асуудал болсон үед авлагыг бүртгэнэ.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлогыг барааны хяналтыг шилжүүлсэн үед буюу худалдан авагч дэлгүүрт барааг худалдан авсан үед бүртгэнэ. Худалдан авагч барааг худалдан авмагц гүйлгээний төлбөрийг нэхэмжилдэг.

Группын бодлогын дагуу жижиглэнгийн худалдан авагчид худалдан авсан бараагаа 7 хоногийн дотор, бөөний худалдан авагчид гэрээгээр тохирсон хязгаарт багтаан буцаах эрхтэй. Тиймээс гэрээний өр төлбөр (буцаагдах боломжит өр төлбөр) болон буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө (эргэлтийн хөрөнгөөр тайлагнагдсан)-ийг буцаагдах боломжит дүнд үндэслэн бүртгэнэ. Групп буцаагдах боломжит дүнг түүхэн мэдээлэл болон хуримтлуулсан туршлага дээрээ үндэслэн тооцоолдог.

Хувьсах төлбөртэй холбогдсон тодорхойгүй хүчин зүйлс нь хожим тодорхой болоход хүлээн зөвшөөрөгдсөн орлогын дүнд материаллаг нөлөөгүй бол хувьсах төлбөрийн тооцоолсон дүнг ажил гүйлгээний үнэд оруулан тооцно.

2.12.2 Үйлчилгээний орлого

Групп гүйцэтгэлийн үүргээ биелүүлэх үед уг гүйцэтгэлээр дамжуулан харилцагч үр өгөөж хүртэл болон хяналтыг нэгэн зэрэг шилжүүлэн авснаар борлуулалтын орлогыг үйлчилгээ үзүүлж буй хугацааны туршид хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүргийн ахиц дэвшлийг гарцын аргаар хэмжих бөгөөд тодорхой өдөр хүртэл харилцагчид шилжүүлсэн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг Группын гэрээний дагуу шилжүүлэхээр амласан үлдсэн бараа, үйлчилгээнд ногдох дүнгээр орлого хүлээн зөвшөөрнө.

2.12.3 Бусад орлого

Бүтээгдэхүүнийг Группын агуулахаас илгээж, бүтээгдэхүүний хяналтыг харилцагч авах үед бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг. Борлуулалтын нэхэмжлэхийн дагуу тодорхой нэг хугацаанд орлого хүлээн зөвшөөрдөг. Орлогыг Группын харилцагчтай байгуулсан гэрээгээр авах эрхтэй хүлээгдэж буй төлбөрийг үндэслэн хэмжинэ. Групп нь гүйцэтгэлийн үүргээ биелүүлж, тухайлбал бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг харилцагчид шилжүүлж, ялангуяа бараа харилцагчийн тодорхой байршилд (хүргэлт) хүргэгдсэн үед бусад орлогыг хүлээн зөвшөөрнө.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.12 Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

2.12.4 Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө болон өр төлбөр

Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө

Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө нь харилцагчаас буцаагдаж ирэхээр хүлээгдэж буй барааг хүлээн авах Группын эрхийг илэрхийлнэ. Хөрөнгийг барааны өмнөх дансны үнээс буцаагдаж ирэх барааны боломжит үнийн бууралтыг багтаасан барааг буцаах үед гарах хүлээгдэж буй зардлыг хасч хэмжинэ. Групп буцаагдахаар хүлээгдэж буй барааны хөрөнгийн хэмжилтэнд орох аливаа өөрчлөлт болон үнэ цэнийн аливаа нэмэлт бууралтыг байгаа эсэхийг үнэлж шинэчилдэг. Буцаалтын дүнг тооцоолохын тулд Групп хүлээгдэж буй үнэ цэнийн аргыг ашиглан багцын түвшин дэх буцаалтын тоо хэмжээг өөрийн хуримтлагдсан түүхэн туршлагаад үндэслэн тодорхойлдог. Өмнөх жилүүдэд тогтмол хэмжээний барааны буцаалт хийгдэж байсан тул мэдэгдэхүйц хэмжээний орлогын буцаалт бүртгэгдэх магадлал бага байна гэж үздэг.

Буцаах эрхтэй барааны өр төлбөр

Буцаах эрхтэй барааны өр төлбөр нь харилцагчаас хүлээн авсан нийт төлбөр (эсвэл авлага) эсвэл төлбөрийн зарим хэсгийг буцаан олгох үүрэг хариуцлага бөгөөд Групп харилцагчид буцаан олгоно гэж хүлээгдэж буй тооцоолсон дүнгээр хэмжигдэнэ. Групп тайлант үе бүрийн эцэст буцаах эрхтэй барааны өр төлбөр (ба гүйлгээний үнийн харгалзах өөрчлөлт)-ийн тооцооллыг шинэчилдэг.

Орлого хүлээн зөвшөөрөлт (2018 оны 1 сарын 1-ээс өмнөх)

Орлогыг харилцагчаас хүлээн авсан болон хүлээн авах зүйлийн бодит үнэ цэнээр хэмждэг. Орлогыг тооцоолж буй борлуулалтын буцаалт, борлуулалтын хөнгөлөлт, эдгээртэй ижил төстэй хөнгөлөлтүүдийг хассан цэвэр дүнгээр бүртгэдэг:

- Барааг эзэмших, өмчлөхтэй холбоотой эрсдэл ба өгөөж нь худалдан авагчид шилжсэн;
- Борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй;
- Орлогыг найдвартайгаар хэмжих боломжтой;
- Ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг Групп хүртэх магадлалтай;
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан болон гарах зардлуудыг найдвартайгаар хэмжиж, тодорхойлох боломжтой.

Ялангуяа, барааг худалдан авагчид хүргэсэн мөн хууль ёсны өмчлөл нь худалдан авагчид шилжсэн үед бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Хэрэв хөнгөлөлт үзүүлэх нь магадлалтай, мөн дүнг нь найдвартайгаар хэмжих боломжтой бол орлогыг хүлээн зөвшөөрөхдөө уг хөнгөлөлтийг орлогоос хасч бүртгэнэ.

Хүүгийн орлого

Эдийн засгийн өгөөж нь Групп-д ирэх өндөр магадлалтай ба орлогын дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой тохиолдолд хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрнө. Хүүг хугацаанаас хамааралтайгаар үндсэн өрийг үр ашигт хүүгийн хувиар үржүүлж хуримтлуулан бүртгэдэг. Үр ашигт хүүгийн хувь гэдэг нь санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгийг бодох ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм.

Түрээсийн орлого

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар тооцож ашиг алдагдлаар тусгадаг.

Бусад орлого

Бусад орлого нь бизнесийн хэвийн бүс нөхцөлд үүссэн бөгөөд эдийн засгийн өгөөжийг найдвартай хэмжих боломжтой, үүнийг Групп хүртэх магадлалтай үед бусад орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.13 Түрээс

Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл болон өгөөжийг түрээслэгчид шилжүүлж байвал үг түрээсийг санхүүгийн түрээсээр тайлагнадаг. Бусад бүх түрээсийг үйл ажиллагааны түрээсээр тайлагнадаг.

2.13.1 Түрээслүүлэгч

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан бүртгэдэг. Түрээсийн гэрээ байгуулах үед гарсан нэмэлт зардлуудыг түрээсийн хөрөнгө оруулалт дээр нэмж бүртгэж, түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулдаг.

2.13.2 Түрээслэгч

Групп-д томоохон түрээсийн гэрээ байхгүй. Үйл ажиллагааны түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээстэй холбоотой болзошгүй төлбөрийг тэдгээрийг гарсан жилд зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу урамшуулал авсан бол түүнийг өр төлбөр гэж бүртгэдэг ба түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан түрээсийн өглөгийг бууруулж, зардлаар бүртгэдэг.

2.14 Гадаад валютын ажил гүйлгээ

Группын бие даасан компани бүрийн хувьд санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн. Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүд нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр нь тухайн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Энэхүү гадаад валютын хөрвүүлгийн гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүг тухайн тайлант хугацаанд нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлангийн хэсэгт тусгадаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөр нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлэгддэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотойгоор, Группын гадаад үйл ажиллагааны хөрөнгө болон өр төлбөрийг тайлант хугацаа бүрийн эцсийн өдрийн ханшаар Төгрөг рүү хөрвүүлсэн. Тайлант хугацааны турш дахь орлого болон зардлын зүйлсийг хөрвүүлэхдээ ажил гүйлгээ үүссэн өдрийн ханшийг ашигласан. Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг бусад иж бүрэн орлогын тайланд тусган эздийн өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэнэ.

2.15 Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг нэгтгэсэн иж бүрэн орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Группын үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

2.16 Зээлийн зардал

Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба үг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Шалгуурт нийцсэн хөрөнгийг санхүүжүүлэхээр хүлээж буй зээлийг сул чөлөөтэй үед нь богино хугацаагаар хүү олох хөрөнгө оруулалтанд ашигласан бол олсон хүүг капиталжуулах хүүгийн зардлыг бууруулж бүртгэнэ.

Бусад бүх зээлийн хүүг тэдгээрийг гарсан жилийн ашиг алдагдлын тайланд тусгана.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.17 Ажилчдын тэтгэмж

Групп нь тайлант хугацаанд ажилчдад олгох цалингийн зардлаас төлсөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр өрийг бүртгэдэг. Түүнчлэн Групп нь ойрын хугацаанд мөнгөн шагнал олгох, ашиг хуваах хөтөлбөрийн хүрээнд төлөх дүнгээр өр бүртгэдэг. Ингэхдээ Групп нь ажилчдынхаа үзүүлсэн үйлчилгээний үр дүнд ийнхүү төлөхөөр хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд холбогдох өрийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой бол өрийн санг бүртгэдэг.

Богино хугацаат тэтгэвэр, тэтгэмжийг ажилчид үйлчилгээ үзүүлсэн үед дискаунтлаагүй сууриар хэмжиж, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

2.18 Нөөц

Групп нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг. Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог.

Нөөцийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед түүнийг авлага хэмээн бүртгэнэ.

Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

2.19 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн тайланд нэмж тодруулна.

2.20 Холбоотой тал

Групп болон Группын толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Групп-тэй холбоотой гэж үзнэ:

- Группыг шууд эсвэл хамтран хянадаг
- Группын үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг
- Группын болон Группын толгой компанийн удирдах ажилтан

Хэрэв дараах нөхцлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Групп-тэй холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон Групп нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм.
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.20 Холбоотой тал (үргэлжлэл)

- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол
- Тухайн аж ахуйн нэгж нь Групп эсвэл Групп-тэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжинд зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө байгаа бол
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх
- Группыг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан

2.21 Татвар

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

2.21.1 Тухайн жилийн орлогын албан татвар

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Группын санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Группын тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

2.21.2 Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвил болон татварын ногдуулах орлого ба санхүүгийн ашгийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө бө өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг. Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдох орлогод нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын өр болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг борлуулах, барагдуулах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар Групп хэрхэн борлуулах, барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

2.21.3 Тухайн жилийн болон хойшлогдсон татвар

Тухайн жилийн болон хойшлогдсон татварыг тайлант жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба харин тэдгээр нь иж бүрэн орлого эсвэл өмчийн хэсэгт шууд бүртгэгдсэн зүйлстэй холбоотой бол харгалзан иж бүрэн орлого эсвэл өмчийн хэсэгт бүртгэдэг. Тухайн жилийн болон хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлийг анх бүртгэхтэй холбоотой бол татварын нөлөөллийг бизнесийн нэгдлийн бүртгэлд оруулж тусгана.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

3.1 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж

3.1.1 Газрын эрхийн ашиглалтын жил ба элэгдэл

Групп нь Монгол улсад орших газрыг 15-аас 60 жилээр түрээсэлдэг.

Монгол улсын Газрын тухай хууль нь Монгол улсын аж ахуйн нэгжүүдэд газрын эрх эзэмших эрх зүйн үндсийг тогтоосон.

Групп газрыг гэрээний дагуу олж эзэмшсэн бодит үнэ цэнээр нь анх бүртгэлд тусгадаг. Групп өнгөрсөн жилүүдэд газар ашиглах эрхийн хугацааг маш бага хэмжээний жил тутмын төлбөр төлж амжилттай сунгуулсан. Группын удирдлага газар ашиглах эрхийн хугацааг бага хэмжээний төлбөр төлж, цаашид тодорхойгүй хугацаагаар эзэмшинэ гэдэгт итгэлтэй байна. Тиймээс нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд 2,576,718 мянган төгрөгийн (2017: 2,576,718 мянган төгрөг) дансны үнэ бүхий газар нь үнэ цэнийн бууралтыг хассан, дахин үнэлсэн дүнгээр илэрхийлэгдсэн бөгөөд газрыг элэгдүүлдэггүй.

3.1.2 Монгол улсын татварын систем

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Групп татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Групп-д татварын эрсдэл байсаар байна.

3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Дараах нэгтгэсэн санхүүгийн тайлангийн их хэмжээний дүн бүхий үзүүлэлтүүдэд дараах таамаглал төсөөллийг ашиглан, нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

3.2.1 Алдагдлын нөөц сангийн тооцоолол

Групп дансны авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо бусад авлагын хувьд тусгайлсан үнэлгээний аргаар ашигласнаас бусад авлагад матрицийн аргыг ашигласан. Зээлдэгчдийг ижил төстэй алдагдлын хандлагаар бүлэглэсэн дотоод зээл ба авлагын зэрэглэлд суурилан хасагдуулгын хувийг тодорхойлдог. Нөөц сан тооцоолох матрицын арга нь Группын түүхэн дефалтын түвшинд суурилдаг бөгөөд хэт их зардал болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахааргүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүдийг харгалзан үздэг. Тайлант үе бүрийн эцэст ажиглагдах түүхэн дефалтын түвшинг дахин үнэлэх ба ингэхдээ ирээдүйг таамаглаж буй мэдээлэлд гарсан өөрчлөлтүүдийг авч үзнэ.

2018 оны 12 сарын 31-нээрх Группын дансны ба бусад авлагын дансны үнэ нь 12,183,569 мянган төгрөг, авлагын нөөц сангийн үлдэгдэл 462,385 мянган төгрөг (2017 оны 12 сарын 31-ний байдлаар дансны ба бусад авлагын дансны үнэ нь 11,644,199 мянган төгрөг, авлагын нөөц сангийн үлдэгдэл 1,425,547 мянган төгрөг) байсан.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)

3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)

3.2.2 Удаан гүйлгээтэй бараа материалын хасагдуулгын нөөц

Группын удирдлага удаан гүйлгээтэй, зарагддаггүй болон эвдэрч гэмтсэн бараа материалыг тодорхой хугацаагаар хянадаг ба үнэлэмж болон тооцооллыг ашигладаг. Эдгээр тооцооллоос хамаарч бараа материалын үнэлгээ өөрчлөгдөх боломжтой.

Группын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бараа материалын үнэлгээг тооцоходоо бараа материалын насжилт дээр үндэслэн өмнөх жилүүдийн туршлага, түүхэн мэдээлэлд үндэслэн тооцсон хувиар тооцдог.

Удирдлага дээрх бараа материалын үнэлгээг тодорхойлоход хэрэглэсэн төсөөлөл болон үнэлэмж зохистой буюу тохиромжтой гэдэгт итгэж байна.

2018 оны 12 сарын 31-нээрх бараа материалын дансны үнэ нь 142,538,944 мянган төгрөг (буцаах эрхтэй барааны 268,017 мянган төгрөгөөс гадна), бараа материалын хасагдуулгын үлдэгдэл 856,406 мянган төгрөг (2017 оны 12 сарын 31-ний байдлаар бараа материалын дансны үнэ нь 101,271,760 мянган төгрөг, бараа материалын хасагдуулгын үлдэгдэл 736,303 мянган төгрөг) байсан.

3.2.3 Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил

Тодруулга 2.6-д тайлбарласнаар, Групп үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоолоход үнэлэмж ашигладаг ба уг тооцоолол нь тайлант жилийн цэвэр ашигт нөлөө үзүүлэх боломжтой.

Удирдлага дээрх тооцоолсон үндсэн хөрөнгийн ашиглалтын жил уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглах жил гэдэгт итгэж байна.

3.2.4 Барилга ба газрын бодит үнэ цэнийн хэмжилт

Газар болон барилга нь санхүүгийн тайлагналын зорилгоор бодит үнэ цэнээр хэмжигдсэн. Групп хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо ажиглаж болох зах зээлийн үнийн мэдээллийг ашигладаг. Идэвхитэй зах зээлийн үнэ цэнийн мэдээлэл тодорхойгүй бол Групп хараат бус мэргэжлийн үнэлгээчнээр хөрөнгийн үнэлгээг тооцоолуулдаг. Эдгээр тооцооллоос хамаарч газар болон барилгын үнэлгээ өөрчлөгдөх боломжтой.

Барилга болон газрын бодит үнэ цэнийг тооцоолоход ашигласан мэдээлэл болон үнэлгээний аргачлалын талаар тодруулга 10.2-г харна уу.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

4. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)

Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2018 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэчлэгдсэн СТОУС болон өөрчлөлтүүд
2018 оны 1 сарын 1	СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
	СТОУС 15 Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого
	СТОУС 2-д хийгдсэн өөрчлөлт – Хувьцаанд суурилсан төлбөрийн Хэмжилт болон Ангилал
	СТОУТХ 22 Гадаад валютын гүйлгээ ба урьдчилгаа
	НББОУС 40-д хийгдсэн өөрчлөлт – Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шилжүүлэлт
	СТОУС 4-д хийгдсэн өөрчлөлт – СТОУС 9-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой СТОУС 4 Даатгалын Гэрээ
	СТОУС-ын 2014-өөс 2016 оны мөчлөгт хийгдсэн Жилийн шинэчлэлүүд

Доор дурьдсанаас бусад стандартуудын хэрэгжилт нь Группын нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөө үзүүлээгүй.

"СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл"-г анхлан хэрэгжүүлэлтийн нөлөөлөл

Тайлант жилд Групп "СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл" болон түүнтэй холбоотойгоор шинэчлэгдсэн бусад СТОУС-уудын өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн. "СТОУС 9" нь 1) санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт, 2) хүлээгдэж буй алдагдал ("ХБА") болон 3) хейдгийн ерөнхий бүртгэл зэрэгт шинэ шаардлагуудыг танилцуулсан.

Групп СТОУС 9-д заасан шилжилтийн нөхцлийн дагуу тус стандартыг хэрэгжүүлсэн.

(a) Санхүүгийн хөрөнгийн ангилал болон хэмжилт

2018 оны 1 дүгээр сарын 1-нээс энэхүү стандартыг анх мөрдөж эхэлсэн. Групп 2018 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаарх бүртгэлтэй байсан санхүүгийн хэрэгслүүдэд СТОУС 9-ийн шаардлагыг мөрдсөн бөгөөд 2018 оны 1 дүгээр сарын 1 гэхэд аль хэдийн бүртгэлээс хасагдсан байсан санхүүгийн хэрэгсэлд уг стандартыг мөрдөөгүй болно. Групп СТОУС 9-ийн шилжилтийн нөхцлөөр зөвшөөрөгдсөн, зэрэгцүүлэгдэх тоон үзүүлэлтүүдийг дахин тайлагнахгүй байх аргыг сонгосон. Шилжилтийн өдрөөрх санхүүгийн хөрөнгө болон өглөгийн дансны үнэд нөлөөлөх нөлөөллийг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд тохируулан бүртгэсэн.

Группын удирдлагууд 2018 оны 1 дүгээр сарын 1-нээрх санхүүгийн хөрөнгийг тухайн өдрийн оршин байсан бодит баримт болон нөхцөл байдалд тулгуурлан үнэлж, Группын санхүүгийн байдал, ашиг болон алдагдал, бусад иж бүрэн орлого эсвэл нийт иж бүрэн орлогод нөлөөлөхүйц санхүүгийн хөрөнгийн дахин ангиллын нөлөө байхгүй гэж үзсэн.

(b) Хүлээгдэж буй алдагдлын загвараарх үнэ цэнийн бууралт

Групп бүх дансны авлагын нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тодорхойлоходоо СТОУС 9-ын дагуу хүлээгдэж буй алдагдлыг тооцох хялбаршуулсан аргыг мөрдсөн. НББОУС 39-ийн дагуу үнэ цэнэ нь буурсан гэж тодорхойлогдсон зээл ба авлага болон дефолт болсон түүхтэй дансны авлагуудыг тусгайлан, үлдсэн хэсгийг хугацаа хэтрэлтийн мэдээлэлд үндэслэн бүлэглэн үнэлсэн.

СТОУС 9-ийн хэрэгжилттэй холбоотойгоор Группын удирдлага дотоод үнэлгээ хийсэн ба үнэлгээний үр дүнд уг стандартын хэрэгжилт нь Группын нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй гэж үзсэн.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

4. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС) (үргэлжлэл)

"СТОУС 15 Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого" хэрэгжүүлэлтийн нөлөөлөл

Групп СТОУС 15-г тайлант жилд анх удаа хэрэгжүүлсэн. НББОУС 18 Орлого болон холбогдох тайлбаруудыг СТОУС 15 хүчингүй болгож, орлосон болно.

Групп СТОУС 15-г буцаан мөрдөж анхлан хэрэгжүүлсэн 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр уг стандартыг анхлан мөрдөж эхэлсэнтэй холбоотой хуримтлагдсан нөлөөллийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Анхлан хэрэгжүүлсэн өдөр үүссэн ямар нэгэн зөрүүг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл (эсвэл бусад өмчийн зохих бүрэлдэхүүн)-д хүлээн зөвшөөрч, харьцуулсан мэдээллийг дахин илэрхийлээгүй болно. Үүнээс гадна, СТОУС 15-ийн шилжилтийн нөхцөлийн дагуу Групп нь зөвхөн 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр бүрэн дуусаагүй байсан гэрээнүүдэд Стандартыг буцаан мөрдөж аргыг сонгож хэрэглэсэн.

Анхлан хэрэгжүүлсэн өдөр үүссэн аливаа зөрүүг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл (эсвэл бусад өмчийн зохих бүрэлдэхүүн)-д хүлээн зөвшөөрч, зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин тайлагнаагүй болно. Үүнээс гадна, СТОУС 15-ийн шилжилтийн шаардлагын дагуу Групп зөвхөн 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан гэрээнүүдэд уг стандартыг буцаан мөрдөж аргыг сонгон хэрэглэсэн.

Иймээс, зарим зэрэгцүүлэгдэх мэдээллүүд нь НББОУС 18 Орлого болон холбогдох тайлбарын дагуу бэлтгэсэн зэрэгцүүлэгдэх мэдээллүүдтэй харьцуулах боломжгүй байж болно.

"СТОУС 15"-г анхлан хэрэгжүүлэхтэй холбоотой нөлөөллийн хураангуй

Группын удирдлагууд 2018 оны 1-р сарын 1-ний өдрөөрх хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан гэрээнүүдийг хянаж, үнэлэн дүгнэсэн.

Шинэ стандартын хэрэгжилт нь Группын нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй болно.

2018 оны 12 сарын 31-нээрх бэлтгэсэн Группын нэгтгэсэн санхүү байдлын тайлан болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд тусгагдах СТОУС 15-н нөлөөллийг доорх хүснэгтэд хураангуйлав. Уг стандартын хэрэгжилт нөлөө үзүүлэхгүй санхүүгийн тайлангийн мөрүүдийг тусгаагүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд үзүүлсэн нөлөөлөл:

	Тайлагнасан	Дахин ангилсан	СТОУС 15-н нөлөөллийг оруулаагүй дүн
Эргэлтийн өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	4,741,052	1,037,239	5,778,291
Гэрээний өр төлбөр	1,037,239	(1,037,239)	-

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үзүүлсэн нөлөөлөл:

	Тайлагнасан	Дахин ангилсан	СТОУС 15-н нөлөөллийг оруулаагүй дүн
Тайлант жилийн цэвэр ашиг	17,764,164	-	17,764,164
Ажлын капиталын хөдөлгөөний өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:			
Дансны болон бусад өглөгийн өөрчлөлт	439,989	(134,913)	305,076
Гэрээний өр төлбөр болон буцаах эрхтэй барааны өр төлбөрийн өөрчлөлт	(134,913)	134,913	-

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

4. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС) (үргэлжлэл)

СТОУХТ 22 Гадаад валютын гүйлгээ ба урьдчилгаа

Тус тайлбар нь ажил гүйлгээ гарсан өдрийг урьдчилгаа төлбөрийг хүлээн авсан эсвэл төлснөөс үүсэх мөнгөн бус хөрөнгө болон мөнгөн бус өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрсөн өдөр гэж тодорхойлсон. Хэрэв олон тооны урьдчилгаа хүлээн авсан эсвэл төлбөр төлсөн бол Групп нь урьдчилгаа төлбөр хийгдсэн өдөр тус бүрийг тодорхойлж бүртгэх шаардлагатай. Тус тайлбар нь нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй үзүүлээгүй болно.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Группын санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг дор тодруулсан болно. Эдгээр стандартууд болон өөрчлөлтүүд нь Группын нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхээр бол Групп эдгээрийг хэрэгжиж эхэлсэн үеэс дагаж мөрдөнө.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2019 оны 1 сарын 1	СТОУС 16 Түрээс
	СТОУХТ 23 Орлогын албан татвар дахь тодорхойгүй байдал
	СТОУС 9-д хийгдсэн өөрчлөлт Хасах нөхөн төлбөртэй урьдчилгаа төлбөрийн онцлог
	НББОУС 19-д хийгдсэн өөрчлөлт Төлөвлөгөөний өөрчлөлт, цомхотхол
	НББОУС 28-д хийгдсэн өөрчлөлт Хараат эсвэл Хамтарсан үйлдвэрийн урт хугацаа дахь сонирхол
2020 оны 1 сарын 1	СТОУС-ын 2015-өөс 2017 оны мөчлөгт хийгдсэн Жилийн шинэчлэлүүд
	СТОУС 3-д хийгдсэн өөрчлөлт - Бизнесийн тодорхойлолт
2021 оны 1 сарын 1	НББОУС 1 болон НББОУС 8-д хийгдсэн өөрчлөлт-Материалын тодорхойлолт
Тодорхойгүй	СТОУС 17 Даатгалын гэрээ
	СТОУС 10 болон НББОУС 28-д хийгдсэн өөрчлөлт -Хөрөнгө оруулагч болон Хараат эсвэл Хамтарсан Үйлдвэрийн хооронд хийгдсэн хөрөнгийн борлуулалт болон хөрөнгөөрх хөрөнгө оруулалт

Группын гүйцэтгэх удирдлага нь эдгээр шинэ болон шинэчилсэн СТОУС-ыг нэвтрүүлэх явцад хяналт тавин ажиллаж байна. Нэгтгэсэн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг тодорхойлж дуусаагүй байгаа боловч Групп уг нөлөөлөл нь материаллаг бус байна гэж үзэж байна.

СТОУС 16 Түрээс

СТОУС 16 нь түрээслэгч, түрээслүүлэгчийн бүртгэл болон түрээсийн гэрээг тодорхойлох иж бүрэн загварыг танилцуулсан. СТОУС 16 хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр НББОУС 17 болон түүнтэй холбогдох тайлбаруудыг хүчингүй болгож орлуулна.

СТОУС 16 нь тодорхой хөрөнгийг харилцагч хянаж байгаа эсэхээс хамааран түрээс эсвэл үйлчилгээний гэрээг аль болохыг ялгахыг шаарддаг. Түүнчлэн, СТОУС 15-н шаардлагын дагуу холбоотой хөрөнгийн шилжүүлэлт нь борлуулалт болон буцаан түрээслэх ажил гүйлгээ гэж бүртгэгдэх ёстой эсэхийг СТОУС 16 тодорхойлохыг шаарддаг. СТОУС 16 хэсэгчилсэн түрээс болон түрээсийн гэрээний өөрчлөлттэй холбоотой шалгууруудыг мөн тодорхойлсон байдаг.

Түрээслэгчийн хувьд санхүүгийн түрээс болон үйл ажиллагааны түрээсийн бүртгэл нь ялгаагүй болсон бөгөөд түрээслэгч нь богино хугацаат түрээс болон бага үнэтэй хөрөнгийн түрээсүүдээс бусад ашиглах эрхтэй хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг бүртгэх загвараар орлуулагдсан.

Ашиглах эрхтэй хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг ба дараа үеүдэд хэмжихдээ өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг болон өр төлбөрийн дахин хэмжилтийн тохируулгыг хасдаг. Түрээсийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн өдрөөр төлөгдөөгүй түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**4. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)
(үргэлжлэл)**

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд (үргэлжлэл)

Дараа үеүдэд түрээсийн өр төлбөр нь хүү, түрээсийн төлбөрүүд болон түрээсийн гэрээнд орсон өөрчлөлтүүдээр тохируулагддаг. Мөнгөн гүйлгээний ангиллын хувьд, Групп өөрийн хэрэгцээнд ашиглахаар түрээсэлсэн газар, хугацааны эхэнд урьдчилан төлсөн түрээсийн төлбөрүүдийг хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээнд толилуулдаг бөгөөд харин бусад үйл ажиллагааны түрээсийн төлбөрүүд нь үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр толилуулдаг. СТОУС 16 хэрэгжиж эхэлснээр түрээсийн өр төлбөрийн үндсэн болон хүүгийн төлбөрийг тус тусад нь санхүүжилтийн мөнгөн гүйлгээгээр толилуулахыг Группээс шаардана.

СТОУС 16-н хэрэгжилт нь ашиглах эрхтэй хөрөнгүүд болон Группын өөрийн эзэмшиж буй хөрөнгүүдийн ангиллын толилуулганд нөлөөлж болох ба хөрөнгүүдийг тусад нь эсвэл нэгтгэсэн байдлаар толилуулж болно.

СТОУС 16-н түрээслүүлэгчид холбогдох хэдэн тодорхой шалгууруудаас бусад нь НББОУС 17-н түрээслүүлэгчийн бүртгэлийн ерөнхий шаардлагуудад томоохон өөрчлөлт ороогүй бөгөөд үйл ажиллагааны болон санхүүгийн түрээсээр ангилахыг шаардсаар байна.

Цаашилбал, СТОУС 16-н дагуу дэлгэрэнгүй тодруулгыг толилуулахыг шаардана.

Групп 2018 оны 12 сарын 31-нээр 95,455 мянган төгрөгийн үл цуцлагдах үйл ажиллагааны түрээсийн үүргийг тодруулга 31.2-д толилуулсан.

Групп НББОУС 17-ы дагуу түрээслэх эрхтэй төлсөн буцаан хүлээн авах түрээсийн барьцаа хөрөнгийн дүн 119,794 мянган төгрөг байна. СТОУС 16-д заасны дагуу түрээсийн төлбөрийн тодорхойлолтод нь ашиглах эрхтэй холбоотойгоор төлсөн барьцааг түрээсийн төлбөрийн хэсэг гэж үзэхгүй бөгөөд барьцааны дансны үнээр хорогдуулсан өртгийг тохируулж болно.

Төлсөн буцаан авах түрээсийн барьцааны тохируулга нь нэмэлт түрээсийн төлбөрүүд болон ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үндэд орсон гэж үзэж болно. Хүлээн авсан буцаан төлөх түрээсийн барьцааны тохируулгыг урьдчилгаа түрээсийн төлбөр гэж үзэж болно.

5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

	2018	2017
Гадаад валютын харилцах данс болон касс	1,656,522	5,539,450
Төгрөгийн харилцах данс болон касс	3,284,418	1,644,312
	4,940,940	7,183,762

Банкин дахь төгрөгийн харилцах дансанд жилийн 7.2% хүртэл, гадаад валютын харилцах дансанд жилийн 1.2%-ийн хүү боддог.

6. Дансны ба бусад авлага

	2018	2017
Дансны авлага	12,089,446	12,599,819
Авлагын алдагдлын нөөц сан	(462,385)	(1,425,547)
	11,627,061	11,174,272
Холбоотой талаас авах авлага (Тодруулга 26.1-г үзнэ үү)	500	8,409
Бусад авлага	556,008	461,518
	12,183,569	11,644,199

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

6. Дансны ба бусад авлага (үргэлжлэл)

6.1 Дансны авлага

Группын зээлийн борлуулалтыг урьдчилан батлагдсан зээлийн хязгаарт багтаан төлөгдөх хугацаа нь дунджаар 90 хоног байна. Хугацаа хэтэрсэн авлагад хүү тооцдоггүй. Аливаа шинэ харилцагчийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө Группын удирдлага харилцагчийн зээлийн эрсдлийн чанарыг үнэлэн зээлийн хязгаарыг харилцагч тус бүрийн хувьд тодорхойлдог.

Групп дансны авлагын алдагдлын нөөц санг бүртгэхдээ нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолдог. Тайлагналын өдрөөр авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо алдагдлын түүхэн мэдээлэл, тухайн зээлдэгчид тусгайлан хамааралтай хүчин зүйлс, үндсэн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн орчин, одоогийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг харгалзан тохируулсан нөөц сан тооцоолох матрицыг ашигладаг.

Тооцооллын арга аргачлал болон нөлөө үзүүлэхүйц таамаглалуудад тайлант жилд өөрчлөлт ороогүй болно.

Харилцагчид томоохон хэмжээний санхүүгийн хүндрэл үүссэн бөгөөд ирээдүйд нөхөн төлөгдөх үндэслэл байхгүй гэдэг нотолгоо байгаа жишээ нь татан буугдсан, дампуурлаа зарлаж үйл ажиллагаа зогсоосон эсвэл дансны авлагын төлөгдөх хугацаа 10 жил ба түүнээс дээш жилээр хэтэрсэн тохиолдсон Групп тухайн авлагыг данснаас хасдаг. Хууль сахиулах байгууллагын шийдвэрээр данснаас хассан авлага байхгүй.

Группын худалдан авагчдын сегмент тус бүрийн зээлийн алдагдлын мэдээлэл нь Группын түүхэн зээлийн алдагдлын мэдээллээс материаллаг зөрүүгүй учир нийт харилцагчдын хугацаа хэтрэлттэй мэдээлэлд үндэслэн тооцсон нөөцийн сан нь Группын худалдан авагчдын сегмент тус бүрийн хувьд тодорхойлсон алдагдлын нөөцөөс хол зөрүү байхгүй гэж үзсэн.

Групп тусгайлан үнэлгээг хийсний үндсэн дээр тухайн авлагын дүнгийн 100%-ийн алдагдлын нөөц сан байгуулсан 460,862 мянган төгрөгийн дансны авлагаас бусад бүх авлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцохдоо алдагдлын түүхэн мэдээллийг өнөөгийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг харгалзан үзсэн. Үүний үр дүнд, Групп хугацаа хэтрээгүй болон даатгагдаагүй авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөцийг 0.01% гэж тодорхойлсон. Иймээс, тайлант жилд 1,523 мянган төгрөгийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

6.2 Бусад авлага

	2018	2017
НӨАТ-н авлага	403,838	262,406
Ажилчдаас авах авлага	118,920	143,243
Бусад авлага	33,250	55,869
	556,008	461,518

6.3 Авлагын алдагдлын нөөц сан

Дараах хүснэгтэнд СТОУС 9-н хялбаршуулсан аргын дагуу тооцоолсон дансны болон бусад авлагатай холбоотой нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлын хөдөлгөөнийг харуулав.

	Нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдал		Нийт
	(үнэ цэнэ буураагүй)	(үнэ цэнэ буурсан)	
2018 оны 1 сарын 1-нээрх үлдэгдэл	-	1,425,547	1,425,547
Тайлант жилд байгуулсан авлагын нөөц сан	1,523	-	1,523
Данснаас хассан авлага		(964,685)	(964,685)
2018 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	1,523	460,862	462,385

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

7. Урьдчилгаа төлбөр

	2018	2017
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа	3,944,070	2,787,958
Урьдчилж төлсөн зардал	451,308	5,397
Урьдчилж төлсөн татвар	295,303	18,095
	4,690,681	2,811,450

8. Бараа материал

	2018	2017
Түүхий эд материал	55,979,147	41,998,818
Дуусаагүй үйлдвэрлэл	32,442,697	21,536,660
Бэлэн бүтээгдэхүүн	40,075,657	27,922,191
Үйлдвэрлэлийн хангамжийн материал	14,207,691	9,607,192
Замд яваа бараа	690,158	943,202
	143,395,350	102,008,063
Бараа материалын хасагдуулга	(856,406)	(736,303)
	142,538,944	101,271,760

Түүхий эд материалд түүхий ноолуур, самнасан ноолуур болон ноолууран утас багтсан. 2018 онд бараа материалаас борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 94.9 тэрбум төгрөгийг (2017 оны 12 сарын 31: 72.4 тэрбум төгрөг) бүртгэсэн.

Тайлант жилд бараа материалын өртөгт 20,970 сая төгрөг (2017 оны 12 сарын 31: 15,204 сая төгрөг)-ийн ажилчдын цалин болон түүнтэй адилтгах зардлыг бүртгэсэн.

Бараа материалын хасагдуулгын хөдөлгөөн:

	2018	2017
Хасагдуулгын эхний үлдэгдэл	736,303	906,212
Тайлант жилд байгуулсан бараа материалын хасагдуулга	120,103	44,742
Өмнө байгуулсан хасагдуулгын нөхөлт	-	(214,651)
Хасагдуулгын эцсийн үлдэгдэл	856,406	736,303

2018 оны 12 сарын 31-ны байдлаар нийт 138,009 сая төгрөг (2017 оны 12 сарын 31-ны байдлаар нийт 99.2 сая төгрөг) – ийн бараа материал Группын зээлийн барьцаанд байна.

9. Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө

	2018	2017
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	268,017	-
	268,017	-

Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө нь Группын худалдан авагчдаас буцаагдах магадлалтай барааг илэрхийлнэ. Групп хүлээгдэж буй борлуулалтын буцаалтыг өмнөх жилүүдийн түүхэн мэдээлэлд үндэслэн хүлээгдэж буй үр дүнгийн аргаар тооцоолсон.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

10. Үндсэн хөрөнгө

	Газар	Барилга	Тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Дуусаагүй барилга/ ашиглаж эхлээгүй тоног төхөөрөмж	Нийт
Өртөг эсвэл дахин үнэлэгдсэн дүн:							
2017 оны 1 сарын 1	2,576,718	21,058,097	41,961,351	2,389,516	1,559,439	9,529,292	79,074,413
Нэмэгдсэн	-	4,301,440	6,935,882	1,114,185	400,148	1,778,640	14,530,295
Хасагдсан	-	(63,946)	(936,655)	(174,369)	(213,965)	-	(1,388,935)
Данснаас хассан (Тодруулга 25)	-	(3,490,667)	-	-	-	-	(3,490,667)
Гадаад валютын ханшийн нөлөө	-	-	-	27,533	-	-	27,533
Биет бус хөрөнгө рүү ангилсан (Тодруулга 12.1)	-	-	-	(124,658)	-	-	(124,658)
Дахин ангилал	-	1,667,578	1,399,891	-	-	(3,067,469)	-
2017 оны 12 сарын 31	2,576,718	23,472,502	49,360,469	3,232,207	1,745,622	8,240,463	88,627,981
Нэмэгдсэн	-	6,455,263	15,093,244	1,179,635	316,880	8,758,691	31,803,713
Хасагдсан	-	-	(616,747)	(329,815)	(48,580)	-	(995,142)
Дахин ангилал	-	13,418,999	91,733	30,277	-	(13,541,009)	-
2018 оны 12 сарын 31	2,576,718	43,346,764	63,928,699	4,112,304	2,013,922	3,458,145	119,436,552
Хуримтлагдсан элэгдэл:							
2017 оны 1 сарын 1	-	1,139,543	24,676,116	700,768	522,226	-	27,038,653
Элэгдэл	-	909,558	4,093,670	346,056	177,992	-	5,527,276
Хасагдсан	-	(5,279)	(698,706)	(110,554)	(147,712)	-	(962,251)
Данснаас хассан (Тодруулга 25)	-	(237,933)	-	-	-	-	(237,933)
Гадаад валютын ханшийн нөлөө	-	-	-	969	-	-	969
Биет бус хөрөнгө рүү ангилсан (Тодруулга 12.1)	-	-	-	(13,508)	-	-	(13,508)
2017 оны 12 сарын 31	-	1,805,889	28,071,080	923,731	552,506	-	31,353,206
Элэгдэл	-	963,243	4,664,262	602,948	186,762	-	6,417,215
Хасагдсан	-	-	(480,310)	(203,245)	(30,374)	-	(713,929)
Дахин ангилал	-	(51,254)	48,439	2,815	-	-	-
2018 оны 12 сарын 31	-	2,717,878	32,303,471	1,326,249	708,894	-	37,056,492
Дансны үнэ:							
2017 оны 12 сарын 31	2,576,718	21,666,613	21,289,389	2,308,476	1,193,116	8,240,463	57,274,775
2018 оны 12 сарын 31	2,576,718	40,628,886	31,625,228	2,786,055	1,305,028	3,458,145	82,380,060

Дуусаагүй барилга нь Группын барьж буй үйлдвэрийн барилга болон угсарч суурьлуулж дуусаагүй тоног төхөөрөмжтэй холбоотой.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

10. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

10.1 Барьцаалсан үндсэн хөрөнгө

2018 оны 12 сарын 31-ний байдлаар нийтдээ 58,984 сая төгрөг (2017 оны 12 сарын 31: 38,455 сая төгрөг)-ийн дансны үнэтэй газар, барилга, дуусаагүй барилга ба тоног төхөөрөмжийг банкны зээлэнд барьцаалсан байна (тодруулга 15.1-г харна уу).

10.2 Газар болон барилгын бодит үнэ цэнийн хэмжилт

Группын барилга болон газар нь хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтыг хассан дахин үнэлсэн дүнгээр тусгагдсан. Группын барилга 2015 оны 12 сарын 31-нээр, газар 2016 оны 12 сарын 31-нээр Группээс хараат бус мэргэжлийн үнэлгээний тодорхойлсон бодит үнэ цэнээр хэмжигдсэн.

Газрын бодит үнэ цэнийг ижил төрлийн хөрөнгийн зах зээлд арилжаалагдсан үнийг ашиглан зах зээлийн жишиг үнийн хандлагаар тодорхойлсон.

Групп 2018 оны 12 сарын 31-ний байдлаар дээрх хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг дахин үнэлсэн ба 2018 оны 12 сарын 31-ний байдлаарх дансны үнэд нөлөөлөхүйц материаллаг дүнтэй залруулга үүсээгүй учир НББОУС 16-н дагуу дансны үнийг тохируулаагүй болно.

Тайлант хугацааны эцсээрх Группын барилга болон газрын бодит үнэ цэнийн мэдээлэл:

	2018		2017	
	Зэрэглэл 3	2018 оны 12 сарын 31-нээрх бодит үнэ цэнэ	Зэрэглэл 3	2017 оны 12 сарын 31-нээрх бодит үнэ цэнэ
Газар	2,576,718	2,576,718	2,576,718	2,576,718
Барилга	40,628,886	40,628,886	21,666,613	21,666,613
	43,205,604	43,205,604	24,243,331	24,243,331

Газар болон барилгыг өртгөөр нь бүртгэж байсан бол газар болон барилгын дансны үнэ дараах байдалтай байна:

	2018	2017
Газар	300,000	300,000
Барилга	29,834,625	8,295,634

10.3 Бүрэн элэгдсэн үндсэн хөрөнгө

	2018	2017
Өртөг	9,652,382	5,675,205

10.4 Бараа материал болон ашиг, алдагдлаар бүртгэсэн элэгдэл ба хорогдол

Борлуулалт ба ерөнхий удирдлагын зардлаар бүртгэсэн элэгдэл ба хорогдол:

	2018	2017
Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,117,579	827,393
Биет бус хөрөнгийн хорогдол	141,663	79,513
	1,259,242	906,906

Тайлант жилд 5,299 сая төгрөг (2017 оны 12 сарын 31-нээр 4,727 сая төгрөг)-ийн элэгдлийн зардлыг бараа материалын өртөгт капиталжуулсан.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

11. Охин компани дахь хөрөнгө оруулалт

Охин компанийн нэр	Үндсэн үйл ажиллагаа	Үйл ажиллагаа явуулж буй улс	Группын эзэмшлийн хувь	
			2018	2017
Говь Кашмир Европ	Гадаад худалдаа	Герман	100%	100%
Говь Кашмир (Өвөр Монгол)	Гадаад худалдаа	Хятад	100%	100%
Говь Кашмир Эс Фи Ар Эл	Гадаад худалдаа	Бельги	100%	100%

12. Бусад эргэлтийн бус хөрөнгө

	2018	2017
Биет бус хөрөнгө	235,903	280,115
Түрээсийн дэлгүүрт байршуулсан барьцаа	119,794	169,928
Бусад хөрөнгө	-	9,000
	355,697	459,043

12.1 Биет бус хөрөнгө

	2018	2017
Дансны үнэ		
1 сарын 1	280,115	236,742
Худалдан авалт	105,736	38,503
Данснаас хассан	(8,285)	-
Үндсэн хөрөнгөөс ангилсан (Тодруулга 10)	-	111,150
Тухайн жилийн хорогдол	(141,663)	(106,280)
12 сарын 31-нээрх цэвэр дүн	235,903	280,115

Биет бус хөрөнгө нь 172,014 мянган төгрөгийн програм хангамж (2017 оны 12 сарын 31: 190,143 мянган төгрөг) болон 63,889 мянган төгрөгийн барааны тэмдэгт (2017 оны 12 сарын 31: 89,972 мянган төгрөг)-ээс бүрдэж байна.

13. Дансны ба бусад өглөг

	2018	2017
Дансны өглөг	1,353,375	2,226,192
Цалингийн өглөг	1,465,517	985,822
Бусад татварын өглөг (орлогын татварын өглөг ороогүй)	938,445	1,275,324
Ногдол ашгийн өглөг (Тодруулга 18-г үзнэ үү)	168,325	169,858
Харилцагчаас авсан урьдчилгаа	-	1,638,481
Бусад өглөг	815,390	76,832
	4,741,052	6,372,509

Дансны өглөг нь голчлон гадаадын болон дотоодын бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөгөөс бүрдэх ба төлбөрийн нөхцөл нь 30-90 хоногийн хооронд байна. Групп нь бүх өглөг гэрээний нөхцлийн дагуу төлөгдсөнийг баталгаажуулах санхүүгийн эрсдлийн удирдлагын бодлоготой.

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

13. Дансны ба бусад өглөг (үргэлжлэл)

13.1 Гэрээний өр төлбөр

	2018	2017
Харилцагчаас авсан урьдчилгаа	1,037,239	-
	1,037,239	-

2018 оны 12 сарын 31-нээрх гэрээний өр төлбөр 2019 онд борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрөгдөж бүртгэгдэнэ.

14. Буцаах эрхтэй барааны өр төлбөр

	2018	2017
Буцаах эрхтэй барааны өр төлбөр		
Борлуулалтын буцаалтаас үүссэн	466,329	-
	466,329	-

Буцаах эрхтэй барааны өр төлбөр нь борлуулалтын гэрээний дагуу харилцагчдын худалдан авсан барааг буцаах эрхтэй холбоотой. Борлуулалтын орлогын хүлээн зөвшөөрөх үед буцаах эрхтэй барааны өр төлбөр болон хүлээгдэж буй борлуулалтын буцаалтыг тооцоолон бүртгэдэг. Групп хүлээгдэж буй борлуулалтын буцаалтыг өмнөх жилүүдийн түүхэн мэдээлэлд үндэслэн хүлээгдэж буй үр дүнгийн аргаар тооцоолсон.

15. Зээл

	2018	2017
Богино хугацаат зээл	113,722,628	40,469,033
Урт хугацаат зээл	6,000,000	30,202,780
	119,722,628	70,671,813

Зээлийн нөхцөл, төрлөөр:

	2018		2017	
	Богино хугацаат зээл	Урт хугацаат зээл	Богино хугацаат зээл	Урт хугацаат зээл
Барьцаат зээл:				
Монгол Улсын Хөгжлийн Банк (i)	53,143,360	-	19,417,040	-
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк ("ЕСБХБ") (ii)	42,286,720	-	-	14,562,780
Худалдаа Хөгжлийн Банк (iii)	9,640,000	6,000,000	120,000	15,640,000
Голомт Банк (iv)	6,343,008	-	5,928,952	-
Хас Банк (v)	-	-	14,562,780	-
Хүүгийн өглөг	2,309,540	-	440,261	-
Нийт зээл	113,722,628	6,000,000	40,469,033	30,202,780

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

15. Зээл (үргэлжлэл)

Группын зээлийн үр ашигт хүүгийн түвшин (зээлийн гэрээний хүүтэй тэнцүү) нь дараах байдалтай байна:

	2018	2017
Үр ашигт хүүгийн хувь:		
Тогтмол хүү	8% - 12%	7% - 9%
Хувьсах хүү	8.51%	7.35%

15.1 Зээлийн гэрээний хураангуй

(i) 2018 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар Монгол Улсын Хөгжлийн Банкнаас дараах зээлүүд авсан:

- Групп 2017 оны 7 сард Монгол Улсын Хөгжлийн Банкнаас 8 сая ам.доллар (18,871,920 мянган төгрөг)-ийн зээлийг 11.3 сарын хугацаатайгаар жилийн 8 хувийн хүүтэйгээр төлбөрийн чадвар болон ажлын капитал аа нэмэгдүүлэхээр авсан. Уг зээлийн гэрээг 2018 оны 6 дугаар сард сунгаж "2019 оны 6 дугаар сарын 15-ны өдөр" болгон өөрчилсөн. Уг зээлд Группын бараа материалыг барьцаалсан.
- Групп нь 2018 оны 5 сард түүхий эд материал худалдан авах зорилгоор 48 тэрбум төгрөгийг жилийн 12 хувийн хүүтэй авсан. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар 16 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд үлдэгдэл 32 тэрбум төгрөг байна. Зээлийн хугацаа 2019 оны 12 дугаар сард дуусна. Уг зээлд Группын барилга, газар болон бараа материалыг барьцаалсан.

(ii) 2018 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас дараах зээлүүд авсан:

- Групп 2017 оны 9-р сард 6 сая ам.доллар (14.7 тэрбум төгрөг), 2018 оны 2 сард 4.0 сая ам.доллар (9.6 тэрбум төгрөг) болон 2018 оны 7 сард 6 сая ам.долларын (14.7 тэрбум төгрөг) буюу нийт 16.0 сая ам.доллар-ын зээлийг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХ Банк)-наас төлбөрийн чадвар болон ажлын капитал аа нэмэгдүүлэхээр авсан ба уг зээлийн жилийн хүү нь 5.3-6.0 хувийн суурь хүү нэмэх нь 6 сарын LIBOR хүү. Уг зээлээс 2019 онд 1.8 сая ам.доллар, 2020 онд 2.9 сая ам.доллар, 2021-2025 онуудад нийт 11.3 сая ам.доллар тус тус төлнө. Тус зээлд Группын барилга, үйлдвэрийн тоног төхөөрөмж болон бараа материал барьцаалсан. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар Групп зээлийн гэрээнд тусгагдсан зарим санхүүгийн харьцааны шалгууруудыг хангаагүй бөгөөд уг зөрчилтэй холбоотой "Зөвшөөрсөн захидал (waiver letter)"-г 2019 оны 3 сарын 6-ны өдөр ЕСБХ Банкнаас авсан тул уг зээлийг богино хугацаат зээлээр ангилсан.

(iii) 2018 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар Худалдаа Хөгжлийн Банкнаас дараах зээлүүд авсан:

- Групп 2016 оны 12 сард хөрөнгө оруулалтын зориулалтаар 6.0 тэрбум төгрөг, жилийн 8 хувийн хүүтэй, 60 сарын хугацаатай Худалдаа, Хөгжлийн банкнаас зээлсэн. Уг зээлээс 2020 оны 1 сарын 31-нээс эхлэн сарын 170 сая төгрөгийг хувиарын дагуу төлөх ба 2021 оны 12 сарын 21-нд бүрэн төлж дуусна. Тус зээлд Группын барилга болон газрыг барьцаалсан. Уг зээл нь Азийн Хөгжлийн Банкнаас санхүүжигдсэн.
- Групп 2015 онд Засгийн Газраас дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих бодлогын хүрээнд олгосон зээлээс 10.0 тэрбум төгрөг, жилийн 9 хувийн хүүтэй зээлийг Худалдаа, Хөгжлийн банкнаас авсан. Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу сард 10 сая төгрөгийг төлөх бөгөөд 2019 оны 12 сард бүрэн төлөгдөж дуусна. Энэхүү зээлд Группын барилга болон газрыг барьцаалсан байсныг 2018 оны 3 дугаар сард Таван Богд Кашмер ХХК (толгой компани)-ийн өмчлөлийн Говь ХК-ийн 600,000 ширхэг хувьцаа болгон өөрчилсөн.
- Групп 2018 оны 4 сард жилийн 12 хувийн хүүтэй, 3 сарын хугацаатай 20 сая ам.долларын зээлийг (48 тэрбум төгрөг) эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зориулалтаар авсан. Уг зээлд Группын бараа материалын барьцаалсан байсан бөгөөд зээлийг 2018 оны 6 сард бүрэн төлж дууссан.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

15. Зээл (үргэлжлэл)

15.1 Зээлийн гэрээний хураангуй (үргэлжлэл)

(iv) 2018 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар Голомт Банкнаас дараах зээлүүд авсан:

- Групп 2017 оны 1 сард болон 2017 оны 3 сард тус тус 725,968 евро (1,926,546 мянган төгрөг) болон 1,320,000 еврогийн (3,825,188 мянган төгрөг)-ийн зээлүүдийг жилийн 8.2 хувийн болон 7.8 хувийн хүүтэйгээр авсан. Эдгээр зээлүүдийг 2018 оны 1-р сар болон 2018 оны 2-р сард тус тус бүрэн төлж дуусгасан. Уг зээлд Группын барилга болон газрыг барьцаалсан.
- Групп 2018 оны 4 сард 10 сая ам.долларын зээлийн шугамыг 24 сарын хугацаатай, 8.4 хувийн хүүтэй нээсэн. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар 2.4 сая доллар (6.3 тэрбум төгрөг)-г авч ашигласан байна. Зээлийн үндсэн төлбөрийг 2020 оны 2 сараас 4 сарын хооронд тэнцүү хуваан төлнө. Уг зээлд Группын барилга, газар болон бараа материалыг барьцаалсан. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас авсан зээлийн гэрээнд тусгагдсан зарим санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд зөрчигдсөний улмаас уг зээлийг богино хугацаат зээлээр ангилсан нь Голомт Банкны зээлийн гэрээний харьцаа үзүүлэлт зөрчигдөхөд нөлөөлсөн.

(v) Групп 2017 оны 10 сард Хас Банканд 6 сая ам.доллар (14,778,120 мянган төгрөг)-ийн зээлийн шугамыг 12 сарын хугацаатайгаар жилийн 8 хувийн хүүтэйгээр нээсэн. Энэхүү зээлийн гэрээг 2018 оны 9 сард өөрчлөлт оруулан жилийн 9 хувийн хүүтэйгээр 12 сарын хугацаатайгаар сунгасан. Зээлийн шугам 2018 оны 12 сарын 31-ний байдлаар бүрэн төлөгдсөн бөгөөд уг зээлийн шугамд Группын бараа материалыг барьцаалсан.

15.2 Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийг тохируулах нь

	2017 оны 12 сарын 31	Санхүүжилтийн мөнгөн урсгал		Ханшийн зөрүү	Бусад өөрчлөлт (i)	2018 оны 12 сарын 31
		Орох урсгал	Гарах урсгал			
Банкны зээл (Тодруулга 15)	70,671,813	186,137,535	(144,231,210)	5,275,211	1,869,279	119,722,628
Холбоотой талын зээл (Тодруулга 26.2)	-	5,586,782	(5,586,782)	-	-	-
	70,671,813	191,724,317	(149,817,992)	5,275,211	1,869,279	119,722,628

	2016 оны 12 сарын 31	Санхүүжилтийн мөнгөн урсгал		Ханшийн зөрүү	Бусад өөрчлөлт (i)	2017 оны 12 сарын 31
		Орох урсгал	Гарах урсгал			
Банкны зээл (Тодруулга 15)	43,514,943	100,162,894	(74,023,755)	704,404	313,327	70,671,813
Холбоотой талын зээл (Тодруулга 26.2)	-	17,046,070	(17,046,070)	-	-	-
	43,514,943	117,208,964	(91,069,825)	704,404	313,327	70,671,813

(i) Бусад өөрчлөлт нь хуримтлуулсан хүү болон зээл авахтай холбоотой гарсан зардлуудыг агуулна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

16. Урт хугацаат өглөг

	2018	2017
Бусад урт хугацаат өглөг	3,231,805	-
	3,231,805	-

Бусад урт хугацаат өглөгт үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах зорилгоор хийсэн жилийн 3%-н хүүтэй гэрээний дүн багтсан. Уг зээл нь 2020 онд бүрэн төлөгдөж дуусах бөгөөд худалдан авч буй тоног төхөөрөмжийг барьцаалсан.

17. Хувьцаат капитал

	Хувьцааны тоо		Хувьцаат капитал	
	2018	2017	2018	2017
Эхний болон эцсийн үлдэгдэл	780,112,500	7,801,125	780,113	780,113
	780,112,500	7,801,125	780,113	780,113

2018 оны 10 сарын 1-ны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу Компани нь өөрийн 1 ширхэг хувьцааг 100 ширхэг болгон хуваасан.

2018 оны 12 сарын 31-нээр Компанийн 780,112.5 мянган төгрөгийн хувьцаат капитал нь нэг бүр нь 1 төгрөгийн үнэтэй 780,112,500 ширхэг (2017 оны 12 сарын 31: нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 7,801,125 ширхэг) зөвшөөрөгдсөн ба гаргасан хувьцаанаас бүрдэж байна.

Компани нь Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, улсын бүртгэлийн 2076357 тоот регистрийн дугаартай гэрчилгээ авсан болно.

18. Ногдол ашиг

	2018	2017
Ногдол ашгийн өглөгийн эхний үлдэгдэл	169,858	291,394
Зарласан ногдол ашиг	1,716,248	1,560,225
Ногдол ашгийн төлөлт	(1,717,781)	(1,681,761)
Ногдол ашгийн өглөгийн эцсийн үлдэгдэл	168,325	169,858

2018 оны 2-р сарын 2-ний өдөр Группын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор нэгж хувьцаанд 220 төгрөг (нийт 1,716,248 мянган төгрөг)-ийн ногдол ашиг зарласан (2017 онд нэгж хувьцаанд 200 төгрөгийн, нийт 1,560,225 мянган төгрөгийн ногдол ашиг зарласан).

19. Нэгж хувьцаанд хувьцаанд ногдох ашиг

	2018	2017
Тайлант жилийн ашиг (мянган төгрөгөөр)	17,764,164	17,502,984
Энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	780,112,500	780,112,500
Нэгж хувьцаанд ногдох ашиг (мянган төгрөгөөр)	0.02	0.02

2018 оны 10 сарын 1-ны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу Компани нь өөрийн 1 ширхэг хувьцааг 100 ширхэг болгон хуваасан. Хувьцааны хуваагдлын улмаас энгийн хувьцаа болон нэгж хувьцаанд ногдох ашигт нөлөөлөх нөлөөллүүд буцаан мөрдөх зарчмаар тохируулагдсан.

Нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцохдоо Группын ашгийг жилийн туршид эргэлтэнд байсан хувьцааны жигнэсэн дундажаар тооцоолно.

Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашгийг тооцоолохдоо боломжит бүх хувьцааг хорогдуулах нөлөөтэй хөрвүүлснээр жигнэсэн дундаж хувьцааны жигнэсэн дундажийг тохируулна.

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

20. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

	2018	2017
Эхний үлдэгдэл	15,647,697	15,647,697
Эцсийн үлдэгдэл	15,647,697	15,647,697

21. Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

	2018	2017
Эхний үлдэгдэл	(28,274)	-
Гадаад дахь охин компаниас үүссэн валют хөрвүүлэлтийн зөрүү	(106,929)	(28,274)
Эцсийн үлдэгдэл	(135,203)	(28,274)

22. Орлогын татварын зардал

	2018	2017
Тайлант жилийн татварын зардал:		
Тайлант жилийн орлогын татварын зардал	6,650,891	6,087,201
Хойшлогдсон татварын зардал:		
Тайлант жилд тооцсон хойшлогдсон татварын өгөөж	(1,166,623)	(147,924)
	5,484,268	5,939,277

22.1 Тайлант жилийн татвар

Тайлант жилийн татварын зардлыг санхүүгийн тайлангаарх цэвэр ашгаас тооцсон тохируулга:

	2018	2017
Санхүүгийн тайлангаарх татварын өмнөх цэвэр ашиг	23,248,432	23,442,261
Татварын өмнөх ашгаас татварын хувь хэмжээгээр тооцсон татварын зардал (25%)	5,812,108	5,860,565
Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл	(459,916)	(42,477)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөөлөл	417,664	418,203
Хүүгийн орлогын татварын нөлөөлөл	(34,348)	(91,014)
Өмнө бүртгээгүй ба түр зөрүүний нөлөөллийг одоо хойшлогдсон татварын өрөөр бүртгэсний нөлөөлөл	-	8,035
Охин компаниудын ашиглаагүй татварын алдагдал дээр хойшлогдсон татварын хөрөнгө бүртгээгүйн нөлөөлөл	198,760	235,965
Татварын бага хувь хэмжээний нөлөөлөл	(450,000)	(450,000)
Нийт орлогын татварын зардал	5,484,268	5,939,277

Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу 3 тэрбум төгрөг хүртэлх албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 3 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулдаг.

22.2 Орлогын татварын өглөг

	2018	2017
Эхний үлдэгдэл	1,971,410	2,196,930
Тайлант жилийн татварын зардал	6,650,891	6,087,201
Төлсөн орлогын татвар	(6,867,067)	(6,312,721)
Эцсийн үлдэгдэл	1,755,234	1,971,410

37

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

22. Орлогын татварын зардал (үргэлжлэл)

22.3 Хойшлогдсон татварын хөрөнгө

Хойшлогдсон татварын хөрөнгө нь гадаад валютаар үүссэн мөнгө болж хөрвөх хөрөнгө болон өр төлбөрийн ханшийн тэгшитгэлийн улмаас үүссэн татвар ногдох эсвэл татвараас хасагдах түр зөрүүтэй холбоотой.

2018	Эхний үлдэгдэл	Ашиг алдагдлаар бүртгэсэн дүн	Эцсийн үлдэгдэл
Хойшлогдсон татварын хөрөнгө:			
Санхүүгийн хөрөнгө	(44,447)	(120,066)	(164,513)
Үндсэн хөрөнгө	(32,141)	(15,241)	(47,382)
Санхүүгийн өр төлбөр	(9,594)	91,534	81,940
Зээл	170,113	1,210,396	1,380,509
	83,931	1,166,623	1,250,554

2017	Эхний үлдэгдэл	Ашиг алдагдлаар бүртгэсэн дүн	Эцсийн үлдэгдэл
Хойшлогдсон татварын хөрөнгө :			
Санхүүгийн хөрөнгө	(68,344)	23,897	(44,447)
Үндсэн хөрөнгө	-	(32,141)	(32,141)
Санхүүгийн өр төлбөр	2,885	(12,479)	(9,594)
Зээл	1,466	168,647	170,113
	(63,993)	147,924	83,931

23. Борлуулалтын орлого ба зардал

23.1 Борлуулалтын орлого

	2018	2017
Сүлжмэл бүтээгдэхүүн	85,560,542	67,101,195
Оёмол бүтээгдэхүүн	42,170,254	26,462,796
Нэхмэл бүтээгдэхүүн	34,853,446	27,469,670
Үйлчилгээний орлого	9,356,857	579,078
Бусад	1,498,276	2,812,368
	173,439,375	124,425,107

23.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

	2018	2017
Сүлжмэл бүтээгдэхүүн	49,842,077	40,231,861
Оёмол бүтээгдэхүүн	17,861,181	16,855,492
Нэхмэл бүтээгдэхүүн	26,171,295	14,304,438
Үйлчилгээний орлого	7,445,051	449,019
Бусад	827,923	2,039,840
	102,147,527	73,880,650

38

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

23. Борлуулалтын орлого ба зардал (үргэлжлэл)

23.3 Зардлын төрлөөр

	2018	2017
Бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэл, замд яваа бараа материалын өөрчлөлт	(27,286,855)	(24,917,169)
Ашигласан түүхий эд материал	94,921,005	71,864,481
Цалин ба түүнтэй холбоотой зардлууд	33,092,258	24,114,521
Элэгдэл хорогдлын зардал (Тодруулга 10 болон 12.1)	6,114,310	5,633,556
Зар сурталчилгааны зардал	4,879,579	1,748,725
Харилцагчийн урамшууллын зардал	4,010,354	3,970,629
Хангамжийн зардал	2,837,338	1,473,015
Ашиглалтын зардал	2,645,031	2,648,543
Банкны үйлчилгээний шимтгэл	2,014,738	1,368,564
Засвар үйлчилгээний зардал	1,865,874	584,750
Хөдөлмөр хамгааллын зардал	1,813,633	1,580,310
Түрээсийн зардал	1,488,680	1,077,970
Тээврийн зардал	1,082,841	166,417
Бизнесийн томилолтын зардал	979,614	873,578
Даатгалын зардал	349,241	524,135
Харуул, хамгаалалтын зардал	302,999	259,834
Мэргэжлийн үйлчилгээний хөлс	257,859	156,464
Түлш, шатахууны зардал	221,833	345,634
Хүний нөөц ба бусад холбоотой зардлууд	103,907	259,452
Харилцаа холбооны зардал	55,742	104,474
Бусад зардал	1,897,937	925,143
Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг, борлуулалт маркетингийн зардал болон ерөнхий удирдлагын зардал	133,647,918	94,763,026

24. Хүүгийн ба бусад орлого

	2018	2017
Хүүгийн орлого	228,987	606,757
Түрээсийн ба бусад орлого	313,058	242,059
	542,045	848,816

25. Бусад олз ба (гарз)

	2018	2017
Гадаад валютын ханшийн зөрүүгийн алдагдал	(6,379,898)	(774,419)
Үндсэн хөрөнгө болон бараа материалыг бүртгэлээс хассанаас илүү давсан даатгалын нөхөн олговор	-	383,784
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз, цэвэр дүнгээр	(181,707)	(181,228)
	(6,561,605)	(571,863)

2017 оны 6 сард Говь ХК-ний үйлдвэрийн барилгын дээврийн ажил гуравдагч этгээдээр гүйцэтгэгдэж байх үед гал алдаж дээвэр бүхэлдээ шатсантай холбоотойгоор даатгалын компаниас 4,400 сая төгрөгийн нөхөн төлбөр хүлээн авсан. Нийт хохирлын дүн 4,016 сая төгрөг (барилгын дээвэр 3,253 сая төгрөг, түүхий эд материал 763 сая төгрөг) бүхий данснаас хассан үндсэн хөрөнгө болон данснаас хассан бараа материалыг тайлант жилд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

26. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл

26.1 Холбоотой талуудын үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах үлдэгдэлтэй байна:

	2018	2017
Толгой компаниас авах дансны авлага	-	7,909
Таван Богд Трейд ХХК (өмнөх толгой компани)	-	7,909
Бусад холбоотой талаас авах дансны авлага	500	500
	500	8,409

26.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээнүүдийг Группын толгой компанитай хийсэн:

Таван Богд Трейд ХХК (өмнөх толгой компани)	2018	2017
Толгой компанид өгсөн санхүүжилт	-	11,005,592
Толгой компанид өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	-	25,010,400
Толгой компаниас авсан санхүүжилт (Тодруулга 15.2)	5,586,782	2,066,070
Толгой компаниас авсан санхүүжилтэнд төлсөн дүн (Тодруулга 15.2)	5,586,782	2,066,070
Толгой компаниас хүлээн авсан хүүгийн орлого	-	316,715
Толгой компаниас авсан худалдан авалт	326,281	72,722
Толгой компанид төлсөн хүүгийн зардал	58,102	868
Толгой компанид хийсэн борлуулалт	3,600	17,993

2018 оны 12 сарын 31-р дуусгавар болсон тайлант жилд Таван Богд Кашмир ХХК (толгой компани)- хийсэн гүйлгээ байхгүй.

Дараах ажил гүйлгээнүүдийг нэгдсэн хяналтанд байдаг бусад холбоотой талуудтай хийсэн:

	2018	2017
Холбоотой талд өгсөн санхүүжилт	3,000,314	424,888
Холбоотой талд өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	3,000,314	420,080
Холбоотой талаас авсан санхүүжилт (Тодруулга 15.2)	-	14,980,000
Холбоотой талаас авсан санхүүжилтэнд төлсөн дүн (Тодруулга 15.2)	-	14,980,000
Холбоотой талаас хүлээн авсан хүүгийн орлого	6,480	5,407
Холбоотой талаас авсан худалдан авалт	3,859,283	1,423,141
Холбоотой талд хийсэн борлуулалт	9,979,074	245,830
Холбоотой талаас авсан түрээсийн орлого	-	144,608
Холбоотой талд төлсөн хүүгийн зардал	-	498,660

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцлөөр хийгдсэн.

2017 оны 12 сарын 31-нээрх толгой компаниас авах авлага нь хангамжийн материал худалдан авахаар төлсөн урьдчилгаа төлбөртэй холбоотой. Зээлээрх худалдан авалт болон борлуулалтын нөхцөл нь 30 хоног бөгөөд худалдан авалтын гэрээний дагуу төлбөрөө төлдөг. Борлуулалт болон худалдан авалтаас үүссэн авлага болон өглөг дээр хүү тооцдоггүй. Холбоотой талуудын дансны үлдэгдэл нь барьцаагүй ба тайлант жил эсвэл өмнөх жилтэй холбоотойгоор найдваргүй эсвэл эргэлзээтэй авлагын зардал бүртгээгүй.

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

26. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл (үргэлжлэл)

26.3 Үндсэн удирдлагын цалин, урамшуулал

Үндсэн удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн тайлант үеийн цалин, урамшуулал дараах байдалтай байна. Үүнд:

	2018	2017
Тайлант үеийн цалин урамшуулал	1,903,367	1,142,619

Группын удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн цалинд үндсэн цалин болон урамшуулалт цалин багтсан.

27. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага

Группын санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны ба бусад авлага, дансны ба бусад өглөг болон банкны зээлээс бүрддэг.

Санхүүгийн хэрэгслийн ангилал:

	2018	2017
Санхүүгийн хөрөнгө:		
Дансны ба бусад авлага, хорогдуулсан өртгөөр	16,720,671	18,827,961
Санхүүгийн өр төлбөр:		
Хорогдуулсан өртгөөр	125,291,523	73,144,695

Групп нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд эдгээр санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэг. Групп арилжаалах болон санхүүгийн хамгаалалт хийх зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэггүй болно.

Группын санхүүгийн хэрэгслээс үүсэлтэй үндсэн эрсдлүүдийг хүүгийн эрсдэл, гадаад валютын эрсдэл, зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэл гэж ангилдаг.

Группын санхүүгийн эрсдлийн удирдлагын бодлогыг хураангуйлан өгүүлбэл:

27.1 Зээлийн эрсдлийн удирдлага

Группын харилцагчид зээлийн нөхцлөөр худалдан авалт хийгээд түүнийгээ төлж чадахгүй болсноор Групп-д зээлийн эрсдлийг үүсгэдэг.

Одоогийн байдлаар зах зээл дээр хараат бус үнэлгээний байгууллага байхгүй байна. Иймээс Группын зүгээс баримталдаг зээлийн борлуулалтын бодлогын дагуу удаан хугацаанд харилцсан, найдвартай харилцагчдад зээлийн лимит олгож баталдаг. Жил бүр худалдан авагчтай хийсэн борлуулалтын гэрээг шинэчилж гэрээний хэрэгжилтийг байнга хянадаг.

Группын дансны авлагыг даатгуулсан эсвэл аккредитив гэрээгээр баталгаажуулснаас бусдаар санхүүгийн хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдлийг хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар даатгуулсан эсвэл аккредитив гэрээгээр баталгаажуулсан дансны авлага 8,855 сая төгрөг (2017 оны 12 сарын 31: 8,818 сая төгрөг) байна.

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

27. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

27.1 Зээлийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

Группын удирдлага нь өндөр зээлийн зэрэглэлтэй дотоодын банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан банкны харилцах дансанд харгалзах санхүүгийн зээлийн эрсдлийн түвшинг бага гэж үзсэн. Группын удирдлага нь дефолтын магадлал нь бага гэж үзсэн тул нөөц санг байгуулаагүй.

Группын удирдлага дансны авлагын эргэн төлөгдөх магадлалыг үнэлэхийн тулд авлага цуглуулалтын түүхэн мэдээлэл болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг харгалзан багцын болон тусдаа үнэлгээ хийдэг. Групп нь нөөцийн матриц, тооцоолол, зээлийн түүхэн мэдээлэл, зээлдэгчийн хугацаа хэтрэлттэй авлагын статусыг одоогийн болон ирээдүйн эдийн засгийн чиг хандлагыг харгалзан тохируулах байдлаар хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолдог. Иймд эдгээр хөрөнгийн зээлийн эрсдлийн багц нь уг авлагын хугацаа хэтэрсэн статусаар тодорхойлсон нөөцийн матрицад үндэслэн толилуулагддаг.

Дансны авлагын үнэ цэнийн бууралтын мэдээллийг тодруулга 6-аас харна уу.

Группын удирдлага нь бусад авлагын эргэн төлөгдөх магадлалыг үнэлэхдээ авлагын түүхэн мэдээлэл, хугацаа хэтэрсэн авлагын мэдээлэл, одоогийн болон ирээдүйг таамагласан мэдээллийг харгалзан тохируулах байдлаар багцалсан болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Группын удирдлагын хийсэн үнэлгээгээр бусад авлагад анх бүртгэлд тусгаснаас хойш үлэмж хэмжээний зээлийн эрсдэл үүсээгүй гэж үнэлсэн ба эрсдлийн түвшин нь материаллаг бус учир үнэ цэнийн бууралт бүртгээгүй болно.

Дансны авлагын үлдэгдлийн 41% хувийг гадаадын 5 том худалдан авагч эзэлж байна (2017 онд: 29%).

Группын удирдлага харилцагчид болон холбоотой талаас авах авлагаа цагт нь цуглуулж буй эсэхэд хяналт тавьдаг.

Дансны авлагын нөхцөл байдлыг үндэслэн зээлийн үнэлгээг тогтмол хийдэг ба шаардлагатай гэж үзвэл төлбөрийн эрсдлийг даатгуулдаг. Мөн Групп худалдан авагчаас дараагийн захиалгыг гүйцэтгэхээс өмнө үлдэгдэл төлбөрөө төлсөн байхыг шаарддаг.

27.2 Хөрвөх чадварын эрсдлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Групп өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Групп нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Группын нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг байнга барьж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Группын Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хөрвөх чадварын эрсдлийн удирдлагыг хариуцдаг ба Группын богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Групп санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавхи, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдлийг удирддаг.

Хүснэгтэнд Группын дериватив бус санхүүгийн өр төлбөрийг гэрээгээрх төлөх хугацаагаар нь ангилан тайлагнасан. Энэхүү хүснэгтийн дүнгүүд нь үндсэн төлбөр болон хүүг агуулсан болно. Хүснэгтэн дэх мэдээлэл нь Группын төлбөр төлөх шаардлагатай хамгийн эхний хугацаанд үндэслэн дискантлаагүй мөнгөн гүйлгээг харуулж байна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

27. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

	Жигнэсэн дундаж хүүгийн түвшин	1 сараас		3 сараас		Нийт	Дансны үнэ
		бага	1-3 сар	1 жил	1-5 жил		
2018 оны 12 сарын 31							
Хүүгүй хэрэглүүр	-	2,104,890	195,487	36,713	-	2,337,090	2,337,090
Хувьсах хүүтэй хэрэглүүр	8.51%	1,734,534	859,956	43,054,189	-	45,648,679	44,265,765
Тогтмол хүүтэй хэрэглүүр	9.27%	8,478,021	1,252,723	63,909,309	9,808,118	83,448,171	78,688,668
		12,317,445	2,308,166	107,000,211	9,808,118	131,433,940	125,291,523

	Жигнэсэн дундаж хүүгийн түвшин	1 сараас		3 сараас		Нийт	Дансны үнэ
		бага	1-3 сар	1 жил	1-5 жил		
2017 оны 12 сарын 31							
Хүүгүй хэрэглүүр	-	181,652	416,587	1,874,643	-	2,472,882	2,472,882
Хувьсах хүүтэй хэрэглүүр	7.35%	89,255	178,511	803,298	16,704,907	17,775,971	14,562,780
Тогтмол хүүтэй хэрэглүүр	8.07%	2,491,540	4,525,207	36,072,672	17,447,632	60,537,051	56,109,033
		2,762,447	5,120,305	38,750,613	34,152,539	80,785,904	73,144,695

27.3 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн хувь, гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Группын орлого эсвэл эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх эрсдэл юм. Групп зах зээлийн үндсэн эрсдэл болох хүүгийн эрсдэл болон гадаад валютын эрсдлийг дараах дурдсанаар хянаж удирддаг.

27.3.1 Зээлийн хүүгийн эрсдлийн удирдлага

Групп тогтмол болон хувьсах хүүтэй зээлүүдтэй учраас зээлийн хүүгийн эрсдэлтэй байна. Мөнгөн гүйлгээний хүүний түвшний эрсдэл нь хувьсах хүүтэй зээлээс үүссэн ба бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдэл нь тогтмол хүүтэй зээлээс үүсдэг. Энэхүү эрсдлийг Групп тогтмол болон хөвөгч хүүтэй зээлийн зохистой байдлыг хангах замаар удирддаг. Зээлийн хүүгийн эрсдлийг удирдахдаа хамгаалалтын хэрэглүүрийг ашигладаггүй.

Группын санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүүгийн түвшний талаар хөрвөх чадварын эрсдлийн удирдлагын хэсэгт дэлгэрэнгүй дурьдсан болно.

Зээлийн хүүгийн мэдрэмжийн шинжилгээ

Доор дурьдсан мэдрэмжийн шинжилгээг тайлант хугацааны эцэст байгаа дериватив бус хэрэгслүүд дэх хүүгийн түвшний нөлөөллийг үндэслэн тодорхойлсон. Хувьсах хүүтэй өр төлбөрийн шинжилгээг бэлтгэхдээ тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй өр төлбөрийг тайлант хугацааны жилийн турш төлөгдөөгүй гэж үзсэн. Гүйцэтгэх удирдлагын түвшинд хүүгийн түвшний эрсдлийг үнэлэхдээ хүүгийн түвшний боломжит өөрчлөлтийг 50 функтээр өснө/буурна гэж үзсэн.

Хэрэв бусад бүх хувьсах үзүүлэлт тогтмол байх үед хүүгийн түвшин 50 функтээр өсч/буурвал 2018 оны 12 сарын 31-нээрх татварын дараах цэвэр ашиг 797,778 мянган төгрөг (2017 оны 12 сарын 31: 148,047 мянган төгрөг) - өөр өснө/буурна. Энэ нь Группын хувьсах хүүтэй зээлүүдэд хамааралтай.

Группын удирдлага хүүгийн түвшингийн өөрчлөлт нь хадгаламж болон харилцах дансны хүүгийн орлогод нөлөөлөөгүй учраас шинжилгээ бэлтгээгүй болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

27. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

27.3 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

27.3.2 Гадаад валютын эрсдлийн удирдлага

Групп-д төгрөгөөс өөр валютаар үүссэн худалдан авалт болон төлбөртэй холбоотойгоор гадаад валютын ханшийн эрсдэл үүсдэг. Групп нь гадаад валютын эрсдлийг гадаад валютын дериватив хэрэгслийг ашиглан хянадаггүй.

Группын гадаад валютаар үүссэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар төгрөгөөр үзүүлбэл дараах байдалтай байна:

	2018		2017	
	Өр төлбөр	Хөрөнгө	Өр төлбөр	Хөрөнгө
Гадаад валютаар илэрхийлэгдсэн	74,018,796	12,423,989	56,053,123	16,719,458
	74,018,796	12,423,989	56,053,123	16,719,458

Гадаад валютын мэдрэмжийн шинжилгээ

Группын гадаад валютын ажил гүйлгээ нь ихэнхдээ америк доллар, японы иен болон евро (хамтад нь "Гадаад валют" гэх)- оор хийгддэг. Дээрх валютуудтай харьцах Монгол төгрөгийн ханш 10 хувиар өсөх/буурах үеийн мэдрэмжийг доорхи хүснэгтэнд харуулав. Гүйцэтгэх удирдлагын түвшинд гадаад валютын эрсдлийг үнэлэхдээ дээрх 10 хувийн мэдрэмжийг ашигладаг ба энэ нь гадаад валютын ханш дахь удирдлагын үнэлж буй боломжит өөрчлөлтийг илэрхийлнэ. Энэхүү мэдрэмжийн шинжилгээ нь зөвхөн гадаад валютаар илэрхийлэгдсэн төлөгдөөгүй байгаа мөнгө болж хөрвөх санхүүгийн үзүүлэлтүүд болон тайлант хугацааны эцэс дэх гадаад валютын ханшийн 10 хувийн өөрчлөлтийн нөлөөллийг агуулдаг.

Хэрэв санхүүгийн тайлангийн өдрөөр төгрөгийн ханш дээрх гадаад валютуудын эсрэг 10%-иар чангарахад Группын татварын дараах ашиг дор хүснэгтэнд үзүүлснээр өснө. Энэхүү шинжилгээнд бусад бүх хувьсах үзүүлэлтүүдийг тогтмол гэж үзсэн.

	2018		2017	
	Татварын дараах ашигт үзүүлэх нөлөөлөл		Татварын дараах ашигт үзүүлэх нөлөөлөл	
	6,159,481	3,933,367	6,159,481	3,933,367
	6,159,481	3,933,367	6,159,481	3,933,367

Санхүүгийн тайлангийн өдрөөр бусад бүх үзүүлэлтүүд тогтмол байх үед төгрөгийн ханш бусад валютын эсрэг 10%-иар сулрахад Группын татварын дараах ашигт үзүүлэх нөлөөлөл дээрх дүнтэй тэнцүү боловч эсрэг нөлөө үзүүлнэ.

27.4 Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Групп нь үнэлгээний техникүүдийг ашиглан санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах шатлалуудыг хэрэглэдэг. Үүнд:

Зэрэглэл 1: Бодит үнэ цэнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэгслийн идэвхтэй зах зээл дээр тогтоосон үнэд үндэслэсэн байх;

Зэрэглэл 2: Бодит үнэ цэнийг хэмжихдээ ашигласан мэдээ нь зах зээл дээрээс шууд ба шууд бусаар олж авах боломжтой бусад техникүүд;

Зэрэглэл 3: Зах зээлийн мэдээлэлд үндэслэгдээгүй мэдээ ашиглан бодит үнэ цэнийг тооцоолох арга ашиглан тооцоолсон техникүүд.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

27. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

27.4 Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Групп санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй тэдгээр санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлсон.

(i) Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүд
Нэг жилээс доош хугацаанд төлөгдөх болон нөхөгдөх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнэтэйгээ ойролцоо гэж авч үзсэн.

(ii) Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрч бүртгэх үеийн зах зээлийн хүү болон Монголд байгаа ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн одоогийн хүүг харьцуулж тодорхойлдог.

Группын санхүүгийн хэрэглүүр нь зээл ба авлага болон бусад хорогдуулсан өртгөөр бүртгэсэн өр төлбөрөөс бүрдэнэ.

Удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо гэж үзэж байна.

28. Сегментийн мэдээлэл

Группын удирдлага худалдан авагчдын төрөл, байршил, борлуулалтын хүргэлт болон төрөлд үндэслэн борлуулалтын орлого болон борлуулалтын өртгийг "Дотоод борлуулалт" болон "Гадаад борлуулалт" гэсэн үйл ажиллагааны 2 сегментээр бүтээгдэхүүний төрлөөр ангилж, удирдлагын шинжилгээ болон шийдвэр гаргалтандаа ашигладаг. Дээрх 2 сегментээс өөр сегментийн мэдээллийг бэлтгэж ашигладаггүй.

Дээрх сегментээр ангилсан борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгөөс бусад орлого болон зардлыг сегментээр ангилж тайлагнадаггүй. Үүнтэй адилаар, Групп нийт хөрөнгө болон өр төлбөрийг сегментээр ангилж тайлагнадаггүй.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

28. Сегментийн мэдээлэл (үргэлжлэл)

28.1 Сегментийн орлого ба ашиг

		Сегментийн орлого		Сегментийн ашиг	
		2018	2017	2018	2017
Дотоод борлуулалт:	Сүлжмэл бүтээгдэхүүн	41,858,531	36,168,748	20,512,623	17,195,336
	Оёмол бүтээгдэхүүн	34,446,836	19,130,964	12,899,731	7,110,274
	Нэхмэл бүтээгдэхүүн	25,530,926	16,961,159	13,589,914	9,025,330
	Үйлчилгээний орлого	9,356,857	579,078	1,911,806	130,059
	Бусад	671,130	1,723,963	184,922	35,716
		111,864,280	74,563,912	49,098,996	33,496,715
Гадаад борлуулалт:	Сүлжмэл бүтээгдэхүүн	43,702,011	30,932,446	15,205,842	9,673,997
	Оёмол бүтээгдэхүүн	7,723,418	7,331,832	3,099,228	2,497,030
	Нэхмэл бүтээгдэхүүн	9,322,520	10,508,511	3,402,351	4,139,902
	Бусад	827,146	1,088,406	485,431	736,813
		61,575,095	49,861,195	22,192,852	17,047,742
		173,439,375	124,425,107	71,291,848	50,544,457
Санхүүгийн ба бусад орлого				542,045	848,816
Бусад олз ба (гарз)				(6,561,605)	(571,863)
Хүүгийн зардал				(10,521,942)	(6,496,773)
Борлуулалт ба маркетингийн зардал				(20,210,195)	(12,121,296)
Ерөнхий ба удирдлагын зардал				(11,290,196)	(8,761,080)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт				(1,523)	-
Татварын өмнөх ашиг				23,248,432	23,442,261

2018 болон 2017 оны Группын орлогын 10% ба түүнээс хувийг дангаараа бүрдүүлсэн харилцагч байгаагүй.

28.2 Газарзүйн мэдээлэл

Групп ноолууран бүтээгдэхүүнийг доорх газарзүйн байршил дахь худалдан авагчдад борлуулсан:

	Орлого бүрдүүлсэн харилцагчдаар	
	2018	2017
Монгол улс	111,864,280	74,563,912
Ази, номхон далайн орнууд	32,961,394	26,724,390
Европын орнууд	19,051,960	15,147,459
Оросын Холбооны Улс	5,234,930	4,605,257
Хойд Америкийн улсууд	4,326,811	3,358,738
Австрали, Шинэ Зеланд	-	25,351
	173,439,375	124,425,107

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

29. Капиталын эрсдлийн удирдлага

Групп тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн өгөөжийг хамгийн ихээр байлгахын тулд зээл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог. Группын нийт стратегийн бодлого 2017 оныхоос өөрчлөгдөөгүй байна.

Группын капиталын бүтэц нь цэвэр зээл (зээлээс мөнгөн хөрөнгийг хассан) ба өөрийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд өөрийн хөрөнгө нь дүрмийн сан, нөөц ба хуримтлагдсан ашгаас тус тус бүрддэг.

30. Гэрээний үүрэг

	2018	2017
Үндсэн хөрөнгө худалдан авах гэрээний үүрэг	7,268,760	150,541
	7,268,760	150,541

31. Үйл ажиллагааны түрээсийн гэрээ

31.1 Түрээслэгч

2017 болон 2018 оны 12 сарын 31-нээр Групп-д урт хугацаат үл цуцлагдах түрээсийн гэрээ байхгүй ба богино хугацаат гэрээний тухайд мэдэгдэл хүлээн авснаар цуцлах боломжтой байдаг. Тиймээс удирдлага үл цуцлагдах үйл ажиллагааны гэрээний үл цуцлагдах түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн дүн нь материаллаг бус гэж үзэж байна.

Зардлаар хүлээн зөвшөөрсөн түрээсийн төлбөр:

	2018	2017
Хамгийн бага түрээсийн төлбөр	1,488,680	1,077,970
	1,488,680	1,077,970

31.2 Түрээслүүлэгч

2017 болон 2018 оны 12 сарын 31-нээр Групп-д түрээслүүлэгчийн хувьд урт хугацаат үл цуцлагдах түрээсийн гэрээ байхгүй. Групп нэг жилийн хугацаатай үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэхээр холбоотой талтай түрээсийн гэрээ байгуулсан. Уг түрээсийн гэрээнд зааснаар түрээсийн хугацаа нь 12 сар ба түрээслэгч эсвэл түрээслүүлэгчийн аль нэг нь гэрээг цуцлах санал гаргахгүй бол гэрээ нь дахин 12 сараар сунгагдах нөхцөлтэй.

Түрээслэгч түрээсийн хугацааны эцэст барилгыг худалдан авах нөхцөл түрээсийн гэрээнд байхгүй.

2018 оны 12 сарын 31-нээрх үл цуцлагдах үйл ажиллагааны түрээсийн гэрээний ирээдүйн хамгийн бага түрээсийн төлбөр:

	2018	2017
1 жилээс ихгүй	95,455	121,336
	95,455	121,336

32. Тайлангийн дараах үйл явдал

2019 оны 2-р сарын 13-ний өдөр Группын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор нэгж хувьцаанд 6.8 төгрөг (нийт 5,304,765 мянган төгрөг)-ийн ногдол ашиг зарласан. Дээрх ногдол ашиг зарласнаас өөр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг тайлангийн дараах үйл явдал гараагүй.



ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

**СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН
ТАЛААРХ ТОДОРХОЙЛОЛТ**

2018 ОНЫ 12 САРЫН 31

Deloitte.

Делоитт Онч Аудит ХХК
15 давхар, Ай Си Си цамхаг
Жамьян гүнгийн гудамж
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар, 14240
Монгол улс

Утас: +976 70100450
+976 70120450
Факс: +976 70130450
www.deloitte.com

2019 оны 3 сарын 7

Говь ХК
Говь Хувьцаат Компанийн байр
Хан-Уул дүүрэг, 3-р хороо
Улаанбаатар хот, Монгол Улс

Тодорхойлолт

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчид танаа,

Бид Говь ХК ба түүний охин компаниудын 2018 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитдаа үндэслэн, Говь ХК-ийн тайлант жилд сонирхлын зөрчилтэй этгээдүүдтэй хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь зах зээлийн нөхцөлөөр хийгдсэн болохыг тодорхойлж байна.

Хавсралт 1-д сонирхлын зөрчилтэй этгээдүүдтэй хийсэн гүйлгээ болон үлдэгдлийг хавсаргав.



Ш.Норжинбат
Захирал, МНБ
Делоитт Онч Аудит ХХК
2019 оны 3-р сарын 7

Делоитт нь Нэгдсэн Вант улсад анх үүсгэн байгуулагдсан Делоитт Түш Тохмацу Лимитед (ДТТЛ) болон түүний гишүүн байгууллагууд, харьяа компаниудаас бүрдэнэ. ДТТЛ болон түүний гишүүн компаниуд нь бие даасан хуулийн этгээдүүд байх бөгөөд үйл ажиллагааны хувьд хараат бус байна. ДТТЛ (мөн "Делоитт Глобал" гэх) нь харилцагчдад үйлчилгээ үзүүлдэггүй. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.deloitte.com/about цахим хуудаснаас авна уу.

Делоитт нь аудит, консалтинг, санхүүгийн зөвлөх үйлчилгээ, эрсдлийн удирдлага, татвар болон холбогдох чиглэлээр төрөл бүрийн салбар дахь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Делоитт Онч ХХК болон түүний охин компаниуд нь аудит, эрсдлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө үзүүлэх мэргэжлийн үйлчилгээгээр дамжуулан Монголын харилцагчдад мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд Делоиттын олон улсын сүлжээний гишүүн байгууллага юм.

© 2019. Делоитт Онч ХХК болон харьяа компаниуд

Deloitte.

Хавсралт 1

1. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл

1.1 Холбоотой талуудын үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах үлдэгдэлтэй байна:

	2018	2017
Толгой компаниас авах дансны авлага	-	7,909
Таван Богд Трейд ХХК (өмнөх толгой компани)	-	7,909
Бусад холбоотой талаас авах дансны авлага	500	500
	500	8,409

1.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээнүүдийг Группын толгой компанитай хийсэн:

Таван Богд Трейд ХХК (өмнөх толгой компани)	2018	2017
Толгой компанид өгсөн санхүүжилт	-	11,005,592
Толгой компанид өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	-	25,010,400
Толгой компаниас авсан санхүүжилт	5,586,782	2,066,070
Толгой компаниас авсан санхүүжилтэнд төлсөн дүн	5,586,782	2,066,070
Толгой компаниас авах хүүгийн орлого	-	316,715
Толгой компаниас авсан худалдан авалт	326,281	72,722
Толгой компанид өгөх хүүгийн зардал	58,102	868
Толгой компанид хийсэн борлуулалт	3,600	17,993

2018 оны 12 сарын 31-р дуусгавар болсон тайлант жилийн хугацаанд Таван Богд Кашмир ХХК (толгой компани)- хийсэн гүйлгээ байхгүй.

Дараах ажил гүйлгээнүүдийг нэгдсэн хяналтанд байдаг бусад холбоотой талуудтай хийсэн:

	2018	2017
Холбоотой талд өгсөн санхүүжилт	3,000,314	424,888
Холбоотой талд өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	3,000,314	420,080
Холбоотой талаас авсан санхүүжилт	-	14,980,000
Холбоотой талаас авсан санхүүжилтэнд төлсөн дүн	-	14,980,000
Холбоотой талаас авах хүүгийн орлого	6,480	5,407
Холбоотой талаас авсан худалдан авалт	3,859,283	1,423,141
Холбоотой талд хийсэн борлуулалт	9,979,074	245,830
Холбоотой талаас авсан түрээсийн орлого	-	144,608
Холбоотой талд өгсөн хүүгийн зардал	-	498,660

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцлөөр хийгдсэн.

2017 оны 12 сарын 31-нээрх дансны авлага нь хангамжийн материал худалдан авахаар төлсөн урьдчилгаа төлбөртэй холбоотой. Зээлээрх худалдан авалт болон борлуулалтын нөхцөл нь 30 хоног бөгөөд худалдан авалтын гэрээний дагуу төлбөрөө төлдөг. Борлуулалт болон худалдан авалтаас үүссэн авлага болон өглөг дээр хүү тооцдоггүй. Холбоотой талуудын дансны үлдэгдэл нь барьцаагүй ба тайлант жил эсвэл өмнөх жилтэй холбоотойгоор найдваргүй эсвэл эргэлзээтэй авлагын зардал бүртгээгүй.

1.3 Үндсэн удирдлагын цалин, урамшуулал

Үндсэн удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн тайлант үеийн цалин, урамшуулал дараах байдалтай байна. Үүнд:

	2018	2017
Тайлант үеийн цалин урамшуулал	1,903,367	1,142,619

МОНГОЛ ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

ҮЙЛДВЭРИЙН ДЭРГЭДЭХ ТӨВ ДЭЛГҮҮР

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Үйлдвэрийн гудамж
Утас: 7004 8888

ГАЛЛЕРИА УЛААНБААТАР САЛБАР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Засгийн газрын ордны зүүн талд
Утас: 7004 8888

ШАНГРИ-ЛА САЛБАР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19 А, Шангри-Ла Төв,
Утас: 7004 8888

3,4-Р ХОРООЛОЛ САЛБАР

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Өргөө кино театрын урд талд, Смарт худалдааны төвийн 1 давхарт; Утас: 7004 8888

ДАРХАН ХОТ САЛБАР

Дархан хот, Шинэ Дархан Олон Улсын Худалдааны Төв
Утас: 95056656, 99376775

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ САЛБАР

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь зорчин явагчдын танхимд

ГАДААД ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

САЛБАР ДЭЛГҮҮРҮҮД

BERLIN, GERMANY

GOBI MONGOLIAN CASHMERE
Knesebeckstr.30, Berlin, Germany
www.gobicashmere.com
+49 (0)30 224 66510

HAMBURG, GERMANY

GOBI MONGOLIAN CASHMERE
Galleria Hamburg, Große Bleichen 21, 20354 Hamburg, Germany
+49(0)30 244 665 10

BRUSSELS, BELGIUM

GOBI MONGOLIAN CASHMERE
1251B chaussee de waterloo, 1180 ucclе, Brussels
+32 (0)28505944

TOKYO, JAPAN

Haneda Airport, 1 Terminal, Market place 4F

ERLIAN, INNER MONGOLIA, CHINA

Department store, 2nd floor, MinMao, Erlian
+86-18747458506

ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРҮҮД

ASIA

ANKARA, TURKEY

GOBI CASHMERE
Armada 1, 1.kat No:136, Eskişehir Yolu No:6 06560
Söğütözü
Tel: +90 (312) 219 16 01-02,
Fax: +90 (312) 219 16 03
Email: info@gobi.com.tr,
Web: www.gobi.com.tr

ISTANBUL, TURKEY

MONGOLIAN CASHMERE GOBI
HARBİYE MAHALLESİ ABDİ İPEKÇİ CADDESİ BRONZ
SOKAK NO: 7D POSTA KODU: 34367 ŞİŞLİ -İSTANBUL,
TÜRKİYE

ALMATY, KAZAKHSTAN

ГОБИ
Проспект Абылай Хана 62, Алма-Ата
+772 731 17035

ASTANA, KAZAKHSTAN

ЛЮКС КАШЕМИР
Z05P5TD Астана, проспект Мангелик ЕЛ 35, в/п 24,
магазин Zharuma
+771 727 53952

ERLIAN, INNER MONGOLIA, CHINA

No.010112 Quanjin Road Xilin street, Erlian haote, Inner
Mongolia, China

HAILAAR, CHINA

No.3-2, Dongda street, Hailar dictrict, Hulunbur city,
Inner Mongolia, China

HUHHOT, CHINA

GOBI CASHMERE
Zhongshan West Road, Hohhot

HONG KONG, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
RM 18-20, 17/F, Horizon Plaza, 2Lee Wing street, Ap Lei
Chau, Hong Kong, China
+852 2730 3911

HONG KONG, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
Man Yee building, 68 Des Voeux road Central, 2nd floor,
Shop 214, Central, Hong Kong

ULANHOT, INNER MONGOLIA, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
New century square, 42-11, Wulanhaote city, Inner
Mongolia, China

FUZHOU, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
2nd floor, Baolong Xinhua, Taijiang District Industrial
Road, Fujian Province

SHANGHAI, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
Shanghai New World Daiwan No.228 Nanjing east road,
Huangpu district.
+86 18800337221

MANZHOU, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE
China and Russian Duty Free trade zone B Hall, M203,
Manzhouli, China

SEOUL, KOREA

GOBI KOREA
Room 201, Jinsung B/D, Abujungro 4 gil 13-9,
Gangnam-gu, Seoul, Korea
+02 518 0525

SEOUL, KOREA

GOBI KOREA
843, Seolleung-ro, Gangnam-gu, Seoul, Korea
+02 518 0525

DEAGU, KOREA

GOBI KOREA
DEBEC PLAZA
333, Myeongdeok-ro, Jung-gu, Daegu, Republic of Korea

EUROPE

DÜSSELDORF, GERMANY

GOBI
Königsallee 60, 40212 Düsseldorf, Germany

NAPLES, ITALY

GOBI CASHMERE
Via nazionale Delle Puglie, 88, San Vitaliano, (NA)

NAPLES, ITALY

GOBI CASHMERE
Via Calabritto, 21 80121 Napoli

PRAGUE, CZECH

GOBI KAŠMÍR
V Jame 3, 110 00 Praha 1, Czech
+42 (0) 702 065 696
www.kasmir.cz

PRAGUE, CZECH

GOBI KAŠMÍR
MAISELOVA 5, 110 00, Praha 1, Czech
+42 (0) 722 066 591
www.kasmir.cz

SZCZECIN, POLAND

GOBI KAŠMÍR
Wyzwolenia str, 44 71-500 Szczecin, Poland

NORTH AMERICA

WASHINGTON, USA

T & U MONGOLIAN CASHMERE
1663 Wisconsin Ave NW, Washington, USA

CHICAGO, USA

TENGR CASHMERE
1650, Premium Outlet blvd Suite #981 Aurora, IL
65502-2901, USA

RUSSIA

MOSCOW, RUSSIA

МАГАЗИН ЖЕТЕМ
Москва, ул. Красного Маяка д. 2Б, ТРЦ “Пражский Пассаж”, 2 этаж, у эскапатора
+4 957 218 220

MOSCOW, RUSSIA

МАГАЗИН ЖЕТЕМ
Москва, ул.1-я Останкинская д.53, ТК “Рапира XXI” 2 этаж, пав. 35 Г
+4 956 096 818

MOSCOW, RUSSIA

МАГАЗИН ЖЕТЕМ
г. Сочи, курорт “Роза Хутор”, набережная Панорама д. 1

MOSCOW, RUSSIA

МАГАЗИН ЖЕТЕМ
Долгопрудный, Лихачовский пр-т, д. 64, ТЦ “Конфитюр” магазин, пав. 36,
+4 987 251 156

MOSCOW, RUSSIA

МАГАЗИН ЖЕТЕМ
м. Семеновская, Семеновская площадь, д. 1, ТРЦ “Семеновский” павильон 226

KHIMKI, RUSSIA

МАГАЗИН ЖЕТЕМ
ТЦ “Лига”, ш. Ленинградское, вл. 5, Химки, Московская обл., Россия, 125080

MOSCOW, RUSSIA

МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА
Москва, м. Коньково, ул.Профсоюзная, д.126, кор. 2, магазин 114, “Коньково-пассаж”
+7 495 229 3314

MOSCOW, RUSSIA

МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА
Москва, м. Теплый Стан, Новоясеневский проспект, д. 1, ТРЦ “Спектр”, 1 этаж
+7 499 550 9374

MOSCOW, RUSSIA

МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА
Москва, м. Калужская, ул. Профсоюзная, д. 61А, ТРЦ “Калужский” 1 этаж
+7 499 550 0198

MOSCOW, RUSSIA

МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА
Москва, м. Ясенево, Новоясеневский проспект, д. 11, ТРЦ “Золотой Вавилон” 2 этаж
+7 499 963 5227

MOSCOW, RUSSIA

МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА
Москва, м. Тульская, ул. Большая Тульская, д. 13, ТРЦ «Ереван Плаза» 2 этаж +7 495 926 11 57

MOSCOW, RUSSIA

МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА
Москва, м. Тверская, ул. Тверская, д. 28, ТЦ «Иван Плаза», 1 этаж
+7 499 530 15 01

MOSCOW, RUSSIA

КАШЕМИР МОНГОЛИИ
Москва, ТЦ “Золотой Вавилон”, г. Москва, м. Отрадное, ул. Декабристов, д. 12, 1 этаж
+7 499 650 8349

MOSCOW, RUSSIA

КАШЕМИР МОНГОЛИИ
Москва, м. Ленинский проспект, Ленинский проспект, д. 34/1
+7 499 135 0081

MOSCOW, RUSSIA

КАШЕМИР МОНГОЛИИ
Москва, м.Академическая, ул. Профсоюзная, д.16/10, 1 этаж (вход со стороны ул. Кедрова)
+7 499 530 15 01

MOSCOW, RUSSIA

МАГАЗИНЫ WOOLSPIRIT
WOOLSPIRIT
М. Китай-Город ул. Маросейка, 13, вход с Лубянского проезда

MOSCOW, RUSSIA

WOOLSPIRIT
Москва, м. Маяковская, 4-я Тверская-Ямская ул., д. 23, стр.1
+7 499 250 5116

MOSCOW, RUSSIA

WOOLSPIRIT
Москва, М. Пушкинская, Чеховская, Страстной бульвар, д. 12, стр. 1
+7 495 210 0274

MOSCOW, RUSSIA

WOOLSPIRIT
Москва, м. Смоленская (Арбатско-Покровская линия) Москва, Троилинский пер., дом 3, БЦ”Смоленка”, 3 этаж (на лифте) офис 303
+7 916 630 8595

MOSCOW, RUSSIA

WOOLSPIRIT
Мосъва, м. Кузнецкий Мост, Москва, Рождественка 5/7 стр. 1, 2 этаж
+7 495 625 9532

MOSCOW, RUSSIA

WOOLSPIRIT
Москва, м. Баррикадная, ул Конюшская, д. 30
+7 499 252 4277

MOSCOW, RUSSIA

GOBI
Москва, м. Чистые пруды, ул. Мясницкая, 19 “Чайный дом” 2 этаж
+7 495 784 0999

MOSCOW, RUSSIA

GOBI
Москва, м. Новокузнецкое-Третьяковское , Клементовский переулок, дом 6
+7 495 784 0999

KAZAN, TATARSTAN, RUSSIA

GOBI MONGOLIAN CASHMERE
ул.Н.Ершова, д.1А, ГРК “КОРСТОН”, Казань, Татарстан, Россия

KAZAN, TATARSTAN, RUSSIA

GOBI MONGOLIAN CASHMERE
Ул, Джержинского д.5, Казань, Респ, Татарстан, Россия

ULAN-UDE, RUSSIA

МАГАЗИНЫ КАШЕМИР ХАУС
Ул Ленина 44, Улан-Удэ, Респ, Бурятия, Россия, 670000
+7 964 414 78 88

IRKUTSK, RUSSIA

МАГАЗИНЫ КАШЕМИР ХАУС
Ул.Советская 3, Деловой Центр, остановка театр кукоп, Иркутская обл., Россия, 670000
+7 952 629 29 84

NOVOSIBIRSK, RUSSIA

МАГАЗИН “GOBI”
Новосибирск, ул. Вокзальная тагисраль 10/1 Торговый центр “ Бонанза”
+7 913 001 66 21

OMSK, RUSSIA

МАГАЗИН “GOBI”
Омск, ТВЦ”Каскад, ул.Карла Маркса 24, 1 этаж, бутик 11
+7 905 097 01 10

KHABAROVSK, RUSSIA

МАГАЗИН “GOBI”
Хабаровск, ул. Муравьева-Амурского, стр.7, 3 этаж
+8 914 158 77 06

SAINT PETERBURG, RUSSIA

МАГАЗИН “GOBI”
Невский проспект 48, Торговый дом – “Пассаж”
+7 921 321 32 68

YEKATERINBURG, RUSSIA

МАГАЗИН ЭКЗОТИЧЕСКИЙ ТРИКОТАЖ
Екатеринбург, Пр. Ленина 50, ТК “СитиЦентр”
+7 343 291 0097

YEKATERINBURG, RUSSIA

МАГАЗИН ЭКЗОТИЧЕСКИЙ ТРИКОТАЖ
Екатеринбург, ул.Халтурина 55а, ТЦ “Карнавал”, 2 эт., бутик В25
+7 343 310 1490

YEKATERINBURG, RUSSIA

МАГАЗИН ЭКЗОТИЧЕСКИЙ ТРИКОТАЖ
Екатеринбург, ул. Красноармейская, 78-а
+7 343 261 3457

YEKATERINBURG, RUSSIA

МАГАЗИН ЭКЗОТИЧЕСКИЙ ТРИКОТАЖ
Екатеринбург, ТЦ”БУМ”, ул. Вайнера 19, 2 этаж
+7 343 376 4246

GOBI

МОНГОЛИАН КАСМЕРЕ

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081
И-мэйл: info@gobi.mn